

Монгол Улс

**Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ**

© 2023, United Nations

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан.

Бүтээлийг хэсэгчлэн, эсхүл гэрэл зургийг хуулбарлах хүсэлтийг Зөвшөөрөл олгох төвд [copyright.com](http://copyright.com) цахим хуудсаар хандана.

Зохиогчийн эрх, лиценз, дагалдах эрхтэй холбоотой бусад асуулгын талаар дараах хаягаар хандана уу:

Нэгдсэн үндэстний байгууллагын хэвлэл

405 Зүүн, 42-дугаар гудамж

Нью-Йорк, Нью-Йорк 10017

Америкийн Нэгдсэн Улс

Цахим хаяг: [publications@un.org](mailto:publications@un.org)

Цахим хуудас: <https://shop.un.org>

Энэхүү ажилд томилогдсон ажилтнууд болон энэ ажилд тусгасан аливаа зураглалтай холбоотой материалын танилцуулга нь аливаа улс, нутаг дэвсгэр, хот, бүс нутаг, эсхүл түүний эрх бүхий байгууллагын эрх зүйн байдлын тухай, эсхүл түүний хил, хилийн заагийг тогтоохтой холбоотой асуудлаар Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын үзэл санааг илэрхийлээгүй болно.

Эх бичвэрийг Дашнямын Сэнгэлмаа, Нямдаагийн Отгонсайхан, Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас Ганболдын Өлзийсайхан, Адъяагийн Ариунаа нар орчуулж, хянан тохиолдуулав. Орчуулгын үнэн зөвийн талаарх асуулгыг Ганболдын Өлзийсайхан, Адъяагийн Ариунаа нар хариуцна.

Энэ бол НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас нийтлэн гаргасан НҮБ-ын хэвлэл юм.

UNCTAD/DTL/ECDE/2023/5

ISBN: 978-92-1-113091-1

eISBN: 978-92-1-002516-4

Sales no.: E.23.II.D.3

Энэхүү тайланг бэлтгэхэд БНСУ-ын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк дэмжлэг үзүүлэв.



## ТЭМДЭГЛЭЛ

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (НҮБ-ын ХХБХ)-ын Технологи, логистикийн хэлтсийн Цахим арилжаа, дижитал эдийн засгийн нэгж нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) болон цахим арилжааны хөгжлийн үр нөлөөний талаар бодлогод чиглэсэн дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэдэг. Дижитал эдийн засгийн тайлан (DER) бэлтгэх, түүнчлэн хөгжлийн төлөөх Мэдээлэл, харилцаа холбооны технологийн сэдэвчилсэн судалгааг хариуцдаг.

Тус нэгж нь хөгжлийн төлөөх МХХТ-ийн асуудлаар олон улсын яриа хэлэлцээг хөгжүүлж, хөгжиж буй орнуудын мэдээллийн эдийн засгийг хэмжих чадавхийг бэхжүүлж, холбогдох бодлого, эрх зүйн актыг боловсруулж, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж ажилладаг. Мөн цахим арилжааны эрхзүйн актын дэлхий нийтийн төлөв байдалд хяналт тавьдаг (UNCTAD Cyberlaw Tracker буюу НҮБ-ын ХХБХ-ын Кибер хууль тогтоомжийг зураглан гаргасан мөшгих тогтолцоо). 2016 оноос хойш тус нэгж нь Бүгдэд зориулсан цахим худалдаа (eTrade for all) (etradeforall.org) нэрээр олон талт оролцогчийн санаачилгыг уялдуулан зохицуулж ирсэн бөгөөд энэ нь хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй орнуудын цахим арилжааг ашиглах, үр шимийг хүртэх чадавхийг нь сайжруулах зорилготой. Энэхүү санаачилга нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас 2019 онд эхлүүлсэн Эмэгтэйчүүдэд зориулсан цахим худалдаа (T4W) хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд ялангуяа Өмгөөлөгчдийн сүлжээгээр дамжуулан илүү оролцоог хангасан дижитал эдийн засгийг хөхиүлэн дэмжихийг зорьдог. Эдгээр дижитал бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нь хөгжиж буй бүх бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жендэрийн бодлогыг илүү хүртээмжтэй хэрэгжүүлэхийн тулд чадавхийг бэхжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг.

Статистик мэдээний тухайд, БНХАУ-ын тоон мэдээлэлд Хонконгийн засаг захиргааны онцгой бүс (Хонконг, Хятад), Макаогийн засаг захиргааны онцгой бүс (Макао, Хятад), Хятадын Тайванийг тус тус оруулаагүй болно.

Компани, аж ахуйн нэгж, тэдний үйл ажиллагааны талаар эш татсаныг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал баталгаажуулсан мэтээр тайлбарлаж болохгүй.

Хүснэгтэд дараах тэмдэглэгээг ашиглав:

**Хоёр цэг (..)** нь тухайн тоон өгөгдөл байхгүй, эсхүл үүнийг тусад нь мэдээлдэггүй болохыг харуулна. Мөрийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийн тоон өгөгдөл нь байхгүй тохиолдолд хүснэгтийн мөрийг орхигдуулсан.

**Зураасан тэмдэг (-)** нь тухайн зүйл тэгтэй тэнцүү, эсхүл түүнийг ялихгүй бага хэмжээтэй байгааг илтгэнэ.

**“доллар” (US\$)** нь өөрөөр заагаагүй л бол Америкийн Нэгдсэн Улсын ам.долларыг илэрхийлнэ.

**Нарийвчилсан мэдээлэл, хувьчилсан хэмжээг** хүснэгтэд бүхэл тоо болгон тоймлосон тул нийлбэр дүнг гаргах шаардлагагүй болно.

**“MNT”** нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийг илэрхийлнэ. Энэ тайланд 1 ам.доллар = 3,404.09 төгрөг (2022 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар) гэж авч үзсэн.

## УДИРТГАЛ

2016 оны 7 дугаар сард болсон НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын Сайд нарын 14 дүгээр бага хурлаас гаргасан Бүгдэд зориулсан цахим худалдаа (eTrade for all) санаачилга нь Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр, ялангуяа Тогтвортой хөгжлийн дараах зорилгыг (ТХЗ) дэмжихэд дижитал эдийн засгийг хэрхэн ашиглах талаар практик жишээ болсон. Үүнд:

- Зорилго 5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхижуулна.
- Зорилго 8. Тогтворжсон, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлт, хүн бүрт чиглэсэн баталгаат, үр бүтээлтэй зохистой ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
- Зорилго 9. Тэсвэртэй уян хатан дэд бүтцийг бий болгох, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилт, инновацийг дэмжинэ.
- Зорилго 17. Тогтвортой хөгжлийн төлөөх Дэлхийн түншлэлийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бэхжүүлж, идэвхжүүлнэ.

Энэхүү санаачилга нь хөгжиж буй орнууд цахим арилжаанд оролцож, түүнээс ашиг хүртэх чадавхаа бэхжүүлэхэд холбогдох бодлогын долоон чиглэлийг шийдвэрлэх замаар хөгжлийн хамтын нийгэмлэгийн зүгээс одоогоор хэрэгжүүлж байгаа болон шинээр гаргаж буй арга хэмжээний хүрээг нэмэгдүүлж, мэдлэг ойлголтыг дээшлүүлж, хоорондын харилцан уялдааг дээшлүүлэхийг зорьж байна:

- Цахим арилжааны бэлэн байдлын үнэлгээ, стратеги боловсруулах
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтэц, үйлчилгээ
- Худалдааны логистик ба худалдааг хөнгөвчлөх
- Төлбөрийн шийдэл
- Хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ
- Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэх
- Санхүүжилтийн хүртээмж

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь хөгжиж буй орнуудын Засгийн газар болон гол оролцогч талуудтай хамтран уг санаачилгын нэг хэсэг болгон Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ (eT Readies) хийж дижитал эдийн засгийн чадавхийг нь сайжруулах зорилготой ажилладаг. Уг үнэлгээний хүрээнд ашиг хүртэгч орны дижитал болон цахим арилжааны экосистемд дүн шинжилгээ хийж, цахим арилжааг хөгжүүлэх боломж, сорилтод тулгуурлан дээрх долоон чиглэлээр бодлогын зөвлөмж өгдөг. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор 2020 онд Хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх механизмыг (ISM) бий болгосон. Уг механизмаар дамжуулан НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь цахим арилжааны бодлого, санаачилгыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн улсын зохицуулалтын түвшинд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлж, үндэсний чадавхийг бэхжүүлсээр байна.

Монгол Улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ нь НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас хийсэн гучин гурав дахь орны үнэлгээ болно. Энэхүү тайлан нь цахим арилжаа, дижитал эдийн засгийг хөгжүүлэхийн тулд хүчирхэг, аюулгүй, бизнест ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Цахим арилжааны боломжийг ашиглах, үр өгөөжийг хүртэхэд Засгийн газар тэргүүлэх ач холбогдол өгч, хөгжлийн түншүүд оройлон үүрэг амлалт хүлээх хэрэгтэй байдаг. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал нь Бүгдэд зориулсан цахим худалдааны түншүүд болон Улаанбаатар хот дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх, хөгжүүлэхэд цахим арилжааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээн ажиллаж байна.

Шамика Н. Сириманне  
Технологи, логистикийн газрын захирал  
НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал

## ТАЛАРХАЛ

Монгол Улсын Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээг Технологи, логистикийн газрын захирал Шамика Н.Сириманнегийн ерөнхий удирдлага дор Леонила Гугля, зөвлөх Сесиле Барайре, Мартине Жулсэйн Кидан, Родриго Сааведра, Ирис Маккули, Файсел Белайд нар багаараа бэлтгэсэн. Энэхүү үнэлгээг амжилттай гүйцэтгэхэд үндэсний зөвлөхөөр Даваагийн Цэндүрэн, Энхбаатарын Дөлгөөн нар ажиллаж, дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын багаас Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Нямдоржийн Анхбаяр, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Ганболдын Өлзийсайхан, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын зөвлөх Адъяагийн Ариунаа, атташе Батсайханы Цэцэгсайхан болон Гадаад харилцааны яамны хамт олонд үнэлгээ хийх үйл явцад техникийн дэмжлэг туслалцаа үзүүлж, тус улсад зохион байгуулсан бүх арга хэмжээг хариуцан хамтран ажилласанд гүн талархал илэрхийлье. Мөн НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра болон түүний багийн гишүүд болох Түншлэл, хөгжлийн санхүүгийн асуудал хариуцсан Алис Чен, эдийн засагч Санг Вон Лим нар дижитал эдийн засгийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрыг дэмжин ажиллаж буй сүүгаа орны хөгжлийн түншүүдтэй уялдаа холбоо тогтооход хамтран ажиллаж, туслалцаа үзүүлсэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Түүнчлэн бидэнтэй хамтран ажиллаж хувь нэмрээ оруулсан дараах хүмүүст талархаж байна. Үүнд: Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Зундуйн Гантоого, мөн газрын ахлах мэргэжилтэн Малтарын Солонго; Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан; Монгол Шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч Нанзадын Хосбаяр, Олон улсын шуудангийн газрын дарга Содчимэгийн Баттулга; Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн дарга Алтантулгын Батсайхан, Хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга Жаргалсайханы Уясах; Гаалийн ерөнхий газрын Гаалийн ахлах мэргэжилтэн Хүдэрчулууны Мөнхзул; Мэдээлэл, технологийн үндэсний парк (IT Park)-ын венч брокер Б.Цэрэнбаатар; МУИС-ийн профессор Н.Батнасан; CITI их сургуулийн Шаарийбуугийн Батдэлэг; МҮХАҮТ-ын Гишүүнчлэлийн албаны дарга Цэндсүрэнгийн Магнайбаатар; Интелмаинд (IntelMind) компанийн Гүйцэтгэх захирал Цэвээний Мэндбаяр; Мобинет ХХК-ийн Гүйцэтгэх Захирал Б.Мөнхзориг; МобиФинанс компанийн Гүйцэтгэх захирал Баатарын Үнэнбат; Хаан Банкны Олон улсын банкны газрын дарга Базарын Болортуяа, ЖДҮ-ийн газрын дарга Сонинпүрэвийн Энх-Ирээдүй, Дижитал банк, АТМ сувгийн хэлтсийн дарга Жамцын Номин-Эрдэнэ; Интерактив ХХК-ийн үүсгэн байгуулагч, Ерөнхий архитектор Б.Ууганбаяр; Ард санхүүгийн нэгдлийн Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн; ArdShop компанийн Гүйцэтгэх захирал Баяраагийн Ариунаа; Ренчинбуугийн Уянгачимэг, Аствишн ХХК; Cody компанийн Технологи хариуцсан дарга Мөнхдалайн Сайнбилэг; НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагын Үндэсний хөтөлбөрийн зохицуулагч Гунгаагийн Мөнхболор; Азийн хөгжлийн банкны Бүсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн Далайхүүгийн Өнөржаргал.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD), Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар (UNRCO) болон Бүгдэд зориулсан цахим худалдаа (eTrade for all)-ны түнш байгууллагууд болох НҮБ-ын Олон улсын Худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL), НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP), Азийн хөгжлийн банк (ADB), Дэлхийн банк (WB)-ны мэргэжилтнүүдийн зүгээс өгсөн санал, дүгнэлт өгсөн нь эцсийн тайланг сайжруулсан. Мөн НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын Технологи, логистикийн хэлтэс үнэтэй хувь нэмэр оруулсан.

Үнэлгээг Женев хотноо хийхэд Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Даваасүрэнгийн Гэрэлмаа тухай бүр дэмжлэг үзүүлж ажилласанд талархаж байна.

Цахим худалдааны бэлэн байдал (eT Ready)-ын судалганд оролцсон төрийн 35 байгууллага, 50 гаруй компани, бизнесийн холбоо, олон зуун цахим хэрэглэгч болон хоёр талын ярилцлагын үрдүн, санал, зөвлөмжийг уг үнэлгээнд тусгаж ажиллав. Улаанбаатар хотноо 2022 оны 6 дугаар сарын 21-ээс 23-ны хооронд зохион байгуулсан зорилтот бүлгийн хэлэлцүүлэг болон 2023 оны 2 дугаар сарын 7, 8-нд цахимаар зохион байгуулсан Үндэсний баталгаажуулалтын семинарт оролцсон бүх хувь хүмүүст онцгойлон талархал илэрхийлье.

Уг үнэлгээний ажлын хэвлэлийн эхийг Кил Чан, нүүр хавтсыг Магали Студер бэлтгэв. Уг баримт бичгийг гаднаас Дашнямын Сэнгэлмаа орчуулж, Нэнси Бирстекер хянан тохиолдуулав.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын зүгээс энэхүү тайланг бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн БНСУ, техникийн ба санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ЕСБХБ-нд талархал илэрхийлж байна.

# АГУУЛГА

<b>ТЭМДЭГЛЭЛ</b>	<b>II</b>
<b>УДИРТГАЛ</b>	<b>IV</b>
<b>ТАЛАРХАЛ</b>	<b>V</b>
<b>АГУУЛГА</b>	<b>VII</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ</b>	<b>VIII</b>
<b>ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ</b>	<b>X</b>
<b>ХУРААНГУЙ</b>	<b>1</b>
<b>АРГА ЗҮЙ</b>	<b>7</b>
<b>ЦАХИМ ХУДАЛДААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН</b>	<b>9</b>
1. ЦАХИМ АРИЛЖААНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ: СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ	9
2. ЦАХИМ АРИЛЖААНЫ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ	18
3. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ДЭД БҮТЭЦ БА ҮЙЛЧИЛГЭЭ	27
4. ХУДАЛДААНЫ ЛОГИСТИК БА ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ	39
5. ТӨЛБӨРИЙН ШИЙДЭЛ	50
6. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ	60
7. ЦАХИМ АРИЛЖААНЫ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ	73
8. САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН ХҮРТЭЭМЖ	86
<b>ДҮГНЭЛТ</b>	<b>97</b>
<b>УРАГШЛАХ АРГА ЗАМ БА ЗӨВЛӨМЖ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ</b>	<b>98</b>
<b>НОМ ЗҮЙ</b>	<b>121</b>
<b>ХАВСРАЛТ: НҮБ-ЫН ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАГА ХУРАЛ (UNCTAD)-ААС НИЙТЛҮҮЛСЭН ЦАХИМ ХУДАЛДААНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ</b>	<b>135</b>

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНДХДЦХХЕХ	Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (СРТА)
АНДХХ	Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АРТА)
АХБ	Азийн хөгжлийн банк (АВВ)
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага (NBFИ)
БХЗ (ДХБ)	Барааны худалдааны зөвлөл (СТG of WTO)
БЖДҮ-үүд	Бичил, жижиг, дунд үйлдвэр (MSME)
БМАТМ	Бэлэн мөнгөний автомат теллер машин (АТМ)
БМДА	Богино мэдээний (дамжуулалтын) алба (SMS)
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (USOF)
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам (MoCUD)
БЦНБНТТ	Бодит цагийн нэг бүрчилсэн нийт төлбөр тооцоо (RTGS)
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам (MoES)
ГАМС	Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (CAIS)
ГБАС	Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан систем (ASYCUDA)
ГВА	Гадаад валютын арилжаа (FX)
ГЕГ	Гаалийн ерөнхий газар (MCGA)
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ALAMGC)
ГХЯ	Гадаад харилцааны яам (MoFA)
ДБ	Дэлхийн Банк (WB)
ДГБ	Дэлхийн гаалийн байгууллага (WCO)
ДГХБО	Далайд гарцгүй хөгжиж буй орон (LLDC)
ДЭЗТХ	Дижитал, эдийн засгийн тухай хэлэлцээр (DEA)
ДЭЗТХ	Дижитал, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (DEPA)
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага (WTO)
ДХБ-МТХ	Мэдээллийн технологийн хэлэлцээр (ITA of WTO)
ДХБ-ОУХТ	Олон улсын худалдааны төв (WTO - ITC)
ДХБ-ын ҮХЕХ	Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (WTO - GATS)
ДХБ-ЭЗТЗТ	ДХБ-ын эрх зүйн талаар зөвлөх төв (ACWL)
ДШХ	Дэлхийн шуудан холбоо (UPU)
ЕОМХ	Европ-Орос-Монгол-Хятад (кабель систем)
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)
ЖДҮ-үүд	Жижиг, дунд үйлдвэр (SMEs)
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам (MoRTD)
КЯТҮБ	Компьютерийн яаралтай тусламж үзүүлэх баг (CERT)
МБ	Монгол Улсын Төв банк (МонголБанк/ВОМ)
МУТ	Монгол Улсын мөнгөн тэмдэгт – төгрөг (MNT)
ХХЗХ	(Монгол Улсын) Харилцаа холбооны зохицуулах хороо (CRC)
МХБ	Монголын хөрөнгийн бирж (MSE)
МЦОШ	Маргааныг цахим орчинд шийдвэрлэх (ODR)
НБХО	Нэн буурай хөгжилтэй орон (LDC)
НТДБ	Нийтийн түлхүүрийн дэд бүтэц (PKI)
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБ-АНДЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон Далайн бүс нутгийн Эдийн засаг-Нийгмийн комисс (UN-ESCAP)
НҮБ-АҮХБ	НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (UNIDO)
НҮБ-БШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)
НҮБ-ОУХЭЗК	НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрх зүйн комисс (UNCITRAL)
НҮБ-СЗГ	НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар (UN-RCO)
НҮБ-ТХХАХ	НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (UNSDCF)



НҮБХС	НҮБ-ын Олон улсын хүүхдийн сан (UNICEF)
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)
НҮБХХБХ	НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)
ОУБХ-СЦХН	Олон Улсын Банк хоорондын Санхүүгийн цахилгаан холбооны нийгэмлэг (SWIFT)
ОУСБ	Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)
ОУСЭХА	Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (IRENA)
ОУХХХ	Олон улсын худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP)
ОУХХЭТС	Олон улсын хэмжээнд хуулийн этгээд таниулагчийн сан (GLEIF)
ОУЦХБ	Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)
ОУШГГ	Олон улсын шуудангийн гаалийн газар (IPCH)
ПОС	ПОС терминал буюу цахим мэдээ үүсгэгч (POS)
САУБДЭЗХ	Сингапур ба Австрали улсуудын Дижитал эдийн засгийн хэлэлцээр (SADEA)
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо (FRC)
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар (MASM)
СЯ	Сангийн яам (MoF)
ТАБН-ЭЗХА	Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC)
ТББ	Төрийн бус байгууллага (NGO)
ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (TVET)
ТС	Тус улсад хэрэгжүүлэх Түншлэлийн стратеги (CPS)
ТХБК	Түргэн хариулт бүхий код (QR code)
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл (PPP)
ҮСХ	Үндэсний статистикийн хороо (NSO)
ҮЦГТ	Үндэсний цахим гүйлгээний төв (NETC)
ХБХТ	Худалдааны бодлогыг хянан үзэх (WTO-TPR)
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам (MoJHA)
ХС	Хамтарсан санаачилга (JSI)
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг (MoU)
ХОУ	Хиймэл оюун ухаан (AI)
ХӨТШ	Хэрэглэгчийн өрөөсгөл тоон шугам (ADSL)
ХПИ	Хэрэглээний програмчлалын интерфэйс (API)
ХТХОХ	Хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр (BIT)
ХХБ	Худалдаа, хөгжлийн банк (TDBM)
ХХМТБҮА	Харилцагчийн хувийн мэдээллийг таньж, баталгаажуулах үйл ажиллагаа (KYC)
ХЭТ	Хуулийн этгээд таниулагч (LEI)
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам (MDDC)
ЦТХ	Цахим түншлэлийн хэлэлцээр (EPA)
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (AFCCP)

# ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

## ЗУРАГ

1. Монгол Улсад цахим арилжааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлс .....	6
2. Онлайнаар ямар нэгэн зүйл худалдаж авахын тулд гар утас, эсхүл интернэт ашигласан 15-аас дээш насны хүмүүсийн эзлэх хувь, сонгосон Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (LLDCs)-аар, 2017 ба 2021 он .....	9
3. Цахим худалдан авалтын үндсэн шинж (дотоодын/олон улсын) .....	10
4. Онлайн худалдан авалтын давтамж .....	10
5. Онлайнаар хамгийн их худалдан авдаг бүтээгдэхүүн .....	11
6. Онлайнаар хамгийн их худалдан авсан үйлчилгээ .....	11
7. Онлайн худалдан авалт хийхэд илүүд үздэг арга .....	12
8. Онлайн худалдан авалт хийхгүй байх шалтгаан .....	12
9. "Дижитал болох" шалтгаан (онлайнаар борлуулах) .....	13
10. Цахим арилжааны борлуулалтын үндсэн шинж (дотоодын/олон улсын).....	13
11. Онлайнаар борлуулалт хийхэд илүүд үздэг арга .....	14
12. Цахим арилжааны шийдэлд хөрөнгө оруулахгүй байх шалтгаан.....	15
13. МХХТ-ийн үйлчилгээ үзүүлж буй идэвхтэй бизнес эрхлэгчдийн тоо .....	16
14. Борлуулалтын хэмжээнд COVID-19 цар тахлын нөлөө .....	17
15. Монгол Улсын цахим арилжааны үндэсний ажлын хэсэг.....	25
16. Хэрэглэж буй ухаалаг төхөөрөмжийн тоо .....	31
17. Интернэт хэрэглэгчдийн тоо, бүс ба нийслэл, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар .....	33
18. Гэрээт суурин интернэт идэвхтэй хэрэглэгчийн тоо, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар.....	34
19. Та интернэт холболтын төлбөрийг (ADSL, гар утас) хэрхэн үнэлдэг вэ? .....	35
20. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн домэйн ба тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа.....	36
21. Байнгын хиймэл дагуулын хөдөлгөөнт хэрэглэгч ба хиймэл дагуулын интернэт хэрэглэгч, бүс нутгаар, 2021 он .....	38
22. Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны бүрэлдэхүүн .....	39
23. НҮБ-аас Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаар дэлхийн хэмжээнд явуулсан судалгаагаар Монгол Улсын худалдааг хөнгөвчилж буй ажлын гүйцэтгэл .....	40
24. Худалдааг хөнгөвчлөх, логистикийн тэргүүлэх чиглэл (%).....	44
25. Та цахимаар бараа худалдан авахдаа хүргэлтийн нөхцлөөс юуг чухалчлан үздэг вэ?.....	47
26. Та ямар шалтгааны улмаас цахим арилжаа хийдэг вэ?.....	47
27. Та бараагаа ямар нөхцлөөр хүлээн авахыг хүсдэг вэ? .....	47
28. Төлбөрийн шийдэлтэй холбоотой энэ тэргүүнд хийх үйл ажиллагаа .....	52
29. Хэрэглэгчийн илүүд үздэг төлбөрийн хэрэгсэл .....	56
30. Үндэсний де бит болон кредит картын хэрэглээнд орсон эргэлт, 2019-2021 .....	57
31. Цахим арилжаанд оролцохдоо төлбөрийн картаар хийсэн гүйлгээ, мянгаар.....	57
32. Цахим арилжааны хууль тогтоомжийн талаарх төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын ойлголт мэдлэг.....	60
33. Цахим арилжааны эрх зүйн зохицуулалтын тэргүүлэх асуудал .....	62
34. Асуудал гарвал (барааг буцаах, мөнгөө буцаан авах хүсэлт гаргах гэх мэт) хэрхэн шийдэх вэ? .....	65
35. Онлайн орчинд худалдан авахад тулгардаг бэрхшээл .....	66
36. Онлайнаар худалдан авалт хийх веб хуудас сонгоход ямар шалгуур чухал вэ? .....	74
37. Та онлайнаар худалдан авалт хийх захиалга хийхээсээ өмнө ямар мэдээллийг хамгийн их шалгадаг вэ?.....	75
38. Их, дээд сургууль, коллежийн төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр нь .....	76
39. 15-24 насны өсвөр үе, залуучуудад зориулсан МХХТ-ийн ур чадвар, Хүйсээр.....	78
40. Цахим арилжааны шийдлүүдэд зориулсан санхүүжилтийн хувилбар.....	83
41. Цахим арилжааны ур чадварыг хөгжүүлэх тэргүүлэх үйл ажиллагаа .....	85
42. Монголын гарааны бизнес салбараар (давхардсан тоогоор), 2022 он .....	87
43. Монголын гарааны бизнес эрхлэгч нарт оруулсан анхны болон явцын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр 2022 он .....	89
44. Санхүүжилтийн хүртээмжтэй холбоотой тэргүүлэх үйл ажиллагаа (%).....	90
45. Гуравдагч талын санхүүжилт хайхгүй байх шалтгаан .....	91
46. Технологийн гарааны бизнест хамгийн их шаардлагатай санхүүжилтийн арга хэмжээ .....	92

## ХҮСНЭГТ

1. Цахим арилжаатай холбоотой зорилго, арга хэмжээг нэгтгэсэн Монгол Улсын үндэсний гол стратеги .....	18
2. Монгол Улсын Засгийн газрын зарим цахим тогтолцоо .....	20
3. Дижитал төхөөрөмж хэрэглэдэг өрхийн хувь хэмжээ (хүн амд эзлэх хувь, %) .....	31
4. Гол үзүүлэлтийн зах зээлийн статистик .....	33
5. Монгол Улсын 2022-2026 он хүртэлх үндэсний төлбөрийн стратеги: Өндөр түвшний зорилго, зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлт .....	51
6. 2022 оны ес 9 дүгээр сарын байдлаар, Монгол Улсын нэгдэн орсон цахим арилжаатай холбоотой олон улсын гэрээ .....	61
7. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) ур чадварын төрөл ба .....	73

## ШИГТГЭЭ

1. Косен Техник мэргэжлийн коллеж .....	77
2. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжсэн санаачилгууд .....	80
3. Мэдээлэл, технологийн үндэсний парк, MONJA, KITE MONGOLIA хэмээх гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах, хурдасгуур хөтөлбөрүүд .....	82
4. АНД Глобал ба СуперАп (AND GLOBAL ба SUPERUP) хэмээх программ хангамж .....	87
5. Дэлхийн гарааны бизнесийн цом: Монгол улс (STARTUP WORLD CUP MONGOLIA) .....	95
6. Туслалцаа үзүүлэх нь (LENDANAND) .....	95



# ХУРААНГУЙ

## Танилцуулга

Монгол Улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн нөөц баялагтай, шилжилтийн<sup>1</sup> үеийн жижиг эдийн засагтай, БНХАУ болон ОХУ-тай хиллэдэг. Тус улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын хувьд нягтрал багатай, хот ба хөдөөгийн ялгаатай нөхцөл байдалтай тулгараад буй. Нийт 3.41 сая хүн амтай, үүнээс 48 хувь нь нийслэл Улаанбаатар хотод<sup>2</sup> амьдардаг.

ЕСБХБ-ны мэдээгээр Монгол Улсын эдийн засгийн жилийн өсөлт нь гол төлөв уул уурхайн салбараас хамаарч 2010-2019 онд 7.8 хувь байсан бөгөөд энэхүү ойр ойрхон давтагддаг “гэнэтийн өсөлт ба тэсрэлтийн мөчлөг”<sup>3</sup> нь эдийн засгийг тогтворгүй байдалд хүргэхэд нөлөөлдөг. Тус улсын эдийн засаг, экспортод олборлох үйлдвэрлэлийн салбар (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алтны олборлолт) давамгайлдаг. Тус улс нь уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг хэрэгжүүлсээр иржээ. Дэлхий нийтийг хамарсан хямралын үед БНХАУ-ын зүгээс Ковид цар тахлын хязгаарлалт хийж хилээ хаасан нь Монгол Улсын экспортын хэмжээ буурахад ихээхэн нөлөөлсөн. 2022 оны 12 дугаар сарын байдлаар ДНБ дунджаар 4.8 хувь байв<sup>4</sup>.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээгээр 2021 онд Монгол Улсын экспортод эрдэс бүтээгдэхүүн (нийт экспортын 81.28 хувь) ба үнэт металл (11.09 хувь) томоохон байр суурь эзэлж байсан бол нэхмэл, сүлжмэл, даавуун эдлэл (4 хувь), машин механизм, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг бусад бараа бүтээгдэхүүн (1 хувиас бага) бага хувь эзэлж байжээ. 2021 онд үнийн дүнгээр нь авч үзвэл, Монголын экспортын 88.4 хувийг Хятад улс, 10.1 хувийг Швейцарь улс, 1.3 хувийг ОХУ түс түс эзэлжээ. Импортын барааг ихэвчлэн Хятад (46.2 хувь), ОХУ (35.9 хувь), Япон (8.3 хувь) улсаас оруулж иржээ.

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д элсэхдээ ерөнхийдөө эдийн засгийн дэвшилтэт нээлттэй бодлогыг эхлүүлэх, чингэхдээ голчлон барааны худалдааны салбарт хэрэгжүүлсэн байдаг. Харин үйлчилгээний худалдааны салбарт харьцангуй бага үүрэг амлалт хүлээж, зөвхөн зургаан салбарыг хэсэгчсэн либералчилсан. Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх<sup>5</sup> тодорхой алхмыг сүүлийн үед хийж байна. Тухайлбал цахим шилжилтэд чухал ач холбогдол өгч, үйлдвэрлэлийн үйл явц болон төрийн санхүүгийн үйлчилгээ (түүний дотор төлбөр, тооцоо)-г дижитал болгох болсноор Засгийн газрын байгууллагаас гаргасан сүүлийн үеийн бодлого, стратегийн олон баримт бичиг болон хууль тогтоомжид энэ санаа уялдан түсчээ. Эдгээр хүчин чармайлтыг хөгжлийн түншүүд, жишээлбэл Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ), Азийн хөгжлийн банк (АХБ), Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC), Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ), Япон (JICA), БНСУ (KOICA), Швейцарь (SECO), Европын холбоо (ЕХ), Дэлхийн банкны групп (ДБ) болон бусад байгууллага түс улсад хэд хэдэн чухал төсөл хэрэгжүүлэх замаар дэмжиж байна.

<sup>1</sup> НҮБ, 'Монгол дахь НҮБ-ын тухай', Монгол дахь НҮБ, 2022 оны 10-р сарын 15-нд хандсан, <https://mongolia.un.org/en/about/about-the-un>; ДББ, 'Дэлхийн Банкны тухайн Улсад буй бүлэг ба Зээл олгох бүлгүүд, Улс орнуудын ангилал', Дэлхийн Банкны тухай Мэдээлэл олгох цэг, 2022 он <https://datahelpdesk.worldbank.org/knowledgebase/articles/906519-world-bank-co>

<sup>2</sup> ҮСХ, 'Хүн амын жилийн тайлан, ХА-3', Үндэсний статистикийн хороо, 2022 оны 3-р сарын 15, [https://www2.1212.mn/tablesdata1212.aspx?tbl\\_id=dt\\_nso\\_0300\\_004v1&ln=en](https://www2.1212.mn/tablesdata1212.aspx?tbl_id=dt_nso_0300_004v1&ln=en)

<sup>3</sup> ЕСБХБ, 'Монгол орны хувьд баримтлах стратеги 2022-2027', 'Өмнөх стратегийн хэрэгжилт (2017-2021)', <https://www.ebrd.com/documents/strategy-and-policy-coordination/mongolia-strategy.pdf>

<sup>4</sup> ҮСХ, Дотоодын нийт бүтээгдэхүүн, <https://1212.mn/>

<sup>5</sup> 'Монгол Улсын нэгдэн орох тухай, СХХХIV хуваарь – Монгол Улс, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн (GATS) тодорхой үүрэг амлалтын жагсаалт - II Бүлэг" (Дэлхийн худалдааны байгууллага, 1996 оны 6 сарын 27). "Монгол Улс, Япон Улстай байгуулсан "Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр"-т Үйлчилгээний салбарын чиглэлээр илүү өргөн хүрээтэй үүрэг амлалт авсан байгаа ба, үүнд: Монгол улс нь боловсролын үйлчилгээ; байгаль орчны үйлчилгээ; эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ; тээврийн үйлчилгээ; амралт, соёл урлаг, спортын үйлчилгээний салбарт үүрэг, амлалтууд авчээ.

Монгол Улсад хийж буй цахим шилжилт нь цахим арилжааг дотооддоо болон хил дамнан хөгжүүлэхэд дэм болох юм. Энэхүү үнэлгээ нь Монголын дижитал эдийн засгийн өнөөгийн сорилт, боломжийг судалж, улмаар Засгийн газар болон хөгжлийн түншүүд худалдааг цахимжуулснаар хүртэх өгөөжийг хэрхэн нэмэгдүүлж болох талаар бодлогын зөвлөмжийг санал болгож байгаа юм. Гол дүгнэлтийг товчлон танилцуулав.

### **Цахим арилжааны бэлэн байдлын үнэлгээ ба цахим арилжааны стратеги боловсруулах**

Монгол Улс цахим арилжааны хөгжлийн эхний шатандаа явж байна. Тус улс дотооддоо цахим арилжааг дэмжих экосистемийг бий болгох чиглэлээр ихээхэн ахиц дэвшил гаргасан. Цахим арилжааны үндэсний зах зээлийн эзлэх хэмжээг найдвартайгаар тооцоолж чадаагүй боловч өмнө хийсэн судалгаа, оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт, Цахим худалдааны бэлэн байдлын (eT Ready) судалгаа зэрэг эх сурвалжаас харахад цахим арилжаанд хувийн хэвшил, хэрэглэгчдийн оролцоо тодорхой түвшинд байгааг батлан харуулж байгаа юм. Монгол Улсын Засгийн газар бие даасан цахим арилжааны стратеги байхгүй бөгөөд цахим арилжаа нь үндэсний эсхүл худалдааны салбарын хөгжлийн стратегид нэгдмэл байдлаар бараг тусгагдаагүй гэж хэлж болно. Байгууллагын зохион байгуулалтын хувьд цахим арилжааны хөгжлийн асуудлыг Гадаад харилцааны яам (ГХЯ) одоогоор түүчээлэн ажиллаж байна. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад гол тоглогчдын хэрэгжүүлж буй янз бүрийн санаачилгыг хооронд нь уялдуулах, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлэхэд яам хоорондын уялдаа зохицуулалт, түүнчлэн төр ба хувийн хэвшил хоорондын яриа хэлцээ маш их хэрэгтэй байна.

### **Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтэц ба үйлчилгээ**

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц нь харьцангуй сайн хөгжсөн. Монгол Улсад интернэт болон мэдээлэл, харилцаа холбооны төхөөрөмжийн хүртээмж нь ерөнхий хөгжлийн буюу газарзүйн хуваагдлын хэв маягийг дагасан байдаг бөгөөд Улаанбаатар хот хамгийн сайн холболттой бол зарим хөдөө орон нутагт интернэтын холболт тааруухан тул хүндрэл үүсдэг. Мобайл буюу хөдөлгөөнт холбооны (суурин бус) өргөн зурвастай улсын хувьд Монгол Улс нь интернэтэд холбогдох, тэр дундаа цахим орчинд худалдан авалт хийх, борлуулах, төлбөр тооцоо хийх зориулалттай ухаалаг гар утсыг эзэмших, ашиглах чадвар өндөртэй байдаг. Холболтын хурд, чанар нь бүс нутгийн болон олон улсын жишиг үзүүлэлттэй харьцуулахад бага хэвээр байгаа тул интернэт хэрэглэгчдийн хувьд цахим орчинд ажиллах түршлага хараахан жигдрээгүй. Салбарын динамик өөрчлөлт ба үндэсний зарим бодлого нь тус салбарт хувийн хөрөнгө оруулалт хийхийг хөхиүлэн дэмжих талаар сайн тусгаагүй бол, төсвийн хөрөнгө оруулалтын орон зай хязгаарлагдмал байдаг. Мэдээлэл, харилцаа холбоог хөгжүүлэх зарим арга хэмжээ, жишээлбэл 5G буюу 5 дахь үеийн сүлжээний архитектур нь цахим шилжилтийн тэргүүлэх чиглэлээс ялгаатай бөгөөд цахим худалдааг ирээдүйд өргөжүүлэн хөгжүүлэхээс илүүтэйгээр цахим засаглалын санаачилгыг хэрэгжүүлэхэд илүү чиглэсэн байна.

### **Худалдааны логистик ба худалдааг хөнгөвчлөх**

Монгол Улсын далайд гарцгүй байдлыг далайн худалдааны замналд нэвтрэхийн тулд Хятад ба ОХУ-аас стратегийн хувьд хамааралтай байдлаар тайлбарладаг. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээ их тул дотоодын болон хил дамнан логистикийн салбар нь дэд бүтцийн насжилт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын холбогдох төсөлд зориулах төсөв хязгаарлагдмал байгаа зэргээс шалтгаалан хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Энэ нь Монголын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын транзит коридор хөгжүүлэх хэтийн төлөвт мөн нөлөөлдөг. Үүнээс гадна гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа нь удаан, хугацаа шаарддаг, хүндрэл ихтэй байдаг. Цахим арилжаагаар худалдаалж буй бараанд гаалийн бүрдүүлэлт тогтмол хийх ёстой байдаг. Зарим хөгжлийн түншийн санаачилга, дэмжлэгтэйгээр Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр (ТФА) хэрэгжих шатандаа байна. Хэлэлцээрт дурдсан арга хэмжээний 80% орчим хувь нь хэрэгжсэн талаар Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д мэдэгдсэн боловч дотоодын хэмжээнд тусгайлан хийсэн үнэлгээгээр эдгээр үүрэг, амлалтын заримыг нь дагаж мөрдөн ажиллахад үе үе доголдол гарч байгааг дурдсан байна.

Монгол Улсын дотоод болон хил дамнасан тээвэрлэлтийг ихэвчлэн төмөр зам, эсхүл авто замаар хийдэг бөгөөд ачааны багахан хувийг (үндсэндээ хил дамнасан) агаарын тээврээр тээвэрлэдэг. Байнгын ахиц дэвшлийн зэрэгцээ хатуу хучилттай болон сайжруулсан авто замын эзлэх хувь хязгаарлагдмал хэвээр, зарим газар, ялангуяа улсын баруун хойд хэсэгт эдгээр үйлчилгээ дутмаг. Энэ салбар нь гадаадын мөн төрлийн үйлчилгээ үзүүлэгчдэд нээлттэй бус тул олон улсын өрсөлдөөн байхгүйн улмаас тээврийн үйлчилгээний зах зээлийн гүйцэтгэл тааруухан байдаг. Жижиг илгээмж, түүний дотор цахим арилжаагаар гүйлгээ хийж худалдан авсан илгээмжийн зардал, хурд, хугацаанд нь хүргэх, найдвартай байдал, аюулгүй байдал зэргийг харгалзан үзэж ихэвчлэн авто замаар тээвэрлэдэг. Тусгай зөвшөөрөлтэй 145 үйлчилгээ эрхлэгч шуудангийн хүргэлт хийдэг тул зах зээл ханасан боловч, ихэнх нь зөвхөн Улаанбаатар болон томоохон хотуудын хүрээнд хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд “Монгол шуудан” ХК нь бусад алслагдсан, хүргэлт хийх боломж тааруухан газарт хүрч ажилладаг. Хаягжуулалтын нэгдсэн систем байхгүй тул хүргэлт хийх нь амаргүй.

Монгол Улс худалдааг хөнгөвчлөх, цаасгүй худалдаатай холбоотой хилийн бүрдүүлэлт, тээвэр, транзит, логистикийн асуудлыг шийдвэрлэх олон тооны олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон байдаг, тухайлбал Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (СРТА, 2016)-т нэгдсэн. Түүнчлэн Монгол Улсын Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрт худалдааг хөнгөвчлөх тухай заалт байдаг.

### Төлбөрийн шийдэл

КОВИД-19 цар тахлын улмаас болон банкинд данс эзэмшиж буй хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх үүднээс олон шат дараатай алхмыг авч хэрэгжүүлж, мөн Засгийн газраас нийгмийн халамжийн тэтгэмжийг цахим төлбөр тооцоо ашиглан хуваарилан түгээх болсонтой холбогдуулан, тус улсад дотоодын цахим төлбөр, тооцооны хэрэглээний түвшин өндөр байна. Бүх банк үндэсний хэмжээнд цахим болон мобайл банкны үйлчилгээний аль алийг нь санал болгож, эдгээр өөр өөр төрлийн төлбөрийн карт, цахим түрийвч зэрэг нь харилцан өөр хоорондоо уялдаагүй боловч түгээмэл хэрэглэдэг. QR код бүхий төлбөрийн хэрэгсэлийг нийтлэг хэрэглэж байна. Бага үнийн дүн бүхий цахим төлбөр тооцоо, төлбөрийн картын гүйлгээг ихэвчлэн 24 цагийн дотор (тухайн цагт гүйлгээг хийж дуусгах буюу RTGS) гүйцэтгэдэг. Арилжааны банкууд болон финтекүүд (fintech буюу санхүүгийн технологи) хэрэглээний програмчлалын интерфэйсийг (API) өргөн хүрээнд ашиглаж байна. Гэсэн хэдий ч тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар Монголбанкнаас хэрэгжүүлэх хөтөлбөрийн жагсаалтад тусгаагүй байна. Хил дамнасан цахим төлбөрийн хураамж өндөр хэвээр байгаа бөгөөд үндсэн гүйлгээг төлбөрөөс тусгаарлах үйл явц жигд бус байна.

Монголын зах зээлд хил дамнасан цахим хэтэвчний (e-wallet) цөөн тооны үйлчилгээ үзүүлэгч байдаг бөгөөд санхүүгийн байгууллагууд SWIFT-ээр буюу Олон улсын банк хоорондын санхүүгийн цахилгаан холбооны нийгэмлэээр дамжуулан хэд хэдэн валютаар гадагшаа болон дотоод руу орж ирж буй мөнгөн гүйвүүлга хийх боломжтой байдаг бөгөөд нийт 18 орны корреспондент банктай холбогдон ажилладаг ба заримдаа MoneyGram, Western Union, Contact болон PayEasy зэрэг гарцаар дамжуулан мөнгөн гүйвүүлга хийдэг. Зарим банкны карт эзэмшигчдэд хил дамнасан төлбөрийг хязгаарлагдмал сонголттой хийх боломжтой олгодог жишээлбэл худалдаа эрхлэгч гэж бүртгүүлсэн бол орж ирж буй төлбөрийг хүлээн авах (UnionPay) эсхүл зарим карт эзэмшигчид рүү арилжааны шилжүүлгийг (Visa B2B холболтоор дамжуулан) илүү хурдан холбох зэрэг болно.

## Хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ

Монгол Улсын хууль тогтоомжид цахим арилжаатай холбоотой олон тооны дүрэм, журам байдаг бөгөөд үүнд цахим гүйлгээ, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хувийн нууцлал, арилжааны нууцыг хамгаалах, кибер орчны аюулгүй байдал, кибер орчинд үйлдсэн гэмт хэрэг, засгийн газрын нээлттэй мэдээлэл зэрэг хамаардаг. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Кибер аюулгүй байдлын тухай хуулийг шинээр баталж, 2021 онд Цахим гарын үсгийн тухай хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Монгол Улсын цахим арилжаанд хамаарах дүрэм журмыг олон улсын стандартад хэсэгчлэн тулгуурлаж боловсруулсан байдгийг судалгаанд оролцогч талууд бүрэн мэддэггүй, хэрэгжилт хангалтгүй, зарим тохиолдолд өөр хоорондоо зөрчилддөг. Монгол Улс нь Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (СРТА, 2016) болон Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн үндэстний байгууллагын конвенц (2005) зэрэг дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг цахим арилжааны дүрэм, худалдааны гүйлгээтэй холбоотой олон улсын гол хэлэлцээрт саяхан нэгджээ. Монгол Улсын Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр (цаашид “чөлөөт худалдааны хэлэлцээр” гэх) -т цахим арилжааны бүлэг оруулсан байдаг.

Монгол Улс ДХБ-ын Цахим арилжааны тухай Хамтарсан санаачилгад нэгдэж, олон улсын дүрмийг боловсруулахад оролцож байгаа (хэдийгээр өнөөг хүртэл ямар нэгэн санал ирүүлээгүй байгаа ч) бөгөөд мөн ДХБ-ын Цахим арилжааны 1998 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээний ажилд оролцдог.

## Цахим арилжааны үр чадварын хөгжүүлэлт

Орчин үеийн цахим арилжааны үр чадвар нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT) болон нийгэм, бизнесийн манлайллын үр чадвар, хэрэглэгчийн дижитал үр чадвар, мөн хэл шинжлэлийн мэдлэг зэргээс бүрэлдэн тогтдог бөгөөд эдгээр нь аж ахуйн нэгж, хэрэглэгчдийг цахим орчинд төлөвшин хөгжихөд зайлшгүй шаардлагатай байдаг. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын мэдээгээр Монголчууд мэдээлэл, харилцаа холбооны технологийн анхан шатны болон стандарт түвшний үр чадварын хувьд дунд зэрэг байна. 2021 онд нийт хүн амын ойролцоогоор 31% нь үндсэн, 22% нь стандарт, 3% хувь нь ахисан түвшний мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр чадвартай болохыг тус тус тооцоолон гаргажээ<sup>6</sup>. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр чадварыг хөгжүүлэх талаар ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдаг.

Гэсэн хэдий ч дунд сургуулиас эхлээд мэргэжлийн сургалт болон их, дээд сургуульд хамрагдах хүртэл, тусгайлан зориулсан ангиудад нь уг чадвар эзэмших цаг хугацааг бага ногдуулж, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж ба интернэтийн хүртээмж хангалтгүй, багш нарын үр чадвар дутмаг зэрэг байдал нь үр чадвар эзэмших сургалтын боломжийг хязгаарлаж, ялангуяа Улаанбаатар хотоос бусад хөдөө орон нутагт илүү хязгаарлагдмал нөхцөл байдалтай байна.

Нээлттэй мэдээллийн эх сурвалжаас харахад, мэдээллийн технологийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж буй төгсөгчдийн тоо бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад бага байна. Энэ салбарын хөдөлмөр эрхлэлтийн хувьд эрэгтэйчүүдээс цөөн тооны эмэгтэйчүүд байдаг. Онол, практик дадлага, харилцаа холбоо, манлайлах үр чадвар, бүтээлч байдлыг хослуулсан дунд шатны инженерүүдийг бэлтгэхийн тулд ахлах сургууль ба их сургуулийн сургалтын хөтөлбөрийг холбосон шинэлэг арга барилыг зохих хэмжээнд түршиж байна.

<sup>6</sup>Олон Улсын цахилгаан холбооны байгууллага, <https://www.itu.int/itu-d/reports/statistics/2021/11/15/ict-skills/>



Төрийн (Мэдээлэл, технологийн үндэсний парк) болон хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийн санал болгож буй бойжуулах хөтөлбөр хангалттай бус. Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах төв болон хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэгчийн зүгээс заримдаа олон нийт, бизнес эрхлэгчид эсвэл хөдөө орон нутгийн ахлах сургуулийн сурагчид зэрэг тодорхой бүлэгт чиглэсэн дижитал чадавхийг бэхжүүлэх сургалт, үйл ажиллагааг явуулдаг. Саяхан эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөөгийн хүн ам, өндөр настнуудад зориулан дижитал шийдлийн хүртээмжийг сайжруулах талаар зарим нэг хүчин чармайлт гаргасан байна.

### Санхүүжилтийн хүртээмж

Монголын хувийн хэвшлийн салбарын технологийн гарааны бизнес эрхлэгчдийн (startups) ихэнх нь хувийн хадгаламж эсхүл зээлийн эх үүсвэрийг ашиглах, эсхүл корпорацийн бүлэгт гишүүнээр элсэх замаар санхүүжилт олж авах боломжтойгоос гадна хожим нь өөрсдийн бизнесийн үйл ажиллагааны орлогоос өөрсдийгөө санхүүжүүлдэг. Ихэнх банк, санхүүгийн зээлдүүлэгч байгууллага (institutional lenders) эсхүл баталгаа гаргагч (grantors) нь тухайн байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг нотлох баримт бичгийг шаарддаг тул анхны санхүүжилтийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэх боломж хязгаарлагдмал учраас гарааны бизнес эрхлэгчид хурдасгах үе шатнаас өмнө орж ирэх магадлал ховор байдаг.

Монголын дижитал болон технологийн инновацийн үйл ажиллагаанд оролцож буй гарааны бизнес эрхлэгчдэд олгох санхүүжилтийн сонголтууд өөр өөр байдаг. Засгийн газрын санхүүжилт ба дэмжлэгийг гарааны бизнес эрхлэгч нарт шууд эсхүл түүнтэй нь холбоотой технологийн болон шинжлэх ухааны салбарын түнш болон эрдэм шинжилгээний байгууллагаар дамжуулан олгохдоо буцалтгүй тусламж, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх, түүнчлэн татварын хөнгөлөлт, олон улсын үзэсгэлэн, яармаг зэрэг олон нийтийн сурталчилгааны үйл ажиллагаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх, оффисын талбай, нийтийн аж ахуйн үйлчилгээгээр хангах зэрэг хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг байна. Инновацийн тухай хууль (2009 он)-д зарим санхүүжилтийн хувилбарыг зөвшөөрсөн байдаг, тухайлбал анхдагч зах зээлээс хөрөнгө бүрдүүлсэн гарааны компанид зориулан хөрөнгө босгох, инновацийн үйл ажиллагаанд оролцож буй байгууллагын өөрийн хөрөнгө (equity), гадаад улс ба олон улсын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө, мөн хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр зэрэг болно. Бодит байдал дээр эдгээр санхүүжилтийн хувьд тэд өөрийгөө санхүүжүүлэх хандлагатай байдгаас гадна, олон улсын түнш хамтран санхүүжүүлсэн банк болон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын зээл байж таардаг.

Чанаргүй зээлийн эрсдлийг бууруулах үүднээс, Монголын банк болон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ууд хөрөнгө оруулалтын өгөөжийн баталгааг хангахын тулд янз бүрийн арга барилыг нэвтрүүлэн хэрэгжүүлсээр ирсэн. Тэд зээлийн тусгай шугам нээж олгож буй эсхүл барьцаа хөрөнгө, авлагын барьцаа зэрэг олон төрлийн үнэт цаастай холбоотой бусад арга хэмжээг авсан Засгийн газар эсхүл хандивлагч байгууллагын түншлэлээс гадуур ЖДҮ-ийн зээл олгохдоо хойрго байдаг. Зээлийн олон бүтээгдэхүүн нь богино хугацаатай, харьцангуй өндөр хүүтэй байдаг нь бизнес эрхлэгч залуучуудын сонирхлыг татахуйц байдаггүй. Зөвхөн жижиг, дунд үйлдвэрлэгч гэж албан ёсоор бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүд олон төрлийн зориулалттай зээлийн бүтээгдэхүүнийг авах эрхтэй.

Хамтын санхүүжилт (Crowdfunding) болон венч хөрөнгө оруулалт (venture capital)-ын шийдлийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт хараахан байхгүй байгаа тул энэ нь технологийн гарааны бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх боломжит эх үүсвэр болон аажмаар гарч ирж байна.


Гарааны бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх чиглэлээр холбогдох эрх мэдэл бүхий байгууллага ялангуяа инновацийн асуудал хариуцсан Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголбанк, Сангийн яам хоорондын уялдаа холбоо хангалттай бус, төлөвлөлт болон төсвийг хангалттай зохицуулаагүй зэрэг нь хязгаарлах хүчин зүйл болж байна.

### Монгол Улсад цахим арилжааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлс.

Төр, хувийн хэвшлийн оролцогч талууд хил дамнасан худалдаа, логистикийг цаашид хөнгөвчлөх, улс төрийн өндөр түвшинд дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн орчныг дэмжих зэрэг нь Монголд цахим

арилжааг хөгжүүлэх гол хүчин зүйлийн эн тэргүүний асуудал гэж тодорхойлов. Бусад бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ өөр өөр байгаа боловч төрийн байгууллагын оролцогчид мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг цаашид хөгжүүлэх, энэ чиглэлээр институци хоорондын уялдаа холбоог сайжруулах, цахим арилжааны талаар илүү сайн ойлголт өгөхийн ач холбогдлыг онцолж байна. Харин хувийн хэвшлийн төлөөлүүд тээвэрлэлтийн зардлыг бууруулах, үр чадвартай ажилтнууд шаардлагатай байгаа, инновацийн соёлыг цаашид төлөвшүүлэх зэрэгт ихээхэн ач холбогдол өгч байна (Зураг 1).

**Зураг 1: Монгол Улсад цахим арилжааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлс (%)**  
(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 96, хувийн хэвшлийн 31)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

## АРГА ЗҮЙ

Монгол Улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ нь цахим худалдааг хөгжүүлэх бодлогын долоон чиглэлийн хүрээнд дижитал экосистемийн нарийвчилсан оношилгоо хийж, дэмжлэг үзүүлэх боломжтой бодлогын үндсэн арга хэмжээг тодорхойлох замаар цахим арилжааг хөгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл, боломжийг тодорхойлох зорилготой. Эдгээр бодлогын чиглэлд цахим арилжааны бэлэн байдлын үнэлгээ, стратеги боловсруулах, МХХТ-ийн дэд бүтэц ба үйлчилгээ, Худалдааны логистик ба худалдааг хөнгөвчлөх, Төлбөрийн шийдэл, Хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ, Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэх, Санхүүжилтийн хүртээмжийн асуудал хамаарна.

Энэхүү тайланд тусгасан мэдээлэл нь, өмнө хийсэн судалгаа, цахимаар явуулсан гурван санал асуулгад өгсөн хариулт (төрийн байгууллага, хувийн хэвшил болон хэрэглэгчид), үндэсний түвшинд зохион байгуулсан олон талт болон хоёр талын зөвлөлдөх уулзалтын үр дүн, мөн “eT4a” болон хөгжлийн түншүүдийн зүгээс оруулсан тодорхой хувь нэмэр зэрэг эх үүсвэрээс цуглуулсан чанарын болон тоон мэдээлэлд тус тус үндэслэсэн.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) нь дараах зорилгоор, уг төсөлд зориулан таван үе шаттай аргачлалыг боловсруулсан. Үүнд: i) үнэлгээний нийт үйл явцад гол оролцогч талуудыг өргөнөөр хамруулах, оролцоог хангах; ii) цахим арилжаанаас хүртэх боломжийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх (чадавхийг бэхжүүлэх, мэдлэг хуваалцах замаар), iii) төр, хувийн хэвшлийн яриа хэлцээг бэхжүүлж, цахим арилжааны чиглэлийн яам хоорондын зохицуулалт, бодлогын үялдааг сайжруулах, iv) тус улсын цахим шилжилтийг хурдасгахын тулд хөгжлийн түншүүдийн дэмжлэгийг дайчлах зэрэг болно.

### 1 дүгээр үе шат | Анхны зөвлөгөөн, 2022 оны 3 дугаар сараас 5 дугаар сар

Монгол Улсын Засгийн газар болон цахим худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийгэмлэг болон Монгол дахь нийт түнш байгууллагатай НҮБ-ын Сүүрин зохицуулагчийн газар (UNRCO), төслийг санхүүжүүлсэн гол түнш ЕСБХБ (EBRD) болон БНСУ-аар дамжуулан холбоо тогтоож, анхны зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.

### 2 дугаар үе шат | Байгууллагыг сонгох ба зураглал гаргах, 2022 оны 5 дугаар сар

Энэ хүрээнд Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ хийхтэй холбогдуулан Үндэсний цахим арилжааны ажлын хэсэг байгуулсан ба энэ нь холбогдох яам, агентлаг, үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, бизнесийн холбоо, аж ахуйн нэгж болон бусад байгууллагын төлөөлөөс бүрдэж, зохицуулагчийг (COP) томилсон тул ажлын эхний уулзалтыг зохион байгуулав. Монгол Улсад цахим арилжаа, дижитал хөгжилд идэвхтэй оролцож буй үндэсний оролцогч талууд болон тус улсад суурин ажиллаж буй хөгжлийн түншүүдийг хамруулсан зураглал гаргав.

### 3 дугаар үе шат | Мэдээлэл цуглуулах, 2022 оны 6 дугаар сар

- Өмнө хийсэн судалгааны ажлыг нягтлах : Хоёрдогч шатны тоон мэдээ, өгөгдөл (үндэсний болон тухайн салбартай холбоотой стратеги, холбогдох хөтөлбөр, бодлогын баримт бичгүүд)-д дүн шинжилгээ хийж, статистик болон дижитал тоон мэдээлэлтэй холбоотой үзүүлэлтийг эмхэтгэн нэгтгэж, өмнө хийсэн судалгааг иж бүрэн нягтлан үзэв.
- Цахим худалдааны бэлэн байдлын талаар цахим орчинд 3 судалгаа явуулах: Хоёр санал асуулга (төрийн байгууллага болон хувийн хэвшлийн оролцогч талуудад зориулсан) болон хэрэглэгчийн бэлэн байдлын нэг судалгааг үндэсний нөхцөл байдалд сайтар тохируулж, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 15-ны өдрийн хооронд цахим орчинд тараасан. Хувийн хэвшлийн 51, төрийн байгууллагын 115, хэрэглэгчдийн 264 төлөөлөл санал асуулгын хариу ирүүлснийг нэгтгэн тус тус цуглуулж, үнэлгээ хийх дүн шинжилгээ хийв.

- 2022 оны 6 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд үндэсний олон талт зөвлөлдөх уулзалт: Бодлогын үндсэн долоон чиглэл, цахим арилжааны гарааны бизнесэрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулагч байгууллагуудын холбогдох мэргэжилтэн, оролцогч талуудтай хамтран зорилтот бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэд хэдэн цуврал зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо болон цахим орчинд хийв. 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран тус улсад суурин ажиллаж буй хөгжлийн түншүүдтэй хамт дугуй ширээний уулзалт зохион байгуулсан бөгөөд энэ үеэр уг төслийг танилцуулж, тус улсад хэрэгжиж буй дижитал чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй болон техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулах боломжийг тодорхойлохыг зорив.
- Хоёр талын уулзалтууд: Цахим арилжааны оролцогчид болон төрийн байгууллагуудтай цуврал уулзалтыг зохион байгуулж, цахим арилжааны талаар хэрэгжүүлж буй санаачилгад тэдний гүйцэтгэх үүрэг, оролцооны талаар хэлэлцэж, үндэсний хэлэлцүүлгийн үеэр хөндсөн гол асуудлын талаар дэлгэрүүлэн ярилцав. Үүний нэгэн адил төслийн хүрээнд НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар болон хөгжлийн түншүүдтэй харилцан уялдааг хангахад чиглэсэн хамтарсан хэд хэдэн удаагийн уулзалт хийв.

#### **4 дүгээр үе шат | Тайлангийн төслийг боловсруулах, 2022 оны 7-11 сар**

- Бодлогын долоон үндсэн чиглэлийг хамарсан үнэлгээний анхны төсөл болон Цахим худалдааны бэлэн байдлын Үйл ажиллагааны матриц (eT Ready Action Matrix)
- НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD), Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD) болон цахим худалдааны түншүүдийн анхны (дотоод болон гадаад) нягтлан үзсэн дүгнэлт.

#### **5 дугаар үе шат | 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 5 дугаар сарын хугацаанд үнэлгээг эцэслэн боловсруулж, тайланг танилцуулах**

- 2023 оны 2 дугаар сард үндэсний оролцогч талууд Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ болон Үйл ажиллагааны матрицын үр дүнг хянаж, баталгаажуулах үндэсний семинар.
- Тайлангийн эцсийн төсөл.
- Тайланг үндэсний түвшинд танилцуулах, энэ хүрээнд бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг дайчлахын тулд цахим арилжааны талаар өндөр, түвшний бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх хандивлагчдын дугуй ширээний уулзалтыг зохион байгуулна.

# ЦАХИМ ХУДАЛДААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

## 1. ЦАХИМ АРИЛЖААНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ: СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улс дотооддоо цахим арилжааг дэмжих экосистемийг бий болгоход ихээхэн ахиц дэвшил гаргасан. Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт болон цахим худалдааны бэлэн байдлын (eT Ready) судалгаа нь цахим арилжаанд хувийн хэвшил болон хэрэглэгчийн оролцоо тодорхой түвшинд байгааг батлан харуулсан. Дотоодын цахим арилжаа нь хил дамнасан цахим арилжаанаас илүү сайн хөгжсөн. Энэ бүлэгт авч үзсэн хэрэглэгчийн болон бизнес эрхлэгчийн цахим арилжааны бэлэн байдлын судалгааны дүн шинжилгээ нь дотоодын болон хил дамнасан цахим арилжааны үндсэн шинж, тогтсон зуршил, сорилтыг тодорхойлоход оршив.


### 1.1. Монгол дахь цахим арилжааны хэрэглэгч болон ЖДҮ-ийн бэлэн байдал

#### Дотоодын цахим арилжаа

Үндэсний цахим арилжааны зах зээлийн хэмжээг найдвартай тооцоолж чадаагүй байгаа боловч өмнө хийсэн судалгаа, оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт, цахим худалдааны бэлэн байдлын (eT Ready) судалгаа нь бүгд цахим арилжаанд хувийн хэвшил болон хэрэглэгчийн оролцоо тодорхой түвшинд байгаа гэдгийг баталсан. Тухайлбал, санал асуулгад оролцсон бизнес эрхлэгчдийн 53 хувь нь онлайн борлуулалт хийж байгаа, 20 хувь нь онлайнгаар худалдан авалт хийдэг гэж хариулсан бол хэрэглэгчдийн 77 хувь нь онлайнгаар худалдан авалт хийсэн гэжээ.

Дэлхийн банкны Findex 2021 судалгаа мөн ийм эерэг динамик байгаа гэдгийг баталсан ба энэ судалгаанд дурдсанаар Монгол Улсад 2017-2021 онд онлайнгаар бараа худалдаж авсан 15-аас дээш насны хүмүүсийн эзлэх хувь зургаа дахин өссөн байгаа нь үнэлгээний ажилд хамрагдсан бусад Далайд гарцгүй хөгжиж буй орон (LLDCs)-той харьцуулахад хамгийн өндөр өсөлтийг харуулав (Зураг 2).

**Зураг 2:** Онлайнгаар ямар нэгэн зүйл худалдаж авахын тулд гар утас, эсхүл интернэт ашигласан 15-аас дээш насны хүмүүсийн эзлэх хувь, харьцуулан сонгосон Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (LLDCs)-аар, 2017 ба 2021 он (%)




Эх сурвалж: Дэлхийн Банкны 'Findex' судалгаа, 2017 ба 2021 он

### Цахим арилжаанд хэрэглэгчийн бэлэн байдал

Монголын хэрэглэгчид хил дамнасан худалдан авалтаас дотоодын худалдан авалтыг илүүд үзэх хандлагатай байна. Энэ хандлага орон нутагт буюу аймагт илүү ажиглагдаж байна (Зураг 3).<sup>7</sup> Харин Улаанбаатар хотын хэрэглэгчид гадаадын буюу олон улсын худалдааг (70 хувь) дотоодынхоос (51 хувь) илүүд үзсэн байна.

### Зураг 3: Цахим худалдан авалтын үндсэн шинж (дотоодын/олон улсын) (%)


(Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Хэрэглэгчийн цахим арилжааны оролцоо Улаанбаатар хотод бусад аймгийг бодвол илүү өргөн хүрээнд тогтмол байдаг ба энэ нь онцгой туршилт хэвээр байна. (Зураг 4).

### Зураг 4: Онлайн худалдан авалтын давтамж (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

<sup>7</sup> Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Говьсүмбэр, Ховд, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Увс, Завхан.

Цахимаар хийсэн худалдан авалт нь ихэвчлэн импортын загварын бараа (бэлэн хувцас, гутал, цүнх, дагалдах хэрэгсэл), хувь хүний арчилгааны бүтээгдэхүүн, эдгээрийн дараа тоглоом, хүнсний бүтээгдэхүүн голлож байв (Зураг 5). Улаанбаатар хотын болон бусад аймгийн хэрэглэгчдийн хүсэл сонирхолд зарим нэг ялгаа байгаа нь харагдсан. Тухайлбал, нийслэлээс ирүүлсэн захиалгын дийлэнх хувийг цахилгаан бараа, программ хангамж эзэлж байсан бол бусад аймаг тавилга, эмийн бүтээгдэхүүнийг илүү их захиалсан харагдаж байна.

**Зураг 5:** Онлайнаар хамгийн их худалдан авдаг бүтээгдэхүүн (%)

(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 112; хувийн хэвшлийн 31, хэрэглэгч 151 )



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Үйлчилгээний талаас нь авч үзвэл онлайн хоол хүнс хүргэлт, дижитал төлбөр тооцоо, тээвэрлэлт (галт тэрэг болон автобусны тасалбар, таксины үйлчилгээ зэрэг) нь гурван бүлгийн оролцогч талуудын хувьд тэргүүлэх байр суурийг эзэлж байсан бол арга хэмжээний тасалбар худалдан авах, санхүүгийн үйлчилгээ, дижитал зар сурталчилгаа зэргийг бүх оролцогч талуудын зарим нь чухал гэж үзжээ (Зураг 6).

**Зураг 6:** Онлайнаар хамгийн их худалдан авсан үйлчилгээ (%)


(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 112, хувийн хэвшлийн 32, хэрэглэгч 151 )



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Хэрэглэгчид олон нийтийн сүлжээ (ялангуяа аймагт), гар утасны хэрэглээний программыг ашиглан эсхүл худалдаа эрхлэгчдийн цахим хуудсаар шууд худалдан авалт хийх хандлагатай байдаг. Иймд ялангуяа Улаанбаатар хотоос бусад газар суурин компьютерт түшиглэсэн зах зээлийн гүйлгээний урсгал тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал байдаг (Зураг 7).

**Зураг 7:** Онлайн худалдан авалт хийхэд илүүдэд арга (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Монголын хэрэглэгчдийг онлайн худалдан авалт хийхэд саад тотгор болж буй гол шалтгааны нэг нь онлайн гүйлгээний аюулгүй байдалд итгэлгүй байх, мөн одоогоор байгаа хүргэлтийн үйлчилгээнд (ялангуяа үнэ, үргэлжлэх хугацааны хувьд) сэтгэл ханамжгүй байгаа ажээ. Үүний зэрэгцээ, онлайн худалдан авалт хийхийг зардал багатай гэж ойлгодог. Төлбөрийн шийдлийг найдвартай гэж үздэг тул онлайн худалдан авалт хийхэд саад болохгүй гэж үзсэн (Зураг 8).

**Зураг 8:** Онлайн худалдан авалт хийхгүй байх шалтгаан (%) (Хэрэглэгчийн судалгаа, 209 оролцогчид)




Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)



### Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчидийн цахим арилжааны бэлэн байдал


Судалгаанд хамрагдсан цахимаар борлуулалт хийдэг ЖДҮ-ийн төлөөлөл (хувийн хэвшлийн оролцогчид) нь зөвхөн онлайнаар байгуулагдаж (санал асуулгад оролцогчдын 26 хувь) "цахим үндэстэн" гэх ойлголтоос илүүтэйгээр "дотоодын хэрэглэгчдийг татах" нь тэдний онлайн байхын гол шалтгаан гэж үзсэн (Зураг 9) ба харин цахим арилжааг бизнесийн үйл ажиллагаагаа гадаад зах зээлд өргөжүүлэх боломж гэдэг талаас нь харьцангуй бага хувьтай үнэлсэн байна. Судалгаанд оролцогчдын 64 хувь нь зөвхөн дотоодын зах зээлд, 6 хувь нь зөвхөн олон улсын зах зээлд, 30 хувь нь дээрх хоёр зах зээлийн аль алинд нь борлуулалт хийдэг гэж хариулжээ. Үнэмлэхүй хувь хэмжээгээр нь үзвэл, хувийн хэвшлийн оролцогчдын 96.97 хувь нь дотоодын онлайн худалдаанд оролцсон байсан бол зөвхөн 36.36 хувь нь олон улсын худалдаанд оролцсон байв (Зураг 10). Судалгаанд хамрагдсан Монголын бизнес эрхлэгчдийн хувьд БНХАУ, БНЭУ, БНСУ, ОХУ, Турк, Украин, Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-д хил дамнасан цахим борлуулалт хийжээ. Харин БНХАУ, Герман, БНСУ, Нидерланд, Украин, АНУ-аас бараа, үйлчилгээ худалдан авсан байна.

**Зураг 9:** "Дижитал болох" шалтгаан (онлайнаар борлуулах) (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 31 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

**Зураг 10:** Цахим арилжааны борлуулалтын үндсэн шинж (дотоодын/олон улсын) (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 33 оролцогч)




Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Хувийн хэвшлийн оролцогчид бараа, үйлчилгээний борлуулалт хийхдээ өөрсдийн вэб сайт/цахим хуудсыг ашиглахыг илүүд үздэг гэв (Зураг 11). Эдгээр сонголтын дараа нийгмийн сүлжээний платформ (social media platforms) орж байна. Монголд хамгийн өргөн хэрэглэгддэг олон нийтийн сүлжээ бол Facebook, тус сүлжээнд Монголын зарим “дэлгүүр” болон “цахим хуудастай дэлгүүр”-ийг байршихыг зөвшөөрдөг хэдий ч, эдгээр нийгмийн сүлжээг зөвхөн бараа дэлгэн харуулах боломж болгон ашигладаг бөгөөд үүгээр дамжуулан тухайн худалдан авалтыг гүйцэтгэх боломжгүй.<sup>8</sup>

Гуравдагч этгээдийн олон улсын платформыг ашиглах нь дотоодын платформыг ашиглахаас хамаагүй илүү (3 дахин) гэж мэдээлсэн байна (Зураг 11). Судалгаагаар цуглуулсан мэдээллээс харахад олон улсын платформд нэвтрэх боломж хязгаарлагдмал, албан бус хэвээр байна. 2021 оны 8 дугаар сард Цахим хөгжил, харилцаа холбооны яам (MDDC) нь Амазон компанитай худалдаачдад нэвтрэх боломж олгох талаар хэлэлцээ хийж байгаа гэж мэдэгдсэн боловч, энэ нь ажил хэрэг харахан болоогүй байна.<sup>9</sup>

### Зураг 11: Онлайнаар борлуулалт хийхэд илүүд үздэг арга (%)

(Хувийн хэвшлийн судалгаа, 28 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Зөвлөгөөнд оролцсон хувийн хэвшлийнхэн цахим арилжаанд оролцоход хамгийн их саад болж буй асуудал нь хууль эрх зүйн хувьд тэднийг дэмжих зохицуулалт байхгүй, цахим арилжааны шийдлийн талаарх мэдлэг дутмаг, логистикийн зардал өндөр гэж үзэв. Тэд монголын зах зээлд байгаа төлбөрийн шийдлийг хэрэглэгчдийн нэгэн адил хүндрэлтэй гэж үзэхгүй байна. Гэсэн хэдий ч санхүү, аюулгүй байдал, логистик, дижитал үр чадвар, МХХТ зэрэг бусад хүчин зүйлүүд нь тэднийг онлайн ажиллахад саад болж байгаа гэжээ (Зураг 12).

<sup>8</sup> Мета, 'Facebook дээрх Арилжааны талбарт зориулсан дэмжлэг авдаг зах зээлүүд', Мета Бизнесийн тусламжийн төв, 2022 оны 10-р сарын 15-нд хандсан, <https://www.facebook.com/business/help/549256849084694> Жишээлбэл, Монголын Event Décor's Facebook “shop” хэсгийг эндээс үзнэ үү: <https://www.facebook.com/event.decor.mongolia/shop/>

<sup>9</sup> Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, 'Монголчууд удахгүй бүтээгдэхүүнээ Амазон дээр зарах боломжтой болно'. Facebook, 2022 оны 10-р сарын 13-нд хандсан, <https://fb.watch/fTzYn1rDu8/>

**Зураг 12:** Цахим арилжааны шийдэлд хөрөнгө оруулаагүй шалтгаан (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 26 оролцогч)




Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Хил дамнансан цахим арилжаа

Дотоодын цахим арилжаанаас ялгаатай нь хил дамнансан цахим арилжааг Монголын оролцогч талууд бага хэмжээгээр судалсан хэвээр байна. Хувь хүний хэрэгцээнд зориулсан импортын буюу гадаадын брэнд барааг худалдаж авах, эсхүл тэдгээрийг Монголд дахин дамлан борлуулах төдий байгаа бөгөөд зарим нь ийм төрлийн үйл ажиллагааг үндсэндээ хөхиүлэн дэмжих зорилготой байгуулсан дотоодын цахим арилжааны платформуор дамжуулан хийдэг байна.

Харин санхүүгийн хүртээмжтэй холбоотой хүндрэл, өндөр хураамж, хил дамнансан төлбөрийн механизмтай холбоотой нарийн төвөгтэй байдал (ялангуяа гадаадаас дотогшоо чиглэсэн төлбөрийн хувьд), чадварлаг боловсон хүчний хомсдол, гаалийн бүрдүүлэлт, логистикийн үр ашиггүй байдал зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж, Монголоос гадаадын зах зээлд бараа экспортлох нь тохиолдлын шинжтэй байна.

Үүний зэрэгцээ МХХТ-ийн үйлчилгээний салбарын экспортын зах зээл нээгдэж байгаа бөгөөд сүүлийн үед шинээр гарч ирж буй технологийн гарааны бизнесийн экосистемийн ачаар эрчимтэй дэмжлэг хүртэж эхэлсэн. Үүнийг мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хөгжлийн үндэсний статистик мэдээ ялангуяа программчлал, холбогдох зөвлөх үйлчилгээний чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн тоо хэмжээ (Зураг 13) болон орлого нотолж байна.

**Зураг 13:** МХХТ-ийн үйлчилгээ үзүүлж буй идэвхтэй бизнес эрхлэгчдийн тоо

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (NSO)

### 1.2. Монгол Улсын цахим арилжааны хөгжилд КОВИД-19 цар тахлын нөлөөлөл ба геополитикийн өнөөгийн байдлын нөлөөлөл


Монгол Улсын эдийн засагт одоогоор үргэлжилж буй хоёр хямрал, нэн ялангуяа КОВИД-19 цар тахал, түүний үр дагавар болон Украинд өрнөж буй дайн зэрэг нөлөөлсөн. Эдгээр нь цахим арилжааны динамик байдалд бас нөлөөлж байна.

КОВИД-19 цар тахал нь Монгол Улсын цахим арилжааны хөгжилд янз бүрийн хүндрэл учруулсан. Хувийн хэвшлийн оролцогч талууд КОВИД -19 цар тахал тэдний ажлын нийт гүйцэтгэлд хэрхэн нөлөөлсөн талаар зөрүүтэй (эерэг болон сөрөг) үзэл бодолтой байгаагаар илэрхийлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь цар тахал тэдний бизнест нөлөөлсөн болохыг баталсан байна (Зураг 14).

Гэсэн хэдий ч тэд ерөнхийдөө цар тахал нь тус улсад цахим арилжааг эрс нэмэгдүүлж, цахим төлбөр тооцоог өргөнөөр нэвтрүүлэх нөхцөлийг дэмжсэн гэдэгтэй санал нийлэх хандлагатай байна.<sup>10</sup>

<sup>10</sup> Монгол Банк, Төлбөрийн системийн стратеги

**Зураг 14:** Борлуулалтын хэмжээнд КОВИД-19 цар тахлын нөлөө (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 22 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

2022 оны 10 дугаар сарын байдлаар Хятад улсын КОВИД-ын бодлогоос үүдэлтэй хилээр нэвтрүүлэх хугацаа уртасч, үйл ажиллагааны зардал нэмэгдсэн нь экспорт, импорт, тэр дундаа онлайн захиалсан бараанд нөлөөлсөн зэргээс шалтгаалан логистикийн саатал үүсгэсээр байлаа.

Украинд өрнөж буй дайнаас үүдэн олон улсын хориг арга хэмжээ авах болсон нь Монгол Улсад нефтийн бүтээгдэхүүн, цахилгаан эрчим хүч, улаан буудай, бордоо зэрэг гол түүхий эдийн импортын хүртээмжийн талаар тодорхойгүй байдал үүсгээд байна.<sup>11</sup> Одоогоор Олон Улсын Банк хоорондын санхүүгийн цахилгаан холбооны нийгэмлэг (SWIFT)-ээс үндсэндээ хасагдсан байгаа Оросын банкны системтэй хэсэгчилсэн байдлаар холбогдсон байдаг банкны салбарууд энэ нөхцөл байдалд дасан зохицох шаардлагатай болсон бөгөөд Монгол Улсын хувьд мөнгөн гуйвуулга хийх зэрэг асуудлаар уг нийгэмлэгт ихээхэн найдаж ажилладаг байна. Түгээмэл хэрэглэдэг худалдааны тодорхой зам чиглэлүүдийг бас өөрчлөх шаардлагатай болсон. Дайны нөлөөгөөр үүссэн үнийн өсөлт, улмаар татварын дараах орлого<sup>12</sup> багасахад хүргэсэн нь, ялангуяа одоогоор уг зах зээлд үндсэн суурь хэрэгцээний бүс бүтээгдэхүүн давамгайлж байгаа нөхцөлд, Монгол Улсын хувьд харьцангуй үнийн-мэдрэмжтэй цахим арилжааны зах зээлд нь нөлөөлж магадгүй юм.

<sup>11</sup> АНУ-ын Төрийн департамент, '2022 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл: Монгол Улс', АНУ-ын Төрийн департамент, 2022, сек. Хураангуй дүгнэлт, <https://www.state.gov/reports/2022-investment-climate-statements/mongolia/>.

<sup>12</sup> Андрей Михнев, Икуко Уочи, Лидия (Ипссе) Ким, 'COVID-19-ийн дараах Монгол: Хүртээмжтэй эдийн засгийн сэргэлтэнд учрах эрсдэл', Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн сэргэлтийн явц, Дэлхийн банкны блог (блог), 2022 оны 10-р сарын 18, <https://blogs.worldbank.org/eastasiapacific/mongolia-post-covid-19-risks-inclusive-recovery>.

## 2. ЦАХИМ АРИЛЖААНЫ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ

Монгол Улс бие даасан цахим арилжааны стратеги байхгүй боловч дижитал, цахим шилжилтийг урагшлуулах зорилгоор хүмүүсийн амьдрал, эдийн засгийн янз бүрийн хүрээнд чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авч, технологи нэвтрүүлэх замаар олон салбарыг дамнасан стратеги хэрэгжүүлсэн нь тус улсын цахим шилжилт, дижитал эдийн засаг, цахим арилжааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Монгол Улс нь Дэлхийн гаалийн байгууллага (WCO) болон Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-ын цахим арилжааны дүрэм, бодлого боловсруулахад олон улсын олон талт болон хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэд хэдэн санаачилгад оролцдог.

### 2.1. Цахим арилжаатай холбоотой үндэсний болон салбарын стратеги

Үндэсний гол стратегийг 1 дүгээр хүснэгтэд тоймлон харуулав.

**Хүснэгт 1** : Цахим арилжаатай холбоотой зорилго, арга хэмжээг нэгтгэсэн Монгол Улсын үндэсний гол стратеги

Ерөнхий стратеги (салбар дундын шинжтэй )	Салбарын стратеги	Дижитал, цахим шилжилтийн стратеги
Алсын хараа 2050 (урт хугацааны хөгжлийн бодлого)  5 жилийн үндсэн чиглэл (дунд хугацааны) <sup>13</sup> ;  Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр (богино хугацааны) <sup>14</sup>  2022 оны Хөгжлийн төлөвлөгөө	[ХАРИЛЦАА ХОЛБОО] Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2019-2024 он  Монгол Улсын үндэсний хиймэл дагуул хөтөлбөр 2012 <sup>15</sup>	Цахим үндэстэн баримтлах чиглэл, 2022-2027  Бүх нийтийн МХХТ-ийн ур чадвар ба чадамжийг сайжруулах Үйл ажиллагааны төлөвлөгөө 2022-2026 <sup>16</sup>
Монгол экспорт хөтөлбөр 2019-2023 <sup>17</sup> (тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын 2019-2023 оны замын зураглалыг гаргаж, мэдээлэл, харилцаа холбоо, мэдээллийн талаар тусгасан)	[ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ]  Худалдааг хөнгөвчлөх үндэсний замын зураглал 2018-2022	

<sup>13</sup> Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол , <https://legalinfo.mn/mn/detail/15584>

<sup>14</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоол , <https://legalinfo.mn/mn/detail/15586>

<sup>15</sup> “Монгол Улсын хиймэл дагуулын үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 137 дугаар тогтоол , <https://legalinfo.mn/mn/detail/8845>

<sup>16</sup> 2022 оны 7-р сарын 25, А/2601, А/391, А/1461, А/260, [https://mddc.gov.mn/wp-content/uploads/2022/07/DL\\_Hamtarsan\\_tushaal\\_20220725-2.pdf](https://mddc.gov.mn/wp-content/uploads/2022/07/DL_Hamtarsan_tushaal_20220725-2.pdf)

<sup>17</sup> “Монгол экспорт хөтөлбөр” батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018.09.05-ны өдрийн 278 дугаар тогтоол , <https://legalinfo.mn/mn/detail/13692>

Эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө” 2021 он <sup>18</sup>	[САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТӨЛБӨР ТООЦОО] Үндэсний төлбөрийн системийг 2022-2030 он хүртэл хөгжүүлэх стратеги (төсөл)	
	[ОРОЛЦООТОЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ] Монгол Улсын Нээлттэй засаглалын түншлэл, 2021-2023 он хүртэлх Үндэсний үйл ажиллагааны дөрөв дэх төлөвлөгөө <sup>19</sup>	

Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

“Алсын хараа 2050” баримт бичигт “Монгол Улс 2050 он гэхэд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараараа Азийн тэргүүлэгч орон болно” гэж заасан байдаг.<sup>20</sup>

Монгол Улсын “Алсын хараа - 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт тодорхойлсон үндэсний хөгжлийн дараах тэргүүлэх чиглэл цахим арилжаанд хамаарна. Үүнд:

- 2.4 Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ (дигитал эдийн засагтай холбогдуулан МХХТ, хиймэл оюун ухааныг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлжээ).
- 2.6 Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлнэ.
- 3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнесийн ноу-хау, үр чадварыг хөгжүүлэх, ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг (МХХТ багтсан) хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.
- 4.4 Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.
- 4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 4.6 Эдийн засгийг төрөлжилт, инновац, хүний хөгжил, шинэ технологи, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.
- 5.3 Хүний хөгжлийг дэмжсэн үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.
- 7.5. Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулна.
- 8.1 Дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан бүс нутгийн эдийн засгийн интеграцид бүрэн холбогдож эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцлийг бүрдүүлнэ.

<sup>18</sup> “Эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг сэргээх 10.0 (арван) их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-г батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн 42 дугаар тогтоол.  
<https://legalinfo.mn/mn/detail?lawid=16160842294411>

<sup>19</sup> Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 91 дүгээр тогтоолын хавсралт, /[https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/01/Mongolia\\_Action-Plan\\_2021-2023\\_EN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/01/Mongolia_Action-Plan_2021-2023_EN.pdf)

<sup>20</sup> Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн баримт бичиг, 2020, [https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2050\\_VISION\\_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf](https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2050_VISION_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf) vision.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам (MDDC)-ны 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027) нь мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нийгэм, эдийн засгийн бүхсалбарт нэвтрүүлж, мэдлэг, оюун ухаанаар<sup>21</sup> дамжуулан цахим үндэстнийг цогцоор нь хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой бөгөөд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан төрийн байгууллагыг цогцоор нь бэхжүүлж, Монголчуудын амьдралын чанарыг сайжруулах зорилтыг бусад зорилтын хамт дэвшүүлсэн.

Энэхүү баримт бичгийн хүрээнд бүтээмжтэй, хүнд сурталгүй, үр ашигтай цахим засаглал; цахим орчин дахь үндэсний аюулгүй байдал; төр, хувийн хэвшил, иргэдийн чадавхийг бэхжүүлэх; мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжтэй байдал; бүх нийтийн тоон бичиг үсгийг дээшлүүлэх, дижитал ялгаа/хуваагдлыг арилгах; дижитал эдийн засгийг хөгжүүлэх зэрэг үндсэн зорилт багтсан. Сүүлийн зорилтыг биелүүлэхийн тулд, мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан (artificial intelligence), юмсын интернэт (Internet of Things), үүлэн (cloud) технологи, робот техник, нисгэгчгүй автомат онгоц буюу дрон технологи, блокчэйн зэргийг дэмжих; электроникийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэх; түүнчлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг арга замаар хүрэх юм.

Монгол Улс дижитал эдийн засгийг хөгжүүлэх бодлогыг боловсруулахын зэрэгцээ И-Монголиа болон бусад хэд хэдэн тусгай порталаар дамжуулан төрийн үйлчилгээг цахимаар хүргэх тодорхой алхмыг хийж байна (Хүснэгт 2). Эдгээр порталыг Улаанбаатар хотод бусад аймгаас илүү их хэрэглэдэг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын иргэн<sup>22</sup>, гадаадын иргэн, хуулийн этгээд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа цахим системээр дамжуулан 1000 гаруй төрлийн үйлчилгээг компьютер эсхүл гар утасны аппликейшн -ээр<sup>23</sup> дамжуулан авах боломжтой.

Монгол Улс нь Эстони Улсын И-засаглалын загварыг сонгож, Эстони Улсын И-засаглалын академи, мөн ижил төстэй И-Засаглалын тогтолцоог хэрэгжүүлж байгаа Украин Улсын Засгийн газартай хамтран ажиллаж, уг хандлагыг үзэл баримтлал болгосон. Улаанбаатар хотоос бусад орон нутагт И-Монголиа системийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 3 дугаар сараас 6 дугаар сар хүртэл Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон И-Монгол академийн хамт олон Монгол Улсын 21 аймагт очиж хөдөө орон нутгийн иргэдэд үйлчилгээг хэрхэн авах талаар танилцуулах арга хэмжээг зохион байгуулав. 2022 оны 7 дугаар сард төрийн байгууллагуудын үйлчилгээг цахимаар үзүүлж, И-Монголыг ашиглах талаар иргэдэд заавар, зөвлөгөө өгдөг “И-Монголиа” төвийг 14 аймагт<sup>24</sup> нээсэн.

## Хүснэгт 2: Монгол Улсын Засгийн газрын зарим цахим тогтолцоо

И-Татвар <sup>25</sup>	И-баримт <sup>26</sup>	Цахим татвар <sup>27</sup>	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн нэгдсэн төв <sup>28</sup>	Монголд хөрөнгө оруулалт хийх (Invest in Mongolia) <sup>29</sup>
Татвар төлөгчдөд зориулсан цахим татварын тайлангийн систем	Хэрэглэгчийн худалдан авалтын тайлан (төлбөрийн баримт)-г үндэслэн Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) төлснийг урамшуулах програм	Вэб хуудсаар нэвтрэх боломжтой Үндэсний татварын бүртгэлийн мэдээллийн сан, бүртгэл ба тайланг нэгтгэж автоматжуулсан	Олон улсын стандартад нийцсэн зураасан код ашиглан Монголын болон экспортын барааг бүртгэлжүүлэх програм хангамж	Хөрөнгө оруулагчдын цахим бүртгэл/ хөрөнгө оруулагчдад үзүүлэх цахим үйлчилгээний тогтолцоо

<sup>21</sup> ЦХХХЯ, “Цахим үндэстэн” хөтөлбөр (2022-2027)’, 2022, <https://mddc.gov.mn/wp-content/uploads/2022/07/%D0%9024-20220518-%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC->



Төрийн цахим үйлчилгээг дэмжсэн цахим порталууд нь Монгол Улсын хүн амын бүх нийтийн цахим үр чадвар, чадамжийг дээшлүүлэх, дижитал орчинд ажиллах ая тухтай байдлыг нэмэгдүүлэх, контент, программ хангамж, харилцаа холбоо, цахим төлбөр тооцоог нэгтгэсэн дижитал үйлчилгээний экосистемийг бий болгоход хувь нэмэр оруулдаг. Тиймээс тэд цахим арилжааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

## **2.2 Монгол Улсын олон улсын цахим арилжааны хууль, бодлого гаргахад оролцож буй байдал**

Монгол Улс 1991 онд Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)-ын гишүүнээр элссэн. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар нь ДГБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар болон хөгжлийн түншүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, гаалийн бүрдүүлэлтийн олон улсын шилдэг туршлагыг тэр дундаа Монгол Улс 2006 онд нэгдэн орсон Киотогийн шинэчилсэн конвенц болон ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр (ТФА)-ийг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцог. Энэхүү ажил нь хилээр нэвтрэх журмыг хөнгөвчлөх, ялангуяа олон улсын хэмжээнд бизнесээс бизнест (B2B), бизнесээс хэрэглэгчид (B2C) түгээх цахим худалдааг цаашид барааг хүргэхэд чухал ач холбогдолтой. Энэ талаар сүүлийн үед авч хэрэгжүүлсэн ажлын тухайд Швейцарийн эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газар болон ДГБ-ын Дэлхийн худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP) болон ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн<sup>30</sup> хэрэгжилт хариуцсан ДГБ-ын Меркатор хөтөлбөр зэрэг гол төлөв эрсдлийн удирдлагад төвлөрсөн үйл ажиллагаанд оролцсоныг дурдаж болно.

Монгол Улс ДХБ-ын олон талт болон хязгаарлагдмал тооны оролцогчидтой цахим арилжааны Хамтарсан санаачилга (JSI)-ын үйл ажиллагаанд мөн оролцдог. ДХБ-ын бусад гишүүн орны нэгэн адил Монгол Улс 1998 онд ДХБ-ын байнгын ажиллагаатай Барааны худалдааны хороо (СТГ), Үйлчилгээний худалдааны хороо (СТС), Худалдаа ба хөгжлийн хороо (СТГ), Ерөнхий Зөвлөл (ГС) дээр хэлэлцсэн 1998 оны цахим арилжааны талаарх ДХБ-ын ажлын хөтөлбөрийн үйл ажилагаанд оролцож, одоогоор цахим гүйлгээнд гаалийн татвар ногдуулахгүй байх асуудалд голлон анхаарч байна. 2021 онд Монгол Улс Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (LLDC)<sup>31</sup> -ын нэрийн өмнөөс худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээний худалдааг хөгжүүлэх, цахим арилжаа зэрэг асуудал чухал ач холбогдолтойг онцолж мэдээлэл түгээсэн.

[%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%87%D0%B8%D0%B3%D0%BB%D1%8D%D0%BB-%D0%B1%D0%B0%D1%82%D0%BB%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9\\_1658190818-1-1.pdf](#) . MDCC

<sup>22</sup> 'И-Монгол', 2022 оны 11 дүгээр сарын 30 өдөр хандсан, <https://e-mongolia.mn>

<sup>23</sup> News.mn, Монгол Улс 2024 он гэхэд цахим шилжилтийг 90 хувьд хүргэхийг зорьж байна, 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хандсан, <https://news.mn/en/798147/>

<sup>24</sup> М.Өнөрзул, 'И-Монгол 14 аймагт нээгдэв', МОНЦАМЭ мэдээлэл, 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр хандсан, <https://montsame.mn/en/read/300986>, <https://montsame.mn/en/read/300986>

<sup>25</sup> Татварын ерөнхий газар, 'Цахим татварын тогтолцоо (E-Tax)', 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, <https://etax.mta.mn> . МТА.

<sup>26</sup> И-татвар төлсөн баримтын тогтолцоо, 'Е-баримт', 2022 оны 10 сарын 12-ны өдөр, <https://ebarimt.mn/>,

<sup>27</sup> Сангийн яам, И-татвар - Татварын нэгдсэн тогтолцоо', 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, <https://itax.mta.mn/home>; Сангийн яам, 'iTAX - Татварын нэгдсэн тогтолцоо', 2022 оны 10 сарын 13-ны өдөр, <https://itc.gov.mn/tais>. Сангийн яам, 'iTAX - Татварын удирдлагын нэгдсэн систем'; Татварын Ерөнхий Газар (МТА).

<sup>28</sup> Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, Улсын үйлдвэрийн газар, 2022 оны 11 сарын 30-ны өдөр, <https://itc.gov.mn/iss>

<sup>29</sup> ЭЗХЯ, 'Цахим үйлчилгээний нэгдсэн портал', 2022 оны 9 сарын 22-ны өдөр, <https://e-invest.mn/> ;

<sup>30</sup> ДГБ, ДГБ-ын Меркатор хөтөлбөрийн хүрээнд Ажлын хэсэг Монголын Гаалийн ерөнхий газартажилласан, ДГБ-ын мэдээ, 2022 оны 9 сарын 22-ны өдөр, <https://www.wcoomd.org/en/media/newsroom/2022/september/wco-mercator-programme-diagnostic-mission-conducted-for-mongolian-customs-general-administration.aspx>

<sup>31</sup> ДХБ, 2021 онд Монгол Улс Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын нэрийн өмнөөс мэдэгдэл хийсэн. 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдөр, (WT/GC/237, 11 May 2021), <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/WT/GC/237.pdf&Open=True>

Энэхүү мэдээлэлд ДХБ-ын олон талт хэлэлцээг иш татаж, хөгжлийн түншүүдийн тусламж ач холбогдолтойг онцлон тэмдэглэсэн байв. Монгол Улс мэдээллийн технологи, харилцаа холбоо (ИТС)-ны бүтээгдэхүүн, түүний эд ангийн үйлдвэрлэлийг хөнгөвчлөх, хүртээмжийг сайжруулахын тулд ийм төрлийн зарим бараа, эд хэрэгслийн гаалийн тарифыг чөлөөлөх тухай Мэдээлэл, технологийн хэлэлцээр (ITA(I and II))-ийн хамтарсан санаачилгад нэгдээгүй.

2017 онд байгуулагдсан цагаас нь эхлэн цахим арилжаатай холбоотой хөтөлбөрт тусгасан 30 гаруй асуудлыг ДХБ-ын 88 гишүүн орон цахим арилжааны хамгийн өргөн хүрээг хамарсан олон улсын цахим арилжааны хэлэлцээний форумар хэлэлцэж, ДХБ-ын Цахим арилжааны тухай Хамтарсан мэдэгдэл (JSI) гаргахад Монгол Улс хамтран оролцогчоор ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улс цахим арилжаатай холбоотой Хамтарсан мэдэгдэл болон бусад ажилд оролцохын зэрэгцээ ДХБ-ын бичил, жижиг дунд үйлдвэр (MSMEs)-ийн болон Хөгжлийн төлөөх хөрөнгө оруулалтыг дэмжих тухай Хамтарсан санаачилгын хүрээний хэд хэдэн ажилд оролцож байна. Гэхдээ Монгол Улс эдгээр хэлэлцээнд баримтлах байр суурь буюу төслөө одоогоор танилцуулаагүй.

Нөгөө талаас, Монгол Улс ДХБ-ын Үйлчилгээний худалдааны дотоодын зохицуулалтын тухай Хамтарсан санаачилгад одоогоор нэгдээгүй бөгөөд холбогдох түнхаглалд тусгасан үр дүнд хүрэх эсхүл дотоодын зохицуулалтын талаар нэмэлт үүрэг амлалт авах хүсэлтээ илэрхийлээгүй. Энэхүү санаачилга нь үйлчилгээний салбарыг ирээдүйд либералчлах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, дотоодын үйлчилгээний худалдааны зах зээлд өрсөлдөөнийг бий болгоход дэмжлэг үзүүлэх юм.

Эцэст нь хэлэхэд, Монгол Улс Худалдаа ба жендэрийн асуудлаарх албан бус ажлын хэсэгт (IWG) оролцож байгаа бөгөөд уг ажлын хэсэг нь салбар дундын шинжтэй өргөн асуудлыг хэлэлцдэг тул цахим арилжааны домэйн үүсгэх хэрэгтэй болно.

### **2.3 Монгол Улс цахим арилжааны бүс нутгийн болон хоёр талт санаачилгад оролцож буй байдал**

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-оос 2019 онд Монгол Улсын цаасгүй худалдааны бэлэн байдлын үнэлгээг хийж, үүний мөрөөр гаргасан зөвлөмжийн дагуу Монгол Улс 2022 онд Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр<sup>32</sup>-т нэгдэн орсон. Энэхүү ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хоёр талын болон бусад улсыг хамарсан төсөл хэрэгжүүлж эхэлснээр Монгол Улс дотоодхудалдаа, ойрын хөрш (БНХАУ, БНСУ хэлэлцээрт нэгдсэн бөгөөд ОХУ хараахан нэгдээгүй) болон бүс нутгийн түнш (Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр буюу CAPEK) орнуудтай хийх худалдааг хөнгөвчилнө гэж дүгнэсэн.

Монгол Улс өнөөг хүртэл чөлөөт худалдааны 2 хэлэлцээр байгуулсан: Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (APTA)<sup>33</sup> болон Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр (EPA)<sup>34</sup>. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (APTA) нь худалдааг хөнгөвчлөхөд чиглэсэн зарчим болон бусад байгууллагын (ДХБ болон ДГБ) өмнө хүлээсэн үүрэг амлалтыг ихэвчлэн давтсан байгаа бол Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр (EPA) нь цахим арилжааны талаар тусгайлсан бүлэг, заалттай. БНСУ, БНХАУ, Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭХ)-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар судалгаа хийж байгаа ч эдгээр хэлэлцээр нь цахим арилжааг хөгжүүлэхийг дэмжсэн бүлэг эсхүл тусгайлсан үүрэг амлалт тусгасан эсэх нь тодорхойгүй байна.

<sup>32</sup> Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээр, 2022 оны 11 дүгээр сарын 30-нд хандсан, [https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtmsg\\_no=X-20&chapter=10&clang=\\_en](https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtmsg_no=X-20&chapter=10&clang=_en).

<sup>33</sup> Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (APTA), 2020, [https://www.unescap.org/apta#:~:text=Asia%2DPacific%20Trade%20Agreement%20\(APTA\)%20is%20a%20preferential%20regional,trade%20expansion%20and%20economic%20cooperation](https://www.unescap.org/apta#:~:text=Asia%2DPacific%20Trade%20Agreement%20(APTA)%20is%20a%20preferential%20regional,trade%20expansion%20and%20economic%20cooperation).

<sup>34</sup> 2016 оны 7 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр”-ийн 9 дүгээр бүлэг, 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хандсан, [https://www.mofa.go.jp/a\\_o/c\\_m2/mn/page3e\\_000298.html](https://www.mofa.go.jp/a_o/c_m2/mn/page3e_000298.html).

#### 2.4 Хөгжлийн түншүүдийн цахим арилжаатай холбоотой санаачилга

Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-аас түүний төрөлжсөн 23 байгууллагын нэг болох НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD) хамтран Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” (UNSDCF)-ний баримт бичиг нь Монгол Улсын “Алсын хараа - 2050”<sup>35</sup> урт хугацааны хөгжлийн бодлоготой нягт уялдсан. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээний 2 дугаар стратегийн тэргүүлэх чиглэл болох “Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт” нь цахим арилжаанд хамаарна. Энэхүү баримт бичигт цахим арилжааны хөгжлийг шууд хэмждэг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй боловч 2.2 дугаар зүйлд заасан “Бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийг байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийг бага ялгаруулах хөгжлийг дэмжих, цахим шилжилт хийх, илүү өрсөлдөх чадвартай, технологийн хувьд шинэлэг, бүтээмжтэй болгох бодлого, стратеги, институт бий болгох зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлнэ. Аж ахуйн нэгжүүдийг илүү ногоон хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлэх, дэлхийн нэмүү өртгийн сүлжээтэй нэгтгэх, албан ёсны оролцоог нэмэгдүүлэх, нөөцийн үр ашиг, тэсвэр тэвчээрийг нэмэгдүүлэх, байнгын ялгаварлан гадуурхалт, гадуурхалд өртөж буй нийгэмд үзүүлэх аливаа хүсээгүй нөлөөллийг бууруулна” гэсэн үр дүнд хүрэхэд түлхэц болохуйц харагдана. Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд “цахим арилжаа, шинэлэг, нэгдсэн шийдэл бүхий цахим шилжилт хийхэд техникийн туслалцаа үзүүлэх”, Монголын бизнес эрхлэгчид, тэр дундаа бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэлхийн цахим худалдааны нэмүү өртгийн сүлжээнд нэгдэх боломжийг хангах ёстой гэж тусгасан.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Монгол Улсад баримтлах стратегийн төсөлд (2022-2027)<sup>36</sup> тодорхойлсон стратегийн тэргүүлэх чиглэлийн хоёр нь тус улсад цахим арилжааг хөгжүүлэхэд хамтран ажиллахаар тусгажээ. : Тухайлбал, илүү хүчирхэг, төрөлжсөн, тогтвортой хувийн хэвшлээр дамжуулан Монгол Улсын бат бэх тогтвортой байдлыг нэмэгдүүлэх ба Монголын эдийн засгийн өсөлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэхэд харилцан уялдаа холбоотой байх, бүс нутгийн интеграцид нэгдэхийг дэмжинэ. Харин хоёр дахь чиглэл нь ЕСБХБ-ны таван жилийн стратеги болон хөрөнгө оруулалтын гэрээ (SCF 2021-25)<sup>37</sup>-нд тусгасан, хөрөнгө оруулалт хийж буй эдийн засгийн бүх салбарт цахим шилжилтийг идэвхжүүлэхэд Монгол Улсад дэмжлэг үзүүлэх үүрэг амлалттай нийцэж байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны (2021-2024 онд) Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги нь “хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг цогцлоох бат бэх суурийг Монгол Улсад тавих”-ад дараах гурван тэргүүлэх чиглэлийг баримтална. Үүнд: (i) хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломж, (ii) өрсөлдөх чадвар, төрөлжилтийг дэмжих, уур амьсгалд тэсвэртэй дэд бүтэц, (iii) ногоон бөгөөд тогтвортой, уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжил болон тэргүүлэх 5 сэдэвт - жендэрийн тэгш байдал, цахим шилжилт, хувийн хэвшлийн оролцоо, ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP), институтын чадавх ба засаглал; иргэний нийгмийн оролцоо<sup>38</sup> хамаарна. ЕСБХБ-наас Монгол Улсад баримтлах стратегийн тэргүүлэх чиглэл нь Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), АХБ-ны 2030 он

<sup>35</sup> НҮБ, Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ”, 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр цахимаар хандсан, [https://minio.dev.devqube.io/uninfo-production-main/bd56bb91-43ad-48c0-89c8-ce7ca7b42aaf\\_UNSDCF\\_Mongolia\\_2023-2027\\_Final\\_English.pdf](https://minio.dev.devqube.io/uninfo-production-main/bd56bb91-43ad-48c0-89c8-ce7ca7b42aaf_UNSDCF_Mongolia_2023-2027_Final_English.pdf).

<sup>36</sup> ЕСБХБ, Монгол Улсад 2022-2027 онд баримтлах стратеги

<sup>37</sup> ЕСБХБ, Захирлуудын зөвлөлийн Захирагч нарт танилцуулсан тайлан: Стратеги болон хөрөнгө оруулалтын гэрээ (2021-25 он), 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдөр, <https://www.ebrd.com/documents/corporate-strategy/strategic-and-capital-framework-2021-2025.pdf?blobnocache=true>.

<sup>38</sup> АХБ, 2021-2024 онд хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг цогцлоох бат бэх суурийг Монгол Улсад тавих”, 2021 оны 8 дугаар сарын 8-ны өдөр, <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/753311/mon-cps-2021-2024.pdf>.

хүртэлх стратеги<sup>39</sup>-тай тус тус нийцэж байна. Цахим арилжааны хөгжлийг энэхүү стратегид тусгасан цахим шилжилт болон өндөр түвшний технологийг тэргүүлэх чиглэлтэй уялдуулна.

Монгол Улсын цахим худалдааны хөтөлбөрийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зүгээс Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны санаачилга (КАРЕК)-ын хүрээнд тухайлбал, Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (КАРЕК)-ны Худалдааны нэгдсэн хөтөлбөр - 2030<sup>40</sup>, КАРЕК-ын дижитал стратеги - 2030<sup>41</sup> зэргээр дамжуулан хэрэгжүүлж байна. Энэхүү дижитал стратегийг Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны Нарийн бичгийн дарга нарын газраас КАРЕК-ын Хүрээлэн, Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP), Евразийн тогтворжуулалт, хөгжлийн сан, Исламын хөгжлийн банк, Дэлхийн банкттай тус тус хамтран бэлтгэсэн. КАРЕК-ын Дижитал стратеги-2030 нь Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн бүх иргэд, аж ахуйн нэгж, засаг захиргааны байгууллагуудад найдвартай, тухайн цагт, хэрэглэгчдэд ээлтэй цахим үйлчилгээ, холбогдох мэдээллийг хурдан, найдвартай цахим хандалт бүхий өгөгдөлд суурилсан бүс нутгийн дижитал эдийн засгийг бий болгохыг эрхэм зорилго болгон баталжээ. Энэхүү эрхэм зорилго нь цахим арилжаанд ач холбогдолтой хэд хэдэн зорилгыг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ. Үүнд: таатай эрх зүйн орчныг хөхиүлэн дэмжихэд дижитал болон өгөгдөлийн сантай холбоотой хууль тогтоомжийг ижилтгэх; хил дамнасан худалдааг нэмэгдүүлэх болон бүс нутгийн хүрээнд бизнес хөгжүүлэх боломжийг өргөжүүлэх, ялангуяа цахим арилжаа хийхэд худалдааны саад тотгорыг багасгах, КАРЕК -ийн үйл ажиллагааны кластерыг хөгжүүлэхийн тулд дижитал сүүрийг сайжруулах, харилцан ажиллах боломжтой дижитал платформыг бий болгох зэрэг болно.

## **2.5 Монголын цахим арилжааны асуудал эрхэлсэн байгууллага ба зохицуулалт**

Энэхүү үнэлгээг хийхээс өмнө Монгол Улсад цахим арилжааны асуудал эрхэлсэн байгууллага болон зохицуулалтын механизм байгаагүй. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 оны эхээр Үндэсний цахим арилжааны ажлын хэсэг байгуулсан. Одоогоор 20 гаруй яам, агентлаг, хувийн хэвшлийн төлөөлөл ажлын хэсэгт багтсан бөгөөд Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал ахалдаг. Улмаар тус газар Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. (Зураг 15).

<sup>39</sup> АХБ, "2030 он хүртэлх стратеги 2030: Ази, Номхон далайн бүсийн цэцэглэн хөгжиж буй, хүртээмжтэй, тогтвортой Монгол Улс болох", 2018 оны 7 дугаар сар, <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/435391/strategy-2030-main-document.pdf>.

<sup>40</sup> АХБ, КАРЕК-ын худалдааны хөтөлбөр-2030 болон 2018–2020 оны стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө (Азийн хөгжлийн банк, 2019), <https://www.adb.org/documents/capec-trade-agenda-2030-action-plan-2018-2020>.

<sup>41</sup> АХБ, КАРЕК-ын дижитал стратеги 2030: Бүс нутгийн өрсөлдөх чадвар, хүртээмжтэй өсөлтийн төлөөх дижитал шилжилийг хурдасгуур (Азийн хөгжлийн банк, 2022), <https://www.adb.org/documents/capec-digital-strategy-2030>.

**Зураг 15:** Монгол Улсын цахим арилжааны үндэсний ажлын хэсэг

Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Цахим арилжааны хэрэглэгч болон бизнес эрхлэгчид Засгийн газрын байгууллагатай яриа хэлцээг үүрэх энгийн механизм бүрдээгүй тул тэдний оролцоо бага хэвээр байна. Тухайлбал, судалгаанд оролцсон 52 хувийн хэвшлийн төлөөллийн зөвхөн 4 нь ( 8 хувь ) цахим арилжааг Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшил хоорондын яриа хэлцээний сэдэв гэж үзжээ.

## **2.6 Цахим арилжааны асуудлыг тэргүүлж буй төрийн байгууллага**

Одоогоор Гадаад харилцааны яам (ГХЯ) нь гадаад худалдаа, эдийн засгийн асуудлыг хариуцан ажиллаж, гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны олон улс, бүс нутаг, гадаад орнуудтай хөгжүүлэх дунд, урт хугацааны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах үүргийг хэрэгжүүлж байна. Засгийн газраас Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-ыг шинээр байгуулж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж, тус шинэ яам нь Монгол Улсын гадаад, дотоод худалдаа, бүс нутгийн болон салбар хоорондын худалдаа, эдийн засгийн стратеги, бодлого, эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг асуудлыг хариуцан ажиллаж байна. ГХЯ болон ЭЗХЯ-ны чиг үүрэг зарим талаараа давхцаж байгаа тул ЭЗХЯ-наас ГХЯ-тай хамтран ажиллаж буй аж. Одоогоор эдгээр яамдын аль нь ч цахим арилжааг зохицуулах талаар тодорхой чиг үүрэг хүлээгээгүй. Хэлэлцүүлгийн үеэр ЭЗХЯ-ны хувьд одоогийн байдлаар цахим арилжааг удирдан идэвхтэй явуулах боловсон хүчний туршлага, чадавх дутмаг байгааг дурдаад энэ салбарыг ГХЯ удирдах, манлайлах чадавхтай гэж онцлон тэмдэглэсэн юм.

Дижитал эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг техник талаас нь ялангуяа дэд бүтэц, харилцаа холбоо, цахим засаглалын талаас авч үзвэл Цахим хөгжил, харилцаа, холбооны яам (ЦХХХЯ)-ны Бодлого, төлөвлөлтийн газар, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (ялангуяа цахим засаглалын хэлтэс, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтэс), Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (сансрын холбооны хэдтэс, Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэс), түүнчлэн Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь Монгол Улсын ирээдүйн цахим арилжааны бодлогыг боловсруулж, уялдуулан хэрэгжүүлэхэд чухал оролцогч талууд болно. Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь АХБ-ны дэмжлэгтэйгээр Монгол Улс дахь цахим арилжаанд тулгарч буй хууль эрх зүйн болон зохицуулалтын саад тотгорыг тодорхойлох судалгааг хийлгэсэн<sup>42</sup>.

Эцэст нь дурдахад Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<sup>43</sup> нь төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудаас бүрдсэн бөгөөд гаалийн бүрдүүлэлт болон холбогдох логистикийн шийдлийг хөнгөвчлөх, хил дамнасан цахим арилжааны барааны худалдаанд мөрдөж буй гаалийн журмыг хялбарчлахтай холбоотой шийдлийг гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

## **2.7 Цахим арилжааны статистик мэдээлэл (жендэр болон бусад ангиллын статистик мэдээлэл)**

Монгол Улсын албан ёсны статистик мэдээллийг 1997 онд баталсан Статистикийн тухай хуульд заасны дагуу цуглуулдаг бөгөөд Үндэсний статистикийн хороо (ҮСХ) уг ажлыг удирдан зохион байгуулдаг. Хуулиар тогтоосон албан ёсны статистик мэдээллийн хураангуй жагсаалтад цахим хөгжилд зөвхөн “харилцаа холбооны үйлчилгээний орлого, утас, радиогийн тоо” гэсэн үзүүлэлт хамаарч байна. Харин Монголбанк нь мэдээлэл, харилцаа холбооны технологитой холбоотой “Харилцаа холбооны хэрэгслийн төрөлжсөн худалдаа; Харилцаа холбооны үйлчилгээ; Компьютер, сүлжээний үйлчилгээ; болон харилцаа холбооны үйлчилгээ”<sup>44</sup> гэсэн статистик мэдээллийг гаргадаг аж.

Статистикийг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь үндэсний статистикийн тогтолцоог бэхжүүлэх, тэр дундаа хүний нөөцийг хөгжүүлэх, статистик мэдээллийн менежментийг сайжруулах, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх, статистикийн чадавхыг бэхжүүлэх, статистикийн бизнесийн боловсруулалтыг сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй байх, хэрэглэгчид ашиглахад энгийн, хялбар байх нөхцлийг хангахаар тусгажээ. Мөн статистикийн мэдээллийн нэгдсэн сан<sup>45</sup>-гийн үзүүлэлтийг цахимжуулахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байна.

Цахим шилжилтийг аажмаар хийсний үр дүнд сүүлийн үед ҮСХ-ны тусгайлсан веб хуудас ([www.1212.mn](http://www.1212.mn)) болон холбогдох яам, агентлагийн цахим хуудсаар дамжуулан илүү их мэдээлэл цуглуулж, танилцуулах боломж бүрджээ. Гэсэн хэдий ч үндэсний оролцогч талууд болон хөгжлийн түншүүдийн сонирхсон (тухайлбал, олон улсын тухайн чиглэлээр зэрэглэл тогтооход ашигладаг) тоон үзүүлэлттэй илүү сайн нийцүүлэн, ижилтгэх, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн динамик ялангуяа дижитал эдийн засгийн үзүүлэлтийг нэмж харуулах нь илүү үр өгөөжтэй.

<sup>42</sup> Судалгааг дэлгэрүүлэн үзнэ үү.

<sup>43</sup> ГХЯ, Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо байгуулах тухай 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/48 тушаал, <https://mfa.gov.mn/documentation/61381>.

<sup>44</sup> Монгол банк, ‘Мерчантын ангиллын код’, <https://www.mongolbank.mn/documents/paymentsystems/merchantcode.pdf>.

<sup>45</sup> ҮСХ, Статистикийг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр’, 2017, <https://en.nso.mn/article/259>.

### 3. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ДЭД БҮТЭЦ БА ҮЙЛЧИЛГЭЭ

*Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. 2022 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар нийт хүн амын 84.3 хувь интернэт хэрэглэж байна. Хөдөлгөөнт холбооны өргөн зурвас хэрэглэгчдийн 90 гаруй хувь нь 3G сүлжээ, 70 гаруй хувь нь 4G/LTE сүлжээнд холбогдсон. Засгийн газраас 5G сүлжээг хүчтэй дэмжиж байгаа бөгөөд эхлээд Улаанбаатар хотод, дараа нь орон нутагт нэвтрүүлэх гэж байна. Шилэн кабелийн холболтоор дамжуулан суурин өргөн зурвасын хэрэглээг ялангуяа хот газар ашиглах нь нэмэгдэж байгаа боловч одоогоор суурин өргөн зурвасын хэрэглэгчийн тоог хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоотой харьцуулахад аравны нэг хувьтай тэнцэж байна. Холболтын чанар харьцангуй доогуур байдаг боловч ялангуяа орон нутагт өндөр үнэтэй гэж оролцогч талууд үзсэн байна. Газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалан хуурай газрын сүлжээ байхгүй тул үйлчилгээ муутай бүс нутгуудад үйлчлэхэд хиймэл дагуул чухал үүрэгтэй. Гэсэн хэдий ч алслагдсан орон нутагт буюу хөдөөгийн малчин айл өрхүүд интернэтэд холбогдоогүй хэвээр байсаар байна.*

#### 3.1. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын бодлогын баримт бичиг

##### Мэдээлэл, харилцаа холбооны технологийг үндэсний стратегид тусгасан байдал

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт мэдээлэл, харилцаа холбооны салбарыг экспортын баримжаатай эдийн засгийг хөгжүүлэхэд хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж тодорхойлсон. “Алсын хараа-2050” нь гурван үе шаттай (2021-2030, 2031-2040, 2041-2050) бөгөөд тус баримт бичигт кибер аюулгүй байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх, технологид суурилсан инновац, интеграц, улс орны эрсдэлийн удирдлагын чадавхыг сайжруулахад чиглүүлнэ гэж тусгажээ. Мөн сансрын технологид суурилсан үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, эрсдэлийн удирдлагын үндэсний институцыг бий болгоно гэжээ. Мөн мэдээллийн технологид тулгуурлан төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, өндөр хурдны сүлжээнд холбох, цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг өргөтгөн хөгжүүлэх зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан байна.

##### Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын стратегид тусгасан байдал

Цахим шилжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрчимжүүлэх үүднээс Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг “Цахим Үндэстэн” болох санаачилгын хүрээнд баримтлах чиглэл боловсруулан баталж, дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах; цахим засаглалыг хөгжүүлэх; мэдээллийн аюулгүй байдлыг хангах; тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх; инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх; үндэсний хөгжлийн хурдасгуур байх гэсэн 6 зорилтыг дэвшүүлжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны 2019-2024 оны стратеги, үйл ажиллагааны цогц төлөвлөгөөнд дөрвөн зорилтын хүрээнд i) цахим ялгааг бууруулж, харилцаа холбооны дэвшилтэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; ii) Хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн, үндэсний эрх ашигт нийцсэн аюулгүй, найдвартай харилцаа холбооны үйлчилгээг Монгол Улсын нийт ард түмэнд хүргэх; iii) Технологийн нэгдлийн үр ашгийг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг хурдасгах замаар өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, инновацыг дэмжих; iv) Харилцаа холбооны зохицуулах хороо<sup>46</sup>-ны чадавхыг сайжруулах зэрэг арга хэмжээг тусгасан.

##### Мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаарх үндэсний хууль эрх зүйн орчин

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хууль тогтоомж хэд хэдэн хуулиас бүрддэг. Үүнд: Харилцаа холбооны тухай хууль (2001), Шуудангийн тухай хууль (2003), Радио долгионы тухай хууль (1999), Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019), Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019),

<sup>46</sup> ХХЗХ, ‘Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны стратеги, үйл ажиллагааны цогц төлөвлөгөө’, 2018, <https://crc.gov.mn/articles/slug11297/mn>.

түүнчлэн саяхан шинэчлэн баталсан Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (бүгд – 2021 онд батлагдсан). Эдгээр хуулийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудасны тусгай хэсгүүдээс тус тус танилцах боломжтой боловч зөвхөн Монгол хэл<sup>47</sup> дээр уншиж танилцах боломжтой. Дүрэм, журмаар зохицуулсан нарийн төвөгтэй байдал үргэлжилсэн хэвээр байна.

---

<sup>47</sup> ЦХХХЯ, 'Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын эрх зүйн орчин', 2021 оны 6 дугаар сарын 12-ны өдөр, <https://mddc.gov.mn/eng/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/>.



## Бусад үүрэг амлалт

Монгол Улс 2013 онд ДХБ-ын Үйлчилгээний худалдааны хэлэлцээр (GATS)-ийн Харилцаа холбооны салбарт хэсэгчилсэн үүрэг амлалт хүлээсэн. Тухайлбал, байгууламжид суурилуулаагүй харилцаа холбооны хэд хэдэн дэд салбарыг бүрэн нээсэн. Үүнд: Цахим шуудан, дүүт шуудан, цахим мэдээлэл, өгөгдлийн сангийн хайлт, цахим өгөгдөл солилцох, сайжруулсан/нэмүү өртөг шингээсэн факс үйлчилгээ (хадгалах, дамжуулах, татах гэх мэт), код болон протокол хөрвүүлэх, цахим мэдээлэл ба/эсхүл өгөгдөл боловсруулах (дамжуулалтыг боловсруулах) зэрэг болно. Харин байгууламжид суурилсан харилцаа холбооны үйлчилгээний салбарт ямар нэгэн үүрэг амлалт хүлээгээгүй. Монгол Улс нь тус салбарт зохицуулалтын болон өрсөлдөөний талаар хамгаалалтын арга хэмжээ авах асуудлыг тодорхойлсон 1996 оны ДХБ-ын Харилцаа холбооны үндсэн лавлах баримт бичигт<sup>48</sup> нэгдээгүй. Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль (2001) нь энэхүү лавлах баримт бичигт заасан зарим зарчмуудыг (бүх нийтийн үйлчилгээний тодорхойлолт, Харилцаа, холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны үндсэн үүрэг, ялангуяа зах зээл дээрх шударга өрсөлдөөнийг дэмжих, хамгаалах талаар тодорхойлсон) тусгасан байдаг. Монгол Улсын харилцаа холбооны зах зээлд өрсөлдөөнийг хэрхэн дэмжиж байгааг үнэлэхийн тулд мөрдөж буй дүрэм журамд цаашид дүн шинжилгээ хийх шаардлагатай. Эдгээрийн дотроос Харилцаа, холбооны зохицуулах хорооноос саяхан баталсан Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам (2021 он), Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөх нөхцлийг бүрдүүлэх журам<sup>49</sup> (2021 он) зэрэг болно. Харилцаа холбооны хууль тогтоомжийг ил тод болгох, мөн олон улсын хэмжээнд тогтоосон жишигт нийцүүлснээр тус салбарт хөрөнгө оруулалтыг татах боломж нэмэгдэнэ.

Харилцаа холбооны шинэ дүрэм журам тухайлбал, ДХБ-ын Харилцаа холбооны үндсэн лавлах баримт бичигт заасан хэрэглээний хамрах хүрээг өргөжүүлэх, сайжруулах, улмаар нэмүү өртөг шингээсэн харилцаа холбоог хамруулах асуудлыг одоогоор Монгол Улсын хамтран оролцож буй Цахим арилжааны талаарх Хамтарсан мэдэгдэл (JSI)-ын хүрээнд хэлэлцэж байна. Төрийн болон хувийн хэвшлийн оролцогчид эдгээр дүрмийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх нь Монгол Улс хэлэлцээ хийх байр сууриа тодорхойлох, цаашид тухайн хэлэлцээрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахад тустай.

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улсын хоорондын хэлэлцээр (ЕРА)-ийн 5 дугаар хавсралтад Харилцаа холбооны үйлчилгээний нарийн дүрмийг үндсэн болон нэмүү өртөг шингээсэн харилцаа холбооны аль алинд нь хамруулж, төвөгтэй байдлаар хослуулан тусгажээ. Нэг талаас, энэ хэлэлцээрт ДХБ-ын Харилцаа холбооны үндсэн лавлах баримт бичигт тусгасан дүрэмтэй ижилтгэсэн дэлгэрэнгүй мэдээлэл (харилцаа холбоо, өрсөлдөөн, бие даасан зохицуулагч, бүх нийтийн үйлчилгээ, хомс нөөцийн хуваарилалт, ил тод байдал гэх мэт)-ийн талаар тусгасан бол нөгөө талаас мэдээллийн урсгал, харилцаа холбооны үйлчилгээг дахин борлуулах, олон улсын стандартыг ашиглах тухай шинэ дүрмийг тусгажээ. Монгол Улс дээрх шаардлагыг хангаж байгаа эсэх эсхүл түүнд хүрэхийн тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тусад нь тусгайлсан үнэлгээ хийх шаардлагатай.

### **3.2. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн асуудал эрхэлсэн байгууллага**

Мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (СИТА)-ийг 2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ) болгон шинээр байгуулсан. ЦХХХЯ-ны үндсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь харилцаа холбоо, мэдээллийн технологи, сансар, өргөн нэвтрүүлэг, шуудан, радио давтамж, бүх нийтийн үйлчилгээний үүрэг юм. Тус яам нь эдийн засаг, нийгмийн өсөн нэмэгдэж буй мэдээлэл, үйлчилгээний хэрэгцээг хангахад мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.

<sup>48</sup> ДХБ, 'Үйлчилгээ: Харилцаа холбооны үндсэн лавлах баримт бичиг', 1996 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр, [https://www.wto.org/english/tratop\\_e/serv\\_e/telecom\\_e/tel23\\_e.htm](https://www.wto.org/english/tratop_e/serv_e/telecom_e/tel23_e.htm).

<sup>49</sup> ХХЗХ, 'Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгох журам', 2021 оны 3 дугаар сарын 9, <https://www.crc.gov.mn/storage/PDF/2021/2021-togtool57.pdf>.

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэдийн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Иймд тус хорооны гол зорилго нь аюулгүй, найдвартай, хямд үнээр мэдээллийн технологийн сүлжээнд нэвтрэх боломжийг хөнгөвчлөх, мөн мэдээлэл, харилцаа холбооны технологийн инновац, өргөжилтийг дэмжих явдал юм. ХХЗХ бүрэн эрхийнхээ хүрээнд харилцаа холбооны салбарт төрөөс баримтлах бодлого, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох / тусгай зөвшөөрөлгүйгээр харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг тогтоох, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон (эсхүл тэдгээрийн үйлчлүүлэгчид) хоорондын маргааныг шийдвэрлэх, харилцаа холбооны стандартыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн гэрчилгээ, сүлжээний харилцан холболтыг хангах, харилцаа холбооны үйлчилгээний тариф, зохицуулалтын үйлчилгээний хураамжийг батлах, Монгол Улсын харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөнийг хамгаалах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилт, дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө, дугаартай шилжих нөхцөлийг боловсруулах, домэйн нэрийг бүртгэх журмыг батлах зэрэг ажлыг хариуцдаг.

Тагнуулын ерөнхий газар /ТЕГ/-ын Мэдээллийн аюулгүй байдлын алба нь Монгол Улсын төрийн бүх байгууллагын харилцаа холбооны аюулгүй байдлыг хариуцдаг. Үүнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>50</sup>-ын 3.6 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын институцийн болон чухал мэдээллийн сүлжээний нууцлагдсан байдал, бүрэн бүтэн байдал, дамжуулалт, кибер аюулгүй байдал зэрэг нь мэдээллийн аюулгүй байдалд хамаардаг.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа байгууллага болох “И-Монгол” академи УТҮГ төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийг хариуцан ажилладаг бөгөөд тэр дундаа бизнесийн үйл явцыг дахин инженерчлэх замаар төрийн үйлчилгээг цахимжуулах чиг үүрэгтэй ажилладаг.

MNCERT/CC төрийн бус байгууллага нь цахим халдлагыг зогсоох, кибер сургалт, кибер мэдлэгийг дээшлүүлэх сургалт, кибер аюулгүй байдлын талаарх хамгийн сүүлийн үеийн шинэчлэлт, зөвлөх үйлчилгээ зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. MNCERT/CC нь Ази Номхон далайн компьютерын яаралтай тусламжийн багийн (APCERT) гишүүн бөгөөд дэлхийн 20 орны Кибер онцгой байдлын үндэсний баг (CERT) болон хувийн хэвшлийн CERT багтай тус тус хамтран ажилладаг. MNCERT/CC нь ШУТИС-ийн Мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургууль, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газар, Мэдээлэл, технологийн үндэсний парктэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилладаг.

### **3.3. Дижитал төхөөрөмжийн хүртээмж**


Монгол Улс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүх тоног төхөөрөмжийг импортоор авдаг бөгөөд ДХБ-ын Мэдээллийн технологийн хэлэлцээр (ITA) эсхүл Мэдээллийн технологийн нэмэлт хэлэлцээр (ITA II) -т хараахан нэгдээгүй байгаа. Монгол Улсын хэмжээнд дижитал төхөөрөмжийн хүртээмж тэгш бус. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ)-ын мэдээлснээр Монголчуудын гар утасны хэрэглээ бараг бүх нийтийг хамарч, 94.3 хувьд хүрчээ (Хүснэгт 3). ХХЗХ-ны мэдээгээр гар утас хэрэглэгчдийн 93 хувь нь ухаалаг төхөөрөмж ашигладаг (Зураг 16).

<sup>50</sup> ГХЯ, ‘Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал’, Гадаад харилцааны яам, 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, <http://mfa.gov.mn/en/documentation/55280/>.

**Хүснэгт 3:** Дижитал төхөөрөмж хэрэглэдэг өрхийн хувь хэмжээ (хүн амд эзлэх хувь, %)

Төхөөрөмж	2018 он	2021 он
Гар утас	94.4	94.3
Компьютер	29.8	33.3

Эх сурвалж: Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)

**Зураг 16:** Хэрэглэж буй ухаалаг төхөөрөмжийн тоо

Эх сурвалж: Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо

Гэхдээ Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ)-ын мэдээгээр нийт хүн амын дөнгөж гуравны нэг нь буюу 33.3 хувь нь компьютер ашиглах боломжтой. Хувь хүмүүс өөрийн хэрэгцээнд зориулж хувийн компьютер импортоор оруулахад “de minimis буюу үл тооцох хувь” горим үйлчилдэг тустай боловч тус улсад компьютерын эзлэх хувь хэмжээ бага хэвээр байна (Хүснэгт 3). Хэдийгээр компьютер нь интернэтэд холбогдох эсхүл цахим худалдаа хийх урьдчилсан нөхцөл биш боловч энэ төрлийн төхөөрөмжийг ашиглах боломж хязгаарлагдмал байгаа нь ялангуяа Монголын хөдөө орон нутгаас худалдан авалт хийсэн эзлэх хувь хэмжээг тооцоход шууд нөлөөлдөг. Төхөөрөмж ашиглах гэдэгт мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр чадварыг тооцоогүй болно.

**3.4. Үүрэн холбооны болон өргөн зурвасын тархалт**

Харилцаа, холбооны зохицуулах хорооны мэдээлснээр 2022 оны хоёрдугаар улирлын байдлаар Монгол Улсын харилцаа холбооны шилэн кабелийн сүлжээний урт 47,983 км болжээ. Тэдгээрийг зургаан оператор компани ажиллуудаг, тухайлбал Мэдээлэл холбооны сүлжээ ХХК (NETCO)<sup>51</sup> (41 хувь);

<sup>51</sup> ХХЗХ, “Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт”, Харилцаа холбооны зохицуулах хороо, 2022 оны 9 дүгээр сарын 22, <https://crc.gov.mn/articles/2022-ony-ehnij-hagas-zhilijn-ndsen-z-lelt-d/mn>. CRC.

Мобиком Нетворкс ХХК (27 хувь); Скайнетворкс ХХК (26 хувь); Жэмнэт ХХК (5 хувь); MT Networks ХХК (1.5 хувь); Айрон Тауэр ХХК (0.3 хувь); болон СТБС ХХК (0.3 хувь). Түүнчлэн, тус улсын хойд-өмнөд чиглэлийн үндсэн төмөр зам дагуух 1400 км урт шилэн сүлжээг Монголын төмөр замын охин компани болох Рэйлком эзэмшдэг. Энэ сүлжээг Рэйлком эзэмшдэг.

Монгол Улс хойд талаараа ОХУ-тай хиллэдэг Сүхбаатар боомт, урд талаараа БНХАУ-тай хиллэдэг Замын-Үүдийн боомтыг холбосон шилэн кабелийн сүлжээ ашиглан Европ-Ази гэсэн чиглэлд нийт 570.5Gps интернэт урсгалыг дамжуулж байна.<sup>52</sup>

Эрчим хүчний үйлдвэрлэлийг илүү үр ашигтай, найдвартай, тогтвортой болгож дэд бүтцийг дэмжих боломжтой. Монголын уламжлалт нүүдэлчин амьдралын хэв маяг, цаг агаарын хүнд нөхцөл, өргөн уудам нутаг дэвсгэрт хүн ам сийрэг тархсан зэргээс шалтгаалан Улаанбаатар хот болон бусад аймагт цахилгаан эрчим хүч<sup>53</sup> үе үе тасрах байдал хэвээр байна. Нийт хүн амын 80 гаруй хувь нь цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд холбогддог. Үлдсэн 20 хувь буюу ихэвчлэн алслагдсан сум, хөдөө орон нутгийн малчид цахилгааны хүртээмж муутай, ихэвчлэн өөрийн үүсгүүр бүхий цахилгаан эрчим хүчийг жишээлбэл нарны зайн хавтан ашигладаг.

Монгол Улсын Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого (2015-2030 он) нь импортын цахилгааны хамаарлыг бууруулахад туслах найдвартай эрчим хүчний эх үүсвэр, тэр дундаа сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийг хэрэглэгчдэд түгээх зорилготой.

Монгол Улсын үүрэн телефоны хэрэглээ 2021 онд 100 хүн тутамд ногдох тоо 140 болж, дэлхийн дундаж 115.1-аас дээгүүр үзүүлэлттэй болов (Хүснэгт 4). Энэхүү үзүүлэлт нь Улаанбаатар хот болон орон нутгийн хооронд мэдэгдэхүйц ялгаатай (Зураг 17). Түүнчлэн Харилцаа, холбооны зохицуулах хорооны мэдээгээр Монголын одоогийн үүрэн телефон утасны захиалгын 71 хувь нь урьдчилсан төлбөрт, 20 хувь нь дараа төлбөрт, 9 хувь нь холимог (урьдчилсан болон дараах төлбөрийг хосолсон) байдаг. Хос (эсхүл олон) СИМ карт ашиглахтай холбоотой байх магадлалтай бөгөөд цаашид дараа төлбөрт болон холимог сонголт бүхий хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна.

<sup>52</sup> НҮБ-АНДЭЗНК (UN-ESCAP), “Монгол Улсын тээвэр, эрчим хүчний дэд бүтэцтэй МХХТ-ийн дэд бүтцийг хамтран ашиглах судалгааны тайлан”, 2020 оны 4-р сарын 13, 15, <https://www.unescap.org/resources/research-report-ict-infrastructure-co-deployment-transport-and-energy-infrastructures>. ESCAP, 15.

<sup>53</sup> НҮБ-АНДЭЗНК (UN-ESCAP), “Монгол Улсын Тээвэр, Эрчим Хүчний Дэд бүтэцтэй МХХТ-ийн дэд бүтцийг хамтран ашиглах судалгааны тайлан”, 18. Монгол Улсын эрчим хүчний дэд бүтцийн систем нь хоорондоо холбогдоогүй дөрвөн эрчим хүчний системүүдээс бүрддэг. Эрчим хүчний үйлдвэрлэлд нь Даланзадгад дахь дулаан ба цахилгаан хосолсон станц, мөн түүнчлэн дизель үүсгүүр, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр орно.

**Хүснэгт 4:** Гол үзүүлэлтийн зах зээлийн статистик


<u>Үзүүлэлт</u>	<u>Монгол Улс</u>			<u>Дэлхийн дундаж</u>
	<b>2010</b>	<b>2016</b>	<b>2021</b>	<b>2021</b>
<u>Хүн амын тоо (сая)</u>	2.7	3.0	3.3	...
<u>100 хүнд ногдох гар утас хэрэглэгчийн тоо</u>	92.9	111.2	140.0	115.1
<u>100 хүнд ногдох суурин өргөн зурвас хэрэглэгчийн тоо</u>	2.8	7.5	11.3	18.2
<u>Хөдөлгөөнт өргөн зурвасын 100 хүнд ногдох хэрэглэгчийн тоо</u>	7.5	80.2	116.2	86.2
<u>Интернэт хэрэглээ (хүн амд эзлэх хувь, %)</u>	10.2	22.3	84.3	84.1

Эх сурвалж: Олон улсын цахилгаан холбооны холбоо (ITU), Дэлхийн харилцаа холбоо, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT)-ийн үзүүлэлтийн өгөдлийн сан

2022 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар интернэт хэрэглэгчдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар буюу 136.6 мянган хэрэглэгчээр нэмэгдэж, 4.1 сая СИМ карт захиалсан нь үүрэн телефоны болон цахим сүлжээний нийт эзэмшигчдийн тооноос илүү байна. Учир нь зарим хэрэглэгчид нэгээс олон СИМ хэрэглэдэг байж болно (давхардсан тоогоор)<sup>54</sup>.

Монгол Улсын гар утас хэрэглэгчдийн тоо суурин өргөн зурвас хэрэглэгчдээс 10 дахин давж, 2022 оны сүүлийн хагаст 3,860,500 болов. Харин гар утасны өргөн зурвасын тархалт мөн Улаанбаатарт төвлөрч байна (Зураг 17). 2017 оноос хойш өргөн зурвасын үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо нэг сая арай хүрэхгүй хэмжээгээр нэмэгджээ. Захиалагчдын 91 хувь нь 3G, 73 хувь нь 4G/LTE технологид холбогдсон байна. 2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сарын хооронд гар утасны дата ашиглалт 36 хувиар өсөхөд 4G/LTE-ийн эзэмшигчдийн захиалга голлон нөлөөлжээ.

**Зураг 17:** Интернэт хэрэглэгчдийн тоо, бүс ба нийслэл, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар




Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо

<sup>54</sup> УХС, 'Мэдээ, мэдээлэл', 2022 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хандсан, [https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Communication\\_2022\\_I-VI\\_en.pdf&ln=En](https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Communication_2022_I-VI_en.pdf&ln=En).

Түүнчлэн суурин өргөн зурвас хэрэглэгчийн тоо нь дэлхийн дунджаас доогуур хэвээр байгаа бөгөөд 11.3 хувийг эзэлж байна. Харин суурин өргөн зурвас хэрэглэгчийн тоо тухайлбал хэрэглэгчдийн 94 хувийг эзэлдэг өрхийн дунд нэмэгдэж байна. Суурин өргөн зурвас идэвхтэй хэрэглэгчдийн 73 хувь нь Улаанбаатар хотод төвлөрдөг. Харилцаа, холбооны зохицуулах хорооны мэдээгээр 2022 оны 2 дугаар улирлын байдлаар гэрээт суурин интернэт идэвхтэй хэрэглэгчийн тоо 396,045 бол өсчээ. (Зураг 18).

**Зураг 18:** Гэрээт суурин интернэт идэвхтэй хэрэглэгчийн тоо, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар



Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо

Өргөн зурвас хэрэглэгчдийн 94 хувийг бүрдүүлж буй шилэн кабель нь суурин интернэт холболтыг бий болгох хамгийн түгээмэл технологи болж байгаа бол үүний дараа нь xDSL (3 хувь), Wi-Fi (2 хувь), Wi-Max (1 хувь) технологи эзэлж байна. Хэрэглэгчдийн 66 хувь нь 10 Мбит ба түүнээс дээш, 4.2 хувь нь 5-10 Мбит, 25.7 хувь нь 2-5 Мбит, харин үлдсэн 3 хувь нь 256-1024 Кбит хурдыг тус тус ашигладаг байна.

Монгол Улс цаашид өргөн зурвасын сүлжээг нэвтрүүлэх зорилтыг үндэсний болон салбарын стратегид тусгажээ.

Засгийн газраас нэн тэргүүнд 5G сүлжээг нэвтрүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч, Харилцаа, холбооны зохицуулах хорооноос радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалт, техникийн шаардлагыг батлах талаар бэлтгэл ажилд тусгасан байна. 5G сүлжээг өрсөлдөөний зарчмаар нэвтрүүлэх бөгөөд Улаанбаатар хотоос эхэлж, үйлчилгээ эрхлэгч компаниуд тусгай зөвшөөрөл олгосноос хойш нэг жилийн дотор үйл ажиллагаагаа эхлүүлж, лиценз олгосноос хойш гурван жилийн дотор бусад аймгуудад үйл ажиллагаагаа явуулах ёстой. Татвар / татварын хөнгөлөлт болон бусад урамшуулал олгох санал дэвшүүлсэн боловч тодорхой<sup>55</sup> арга хэмжээ аваагүй.

### Холболтын чанар ба өгөгдөл (найдвартай байдал, боломжит үнэ, хоцрогдол, хурд)

Монгол Улс Амьдралын дижитал чанарын индекс (DQL)-ээр 2022 онд 117 орноос 90 дүгээр (Азийн 34- орноос 27 дугаар байр)<sup>56</sup> байр эзэлжээ. Индексээс харахад тус улсад интернэтийн үнэ боломжийн байгаа боловч холболтын хурд, тогтвортой байдал хангалтгүй байна. SpeedTest-ийн мэдээлснээр Монгол дахь суурин болон хөдөлгөөнт өргөн зурвасаар мэдээлэл татаж авах (download), байршуулах (upload) холболтын хурдыг харьцуулан үзэхэд суурин өргөн зурвасын холболт илүү хурдтай хэвээр байна<sup>57</sup>. Хэрэглэгчийн санал асуулгад оролцсон хэрэглэгчдийн дийлэнх нь (74.62 хувь) интернэтийн

<sup>55</sup> ХХЗХ, 'Харилцаа, холбооны зохицуулах хорооноос радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалт, техникийн шаардлага', 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр, <https://crc.gov.mn/articles/h-d-lg-nt-holboony-5-dah-eijn-tehnologid-ashiglah-radio-davtamzhijn-zurvasyn-huvaarilalt-zohicuulalt/en>.


<sup>56</sup> Амьдралын дижитал чанарын индекс, 2023 оны 3 дугаар сарын 5-ны өдөр, <https://surfshark.com/dql2022>

<sup>57</sup> Холболтын хурдны индекс, 2023 оны 3 дугаар сарын 5-ны өдөр хандсан, Монгол Улс, <https://www.speedtest.net/global-index/mongolia#mobile>

төлбөрт сар бүр 30,000 гаруй монгол төгрөг (MNT) зарцуулдаг гэж мэдээлсэн бол үүнтэй ойролцоо хувь (69.32 хувь) нь интернэтэд холбогдох зардал өндөр байна гэж хариулжээ. Энэ нь Улаанбаатар хотод оршин суудаггүй хөдөө орон нутгийн оролцогчдын хувьд бодит үнэн юм (Зураг 19).

**Зураг 19:** Та интернэт холболтын төлбөрийг (ADSL, гар утас) хэрхэн үнэлдэг вэ?

(Хэрэглэгчийн судалгаа, 264 оролцогч)



Эх сурвалж: НУБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

**Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчид хоорондын өрсөлдөөн**

Судалгаанд оролцогчид өрсөлдөөнийг гол асуудал гэж тодотгоогүй. Үнэн хэрэгтээ жижиглэнгийн зах зээл өрсөлдөөнтэй байдаг тул хувийн компаниуд арилжааны хөрөнгө оруулалт татах шийдвэр гаргах эрхтэй. Харин бөөний худалдааны түвшинд тодорхой өрсөлдөөний асуудал байх магадлалтай.<sup>58</sup>

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 52 дугаар тогтоол баталж, одоогийн ашиглаж буй болон ашиглаагүй дэд бүтцийг хамтран ашиглах журмыг тогтоосон<sup>59</sup>. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мэдээлэл, холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах тусгай зөвшөөрөл бүхий сүлжээний операторууд, тэр дундаа төрийн өмчит сүлжээ (НЕТКО, МТ Сүлжээ) зэрэгт хамаарна. Харин ЕСБХБ-ны судалгаанд хамрагдсан оролцогч талууд (санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, харилцаа холбооны оператор, үйлчилгээ эрхлэгч, шинжээч) хүчин чадлын бөөний түрээсийн сүлжээний үнэ хэт өндөр байгаа тул дэд бүтцийг хамтран ашиглах ажил бүрэн хэрэгжихгүй байна гэж үзжээ. Дараагийн сонголт бол шинэ дэд бүтцийг одоо байгаа дэд бүтцийн дагуу оновчтой бус маршрутаар ч гэсэн "бий болгох" хэрэгтэй. Дээрх шийдлийн аль нь ч бий болгосон дамжуулах сүлжээг байвал зохих үнийгулам нэмэгдүүлж энэ салбарт хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байна.

**3.5. Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа**


Төр, хувийн хэвшлийн судалгаанд оролцогчид мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн хамгийн тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Хувийн хэвшлийнхэн (үүрэн болон суурин) интернэтын хүртээмж чухал гэж үзсэн бол төрийн байгууллагынхан хөдөө орон нутагт интернэтийн хэрэглээ, хурдыг нэмэгдүүлэхийг нэн тэргүүнд чухал гэж үзсэн. (Зураг 20).

<sup>58</sup> Энэ хэсэгт ЕСБХБ-наас Монгол Улсын өргөн зурвасын салбар болон хөрөнгө оруулагч нарын төсөөллийн талаар түлхүү тусгасан. 2021 он, <https://www.ebrd.com/documents/ogc/broadband-sector-mongolia.pdf>

<sup>59</sup> Энэхүү хэрэгсэл нь идэвхгүй болон идэвхтэй дэд бүтцийг хоёуланг нь хуваалцах боломжийг олгодог. Үүнд: инженерийн барилга байгууламж, санал асуулга, худаг ба сувагчлал, хуваарилах кабинет ба хайрцаг, цамхаг, талбай, эрчим хүчний эхүүсвэр, агааржуулалтын систем, дохиоллын хамгаалалтын систем, лангуу, тоон суваг, хэрэглэгчийн сүлжээ, болон дамжуулах сүлжээний тоног төхөөрөмж, түүний элементүүд хамаарна.

Монгол Улсын ҮСХ-ны 2021 оны Монголын өрхийн эдийн засгийн судалгааны дүн нь интернэтийн хэрэглээ (болон ашиглалт)-г эрэмбэлэх шаардлагатайг нотлов. Судалгаанд хамрагдсан иргэдийн 65 орчим хувь нь гэртээ интернэт байхгүй гэж хариулсан бол 40 хувь нь өрхийн нэг ч гишүүн интернэт ашигладаггүй гэж хариулжээ.

**Зураг 20:** Мэдээлэл, харилцаа холбооны технологийн домэйн ба тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа (Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 94, хувийн хэвшлийн 31 төлөөлөл оролцов)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын төслийн санхүүжилт

Монгол Улсад мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн төслүүдийг төсвийн зардал, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (universal service obligation funding (USOF)),<sup>60</sup> хөрөнгө оруулалтын санхүүжилт (гадаадын болон дотоодын), төр хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийн гэрээ байгуулах зэрэг олон төрлийн санхүүжилтийн аргаар шийддэг. Гэхдээ төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүд дутмаг, Засгийн газрын баталгаа гаргах боломж хязгаарлагдмал, зохицуулалт хангалтгүй, төлөвлөлт, төсөв зохиох чадавх хангалтгүй, дүрэм журмын зохицуулалтын нарийн төвөгтэй байдал зэрэг нь томоохон хөрөнгө оруулалт татахад саад болдог.<sup>61</sup>

<sup>60</sup> Харилцаа холбооны тухай хуулийн (2001) 3.1.8-д “бүх нийтийн үйлчилгээний үүрэг” гэж төрийн бодлогын хүрээнд алслагдсан бүс нутаг, үйлчилгээ муутай хүн амд шуудан, харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг боломжийн үнээр хүргэхийг хэлнэ. Төрийн тусгай сангийн тухай хууль (2019)-д дээрх тодорхойлолыг өргөтгөж, шинэ сүлжээг бий болгох, харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх талаар тусгасан.

<sup>61</sup> ЕСБХБ, Монгол Улсад 2022-2027 онд баримтлах стратеги, НҮБ, Монгол Улсад үзүүлсэн хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ, 2018 оны бдугаар сарын 13. <https://www.undp.org/mongolia/publications/development-finance-assessment>



Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (USOF<sup>62</sup>) ашиггүй газруудад өргөн зурвасын дэд бүтэц барьж буй үйлчилгээ эрхлэгчдэд (өрсөлдөөнт тендер зарлах замаар) татаас олгодог. Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөрөнгө оруулалтын төсөл, байршлыг тухай бүрд нь тодорхойлдог. Эдгээр тэргүүлэх чиглэл нь үйлчилгээ хүрээгүй тухайн байршилд байгаа сургуулийн насны хүүхдийн тооноос хамаардаг. Гэсэн хэдий ч эрэмбэлэх, хуваарилах үйл явцыг ил тод болгон сайжруулах боломжтой гэж Европын сэргээн босголт, хөгжлийн банк үзэж байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (USOF) нь 2007-2020 онуудад 117 төсөл, хөтөлбөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн. Эдгээр төслүүдийн ихэнх нь хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх таатай орчныг бүрдүүлэх, өргөн зурвасын сүлжээг бий болгох, өргөжүүлэх, хөдөөгийн хүн амын мэдээллийн технологийн үр чадварыг дээшлүүлэхэд чиглэгджээ. Монголын мэдээлэл, харилцаа холбооны салбарт орж ирж буй хөрөнгө оруулалтын урсгал эдийн засгийн бусад салбарын хөрөнгө оруулалттай харьцуулахад тогтвортой боловч хязгаарлагдмал хэвээр байна<sup>63</sup>. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2021 онд тус салбарт 269,821,5 сая төгрөгийн (үлсын төсөв, гадаад эх үүсвэр нийлээд) (тухайн онд оруулсан нийт хөрөнгө оруулалтын 1.7 хувь) хөрөнгө оруулалт хийжээ. Үүнээс 7.34 сая ам.доллар (нийт хөрөнгө оруулалтын 0.3 хувиас бага хувь) нь гадаадын шууд хөрөнгө оруулалт байв. ЕСБХБ-ны мэдээлснээр харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулахад саад болж буй гол хүчин зүйл нь барилга барих тусгай зөвшөөрөл авах горим, дэд бүтцийг хамтран ашиглах буюу бусад зохицуулалт хийх зардал өндөр.<sup>64</sup>

### **Мэдээлэл, харилцаа холбооны стандартчилал ба хил дамнасан дэд бүтцийн харилцан үйлчлэл**


Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017)-д санал болгож буй техникийн зохицуулалтад олон улсын болон бүс нутгийн стандарт байгаа бол түүнийг хэрэглэнэ гэж заасан. ЦХХХЯ-наас мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын стандартыг боловсруулах явцыг ил тод болгох алхам хэрэгжүүлж байна. Санал болгож буй стандартын төслийг цахим хуудаснаа нийтэлж, сонирхогч талууд хоёр сарын<sup>65</sup> хугацаанд цахим шуудангаар санал, хүсэлтээ илгээх боломжтой. Цахим хуудсанд нийтэлж, санал авах стандартын төслийн жагсаалтад (санал авах хугацаа дууссан бол) Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) болон Их Британийн стандартын байгууллага (BSI)-ын стандарт мөн хамаарна. Гэхдээ Монголд хэрэглэж буй цахим арилжааг хөгжүүлэхэд хэрэгтэй стандартын талаар илүү өргөн хүрээтэй судалгаа хийх шаардлагатай.

### **Харилцаа холбооны хиймэл дагуул**

Монгол орныг дэлхийн сүлжээнд холбоход, ялангуяа газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалан хуурай газрын сүлжээгүй Монголын баруун хойд болон зүүн өмнөд хэсэгт үйлчилгээ хүргэхэд хиймэл дагуул чухал үүрэгтэй. Одоогийн хиймэл дагуулын үйлчилгээнд хиймэл дагуулын өргөн зурвасын интернэт болон VPN багтдаг бөгөөд эдгээр нь цахим арилжааны хөгжилд онцгой ач холбогдолтой. 2022 онд Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Сансрын хөдөлгөөнт холбооны радио давтамжийн зурвасын зохицуулалт”-ыг баталсан бөгөөд үүнд тусгай зөвшөөрөл олгох журам, холбогдох давтамж, ашиглах төхөөрөмжид тавигдах техникийн шаардлага, харилцагчийн үйлчилгээний үүрэг зэрэг багтсан болно<sup>66</sup>. Монголын харилцаа холбооны 4 компани 444 Мгц давтамжийн зурвасыг өргөн нэвтрүүлэг болон хиймэл дагуулын үүрэн холбооны үйлчилгээнд ашигладаг. Монгол Улс Koreasat 20 (Ku), Telesat (Ku) зэрэг гадны хиймэл дагуулаас транспордер түрээслэн ашиглаж байна. Түүнчлэн Монголын үүрэн холбооны оператор Юнител групп нь Линк Глобал (Lynk Global)<sup>67</sup> хиймэл дагуулын холболтын үйлчилгээг эх орондоо анх удаа ашиглах боломжийг баталгаажуулсан. Линк технологи нь стандарт гар утсыг техник хангамж, программ хангамжийн хувьд ямар ч өөрчлөлтгүйгээр дэлхийн өнцөг булан бүрээс бага тойрог замын хиймэл дагуул ашиглан холбох боломжийг олгодог. Монгол Улс сансрын холбооны хиймэл дагуул хөөргөх нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын бодлогын зорилтын нэг юм. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 137 дугаар тогтоолоор баталж, 2013 онд энэхүү төслийн<sup>68</sup> хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор Сансрын үндэсний зөвлөлийг байгуулсан. Сансрын хиймэл дагуулын технологийн үндэсний чадавхыг бэхжүүлэх, ялангуяа Япон Улсын Кюүшүгийн технологийн хүрээлэн<sup>69</sup>-тэй хамтран ажиллаж, туслалцаа авахыг зорьж байгаа юм.

Холбогдох статистик мэдээнээс харахад аймгуудад хиймэл дагуулын холболтыг интернэтийн үйлчилгээ авахад өргөнөөр ашигладаг (Зураг 21). Харин Улаанбаатар хотод интернэтийн холболтыг хангах өөр арга хэрэгсэл байгаа тул ийм хэрэглээ бараг байхгүй.

**Зураг 21:** Байнгын хиймэл дагуулын хөдөлгөөнт хэрэглэгч ба хиймэл дагуулын интернэт хэрэглэгч, бүс нутгаар, 2021 он



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

<sup>62</sup>, . F., Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын дагуу “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”-г байгуулсан (2006 оны журмыг 2009 онд шинэчлэн баталсан). Бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгийг хандив, зээл, тусламж, харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн орлого болон хөрөнгөөс хоёр хувийн хураамж авч санг бүрдүүлнэ. “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”-гийн журмыг 2020 онд шинэчилж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байхаар зохицуулсан. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн журмыг батлах тухай Засгийн газрын 151 дүгээр тогтоол. 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдөр. <http://www.usof.gov.mn/wp-content/uploads/2018/03/law3.pdf>

<sup>63</sup> Эдгээр хөрөнгийн урсгал нь зөвхөн дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтаас гадна МХХТ-тэй холбоотой бусад үйл ажиллагаа/бизнес хамаарч болохыг анхаарна уу.

<sup>64</sup> ЕСБХБ, ‘Хөрөнгө оруулагчдын төсөөлөл ба өргөн зурвасын салбар (Монгол)’, 2021, 7, <https://www.ebrd.com/documents/ogc/broadband-sector-mongolia.pdf>. EBRD, 7

<sup>65</sup> ‘Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо’, 2022 оны 12-р сарын 1-нд хандсан, [https://www.crc.gov.mn/pages/show/standart\\_new/mn](https://www.crc.gov.mn/pages/show/standart_new/mn).

<sup>66</sup> Харилцаа холбооны зохицуулах хороо (CRC), ‘Сансрын хөдөлгөөнт холбооны радио давтамжийн зохицуулалт’, 2016 оны 1-р сарын 4, <https://www.crc.gov.mn/storage/PDF/2014/2014-31.pdf>. CRC.

<sup>67</sup> Крис Донкин, ‘Юнител групп хиймэл дагуулын гэрээ хийж, холболтын үйлчилгээг нэмэгдүүлэхийг зорьж байна’, Mobile World Live (blog), 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр хандсан, <https://www.mobileworldlive.com/featured-content/top-three/unitel-eyes-mongolia-coverage-boost-with-satellite-deal/>; Жэймс Бартон, ‘Юнител Lynk-тэй хиймэл дагуулын талаар гэрээ байгууллаа’, 2021 оны 11 дүгээр сарын 4-ны өдөр хандсан, <https://developingtelecoms.com/telecom-technology/satellite-communications-networks/12246-unitel-signs-satellite-deal-with-lynk-for-coverage-in-mongolia.html>.

<sup>68</sup> Сансрын холбооны хэлтэс, ‘Монголын хиймэл дагуул’, [https://www.itu.int/en/ITU-D/Regional-Presence/AsiaPacific/Documents/Events/2015/October-IISS-2015/Presentations/S4\\_Batbayar\\_Vandansambuu.pdf](https://www.itu.int/en/ITU-D/Regional-Presence/AsiaPacific/Documents/Events/2015/October-IISS-2015/Presentations/S4_Batbayar_Vandansambuu.pdf).

<sup>69</sup> Кюшүгийн технологийн хүрээлэн, ‘BIRDS төсөл’, 2017, <https://birds1.birds-project.com/>; Төртөгтох Түмэнжаргал ба бусад, ‘Монгол Улсын анхны хиймэл дагуул: Боломж ба төсөөлөл, Олон улсын сансрын холбооны цахим номын сан, 2021, <https://dl.iafastro.directory/event/IAC-2021/paper/61881/>.

#### 4. ХУДАЛДААНЫ ЛОГИСТИК БА ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

Монгол Улс дэд бүтэц, түүний үйлчилгээг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж, хөгжлийн түншүүдээс эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааг авдаг боловч худалдааны логистик, худалдааг хөнгөвчлөх нь тус улсын тулгамдсан томоохон асуудлын нэг хэвээр байна. Хятад улсын Ковид -19 цар тахлын хөл хорио, ОХУ-д тавьсан хориг арга хэмжээний улмаас үүссэн хямрал нь өнөөгийн сорилтыг улам хүндрүүлж байна. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хуучирч элэгдсэн дэд бүтэцтэй, олон улсын өрсөлдөөн байхгүй байдал нь Монгол Улсын эдийн засгийн тээврийн үйлчилгээний салбарын өрсөлдөх чадварыг улам бүр доройтуулж байна. Энэ талаар аажмаар ахиц дэвшил гарч буй хэдий ч Монгол Улсын Засгийн газраас бага оврын ачаа тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлтийн ажлыг хөнгөвчлөхөд чиглэсэн дэлгэрэнгүй, зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

##### 4.1 Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ ба стратеги

Монгол Улс худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, Гадаад харилцааны яамаар ахлуулсан Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (ХХҮХ)-г 2017 онд байгуулсан (Зураг 22). Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо нь “Худалдааг хөнгөвчлөх 2018-2022 оны стратеги төлөвлөгөө”, “Үндэсний замын зураглал” боловсруулж, ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээрийн холбогдох заалт болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр авсан бусад үүрэг амлалт, сайн туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Зураг 22: Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны бүрэлдэхүүн



Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага (WTO)<sup>70</sup>


<sup>70</sup> ДХБ, ‘Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт’, <https://tfadatabase.org/uploads/thematicdiscussiondocument/Mongolia.pdf>.

#### 4.2 Монгол Улсын худалдааг хөнгөвчилж буй ажлын гүйцэтгэл

Монгол Улс далайд гарцгүй газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалан худалдааг хөнгөвчлөх, тэр дундаа хөрш орнуудтай дамжин өнгөрөх тээвэр, хилийн хамтын ажиллагаа, хилийн боомтод мөрдөх дүрэм, журмыг хялбарчлах, оновчтой болгоход ихээхэн ач холбогдол өгдөг.<sup>71</sup> НҮБ-аас 2021 онд гаргасан дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаар дэлхийн хэмжээнд явуулсан судалгаагаар Монгол Улсын хэрэгжилт 2015 онд 33.33 хувьтай байсан бол 2021 онд нийт 50.54 хувьтай гарсан нь ил тод байдал, цаасгүй худалдаа, хил дамнасан цаасгүй худалдаа болон гаалийн бүрдүүлэлтийн талаар дэвшил гарсантай холбоотой (Зураг 23)<sup>72</sup>. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (АЕО)-ийн схем болон цаасгүй худалдаатай холбоотой арга хэмжээг үндэсний болон хил дамнасан худалдаанд хэрэгжүүлээгүй эсхүл хангалтгүй хэрэгжүүлснээс үүдэн оноо нь бүс нутгийн болон тухайлбал Ази, Номхон далайн Далайд гарцгүй орнуудын бүлгийн дунджаас бага зэрэг доогуур гарсан байна<sup>73</sup>.

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-ын мэдээгээр, Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг дангаар хэрэгжүүлбэл худалдааны зардлыг 10 орчим хувиар, харин Ази Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны хэлэлцээрийн арга хэмжээтэй хамтатган хэрэгжүүлбэл худалдааны зардлыг 30 хувиар бууруулах боломжтой гэж тооцоолжээ. Ингэснээр худалдааны зардлыг жилд багадаа 133 сая ам.доллараар бууруулна гэсэн үг.<sup>74</sup>

**Зураг 23:** НҮБ-аас Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаар дэлхийн хэмжээнд явуулсан судалгаагаар Монгол Улсын худалдааг хөнгөвчилж буй ажлын гүйцэтгэл



Эх сурвалж: НҮБ-ын Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаар явуулсан судалгаа<sup>75</sup>

<sup>71</sup> Худалдааны бодлого хянан үзэх тухай, 'Монгол Улсын худалдааны бодлого - 2021 он', 2021 оны 1 дүгээр сар, Дэлхийн худалдааны байгууллага, [https://www.wto.org/english/tratop\\_e/tpr\\_e/s406\\_e.pdf](https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/s406_e.pdf).

<sup>72</sup> НҮБ, 'Худалдааг хөнгөвчлөх ба цаасгүй худалдаа (2021)', Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаарх НҮБ-ын дэлхийн хэмжээний судалгаа, <https://www.untsurvey.org/economy?id=MNG>. UN.

<sup>73</sup> НҮБ, 'Худалдааг хөнгөвчлөх ба цаасгүй худалдаа (2021)'. НҮБ-аас Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх талаарх дэлхийн хэмжээний судалгаа, харьцуулалт,

<sup>74</sup> АНДЭЗНК, 'Ази, Номхон далайн бүсийн дижитал худалдааг хөнгөвчлөх: Худалдаа, хөрөнгө оруулалт, инновацийн судалгаа-87', 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, <https://www.unescap.org/publications/digital-trade-facilitation-asia-and-pacific-studies-trade-investment-and-innovation-87>.

<sup>75</sup> НҮБ, 'Худалдааг хөнгөвчлөх ба цаасгүй худалдаа (2021)'.

### ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн явц

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтаа бүрэн хэрэгжүүлэх нь Монгол Улсын худалдааг, тэр дундаа цахим худалдааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш Монгол Улс ихээхэн ахиц дэвшил гаргажээ. 2022 оны 12 дугаар сарын байдлаар Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн арга хэмжээний 79.8 хувь нь хэрэгжсэн талаар ДХБ<sup>76</sup>-д мэдэгдсэн байна. Гэхдээ Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас хийсэн үнэлгээний дагуу ДХБ-д мэдэгдсэн зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй гэж үзжээ. Тухайлбал, 1–4 дүгээр зүйл – Мэдэгдэл (А); 4 дүгээр зүйл – Давж заалдах эсхүл хянан шалгах ажиллагаа (А); 10.1 дүгээр зүйл – Холбогдох журам, баримт бичгийн шаардлага (А); 3 дугаар зүйл – Лавлагаа авах цэг (В); 5.3 дугаар зүйл – Шинжилгээ хийх (В); 6.3 дугаар зүйл – Торгууль ногдуулах журам (В); 12 дугаар зүйл – Гаалийн хамтын ажиллагаа (В); 1.2 дугаар зүйл – Интернетээр дамжуулан авах боломжтой мэдээлэл (С); 3 дугаар зүйл – Барааг урьдчилан тодорхойлох (С); 7.4 дүгээр зүйл – Эрсдэлийн удирдлага (С); 7.6 дугаар зүйл – Барааг эзэнд нь олгох дундаж хугацааг тодорхойлох болон энэ тухай хэвлэн нийтлэх; болон Зүйл. 7.7 дугаар зүйл – Итгэмжлэгдсэн операторуудад зориулсан худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ зэрэг болно. Гэтэл Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.8 дугаар зүйлд заасан түргэвчилсэн ачилт нь С ангилалд багтаж байгаа бол энэ талаар ДХБ-д хараахан мэдэгдээгүй байгааг үнэлгээнд иш татжээ.

Одоохондоо бүрэн хэрэгжээгүй буюу мэдэгдэл хүргүүлээгүй 5 арга хэмжээ байна. Үүнд: Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.5 дугаар зүйл – бүрдүүлэлтийн дараах шалгалт; 7.8 дугаар зүйл – Түргэвчилсэн ачилт; 8 дугаар зүйл – Хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагаа; 10.3 дугаар зүйл – олон улсын стандартыг ашиглах; ба 10.4 дүгээр зүйл – Нэг цонхны систем (бүгд – С ангилалд хамаарна).

Хөгжлийн түнш орнууд эдгээр арга хэмжээний заримыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал:

- АХБ-ны хэрэгжүүлж буй “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл” нь сонгогдсон хилийн боомтуудыг сэргээн засварлах, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг (CAIS) шинэчлэх, хилийн боомтыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах замаар худалдааны үйл явцын үр ашгийг нэмэгдүүлэх болон Нэг цонхны системийг бүдүүлэхэд хувь нэмэр оруулна.<sup>77</sup>
- Дэлхийн гаалийн байгууллагын стандарт, ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээрийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлэлтийн дараах аудитыг хэрэгжүүлэхэд ДГБ дэмжлэг үзүүлж, Японы Гаалийн хамтын ажиллагааны сангийн (CCF/Japan) санхүүгийн дэмжлэг үзүүлж байна<sup>78</sup>.
- Швейцарын эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газар болон ДГБ хамтран LTI (Light Touch Intervention)-д суурилсан Олон улсын худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP)-ийг саяхан баталж, эрсдэлийн удирдлагад үндэслэсэн гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тус улсын эрсдэлд суурилсан хяналтын стратегийг боловсруулах, гаалийн хяналтын стратегийг ДГБ-ын хэрэгсэл,

<sup>76</sup> ДХБ, ‘Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дата мэдээлэл’, Монгол Улсын хэсэг, 2022 оны 12 дугаар сарын 1-ны өдөр хандсан, <https://tfadatabase.org/>.

<sup>77</sup> Гаалийн ерөнхий газар, “(КАРЕК-ын Гаалийн хамтын ажиллагааны хорооны 19 дүгээр уулзалт, цахим уулзалт, 2020 оны 8 дугаар сарын 9-ний өдөр, <https://www.carecprogram.org/uploads/CCC-04-Mongolia.pdf>.

<sup>78</sup> ДГБ-ын Меркатор хөтөлбөрийн хүрээнд Ажлын хэсэг Монголын Гаалийн ерөнхий газарт ажилласан, 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр, <https://www.wcoomd.org/ru-ru/media/newsroom/2022/september/pca-diagnostic-mission-conducted-in-mongolia.aspx>

төхөөрөмж болон улс орнуудын эрсдэлийн удирдлагын олон улсын шилдэг туршлагад нийцүүлэхийг зорьж байна<sup>79</sup>.

Европын Холбооноос амжилттай хэрэгжүүлсэн EX-TPAM төслийн хүрээнд 2017-2021 онд худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн<sup>80</sup>. Монгол Улсын Засгийн газраас уг төслийн хоёр дахь үе шатыг хэрэгжүүлэх хүсэлтийг Европын Холбоонд гаргаад байгаа болно.

#### **4.3 Монгол Улсын цаасгүй худалдааны бэлэн байдал**

Монгол Улсад хил дамнасан үйл ажиллагааг төрийн олон байгууллага хариуцаж, ижил мэдээллийг шаарддаг тул худалдаа эрхлэгчид тухайн мэдээллийг төрийн байгууллага бүрт шинээр бүрдүүлж өгдөг. Эдгээр нь дэд бүтцийг бэхжүүлэхэд саад болохоос гадна Монгол Улсын олон улсын транзиттээврийн өрсөлдөх чадварыг бууруулдаг. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг энэ чиглэлээр оновчтой болгох зорилгоор 2005 оноос Үндэсний нэг цонхны үйлчилгээ төслийг хэрэгжүүлж, 2011 онд байгууллага хоорондын ажлын уялдааг хангах чиг үүрэг бүхий удирдах хороог байгуулсан. Нэг цонхны систем бий болгох чиглэлээр ахицтай байгаа боловч бэлтгэл ажлын шатанд байгаа тул 2025 он гэхэд хэрэгжинэ гэсэн хүлээлттэй байна.

2019 онд Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос Монгол Улсын хил дамнасан цаасгүй худалдааны бэлэн байдлын үнэлгээг хийж, цаасгүй худалдааны салбарт ахиц дэвшил гарсныг онцолж, зөвлөмж гаргасан. Тухайлбал, Монгол Улс Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээр (СРТА) болон Олон улсын гэрээний цахим харилцааны тухай НҮБ-ын конвенцод түс түс нэгдэж, Гаалийн тухай хуулийг шинэчлэн боловсронгуй болгож, Нэг цонхны системийг танилцуулах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарсан<sup>81</sup>.

#### **4.4 Монгол Улсын худалдааг хөнгөвчлөх болон цаасгүй худалдааны олон улсын хэлэлцээр, түүний хэлэлцээнд оролцож буй байдал**

Монгол Улс ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээр (СРТА)-ээс гадна худалдааг хөнгөвчлөх, цаасгүй худалдаатай холбоотой<sup>82</sup> хилийн бүрдүүлэлт, тээвэр, дамжин өнгөрөх тээвэр, логикийн чиглэлийн бусад олон

<sup>79</sup> ДГБ, 'Швейцарын эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газар болон ДГБ хамтарсан Олон улсын худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP), ДГБ, 1 December 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, [https://www.wcoomd.org/en/topics/capacity-building/activities-and-programmes/cooperation-programmes/seco\\_wco-gtftp.aspx](https://www.wcoomd.org/en/topics/capacity-building/activities-and-programmes/cooperation-programmes/seco_wco-gtftp.aspx).

<sup>80</sup> Европын холбоо, 'Монгол Улсад худалдаатай холбоотой туслалцаа үзүүлэх', EX-ны TPAM төсөл, 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, <http://tram-mn.eu/>.

<sup>81</sup> АНДЭЗНК, 'Монгол Улсын хил дамнасан цаасгүй худалдааны бэлэн байдлын үнэлгээ' (2019), <https://www.unescap.org/resources/readiness-assessment-cross-border-paperless-trade-mongolia>.

<sup>82</sup> ДГБ-ын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенц (1988), [www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/nomenclature/instruments-and-tools/hs-convention/hs-convention\\_en.pdf?la=en](http://www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/nomenclature/instruments-and-tools/hs-convention/hs-convention_en.pdf?la=en); Ховордсон зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES) (1973), <https://cites.org/sites/default/files/eng/disc/CITES-Convention-EN.pdf>; ДГБ-ын шинэчилсэн Киотогийн конвенц (2006), [https://www.wcoomd.org/en/topics/facilitation/instrument-and-tools/conventions/pf\\_revised\\_kyoto\\_conv.aspx](https://www.wcoomd.org/en/topics/facilitation/instrument-and-tools/conventions/pf_revised_kyoto_conv.aspx); Утра зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах Бернийн конвенц (1886), <https://wipolex.wipo.int/en/treaties/textdetails/12214>; Транс Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр (2006), <https://www.unescap.org/resources/intergovernmental-agreement-trans-asian-railway-network>; Маркны олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр (1979), <https://www.wipo.int/treaties/en/registration/madrid/>; Түр оруулах тухай конвенц (Истанбулын конвенц) (1990), <https://www.wcoomd.org/en/about-us/legal-instruments/~/-/media/2D53E23AA1A64EF68B9AC708C6281DC8.ashx>; Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай НҮБ-ын конвенц (1982), <https://unece.org/DAM/trans/conventn/harmonie.pdf>; ТИП карнэйг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай гаалийн конвенц (1975), [https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg\\_no=XI-](https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XI-)

тооны олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдсэн. Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр (ЕРА) нь гаалийн журам, худалдааг хөнгөвчлөх зэрэг бүлгийн талаар товчхон тусгасан бөгөөд ерөнхийдөө холбогдох зарчимтай нийцүүлсэн байна.<sup>83</sup>

Түүнчлэн өнөөдрийн байдлаар Монгол Улсын Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-аас ОХУ, БНХАУ, Унгар, БНСУ, АНУ, Их Британи, Казахстан, Болгар, Чех, Турк, Украин, Киргизстан, Энэтхэг, Вьетнам, Балба, Беларусь улстай гаалийн салбарт хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, санамж бичигт гарын үсэг зурсан. ГЕГ нь бусад орны гаалийн байгууллагын сайн туршлагаас суралцах, боловсон хүчнийг чадавхжуулах, хилийн хяналтын ажилтнуудад зориулсан сургалт, семинарыг хамтран зохион байгуулах чиглэлээр хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна<sup>84</sup>.

### Цахим худалдааны гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх арга хэмжээ

2010 оноос хойш Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (CAIS)-ийг барааны цахим бүрдүүлэлт хийх үндсэн систем болгон ашиглаж байна. Энэхүү систем нь гаалийн бүрдүүлэлтийг 24/7 хийх боломжтой, программ хангамжтай. 2016 онд Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг шинээр байгуулж, нэг цонхны системтэй нэгтгэх төслийг эхлүүлсэн. Гэсэн хэдий ч гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (ASYCUDA)-ийг буцаан ашиглаж, дамжин өнгөрөх ачаа тээврийн үрсгалд хэрэглэхээр төлөвлөсөн. Орос, Хятадын гаалийн байгууллагатай гаалийн бичиг баримтыг цаасгүй солилцох ажил хэрэгжиж байна<sup>85</sup>. НҮБ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын бага хурал, Европын сэргээн босголтын Банк хамтран 2022 оны 10 дугаар сард гарын үсэг зурсан “Монгол Улсынгаалийг цахимжуулах” шинэ төсөл нь гаалийн автоматжуулахад үүсээд буй бэрхшээлийг тодорхойлох ТЭЗҮ боловсруулах, түүнчлэн цахим хил, цахим арилжааны операторуудад гаалийн мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийг хүргэх зорилготой юм.

Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтын дагуу технологийн шинэ дэвшил, худалдааг хөнгөвчлөх хүчин чармайлттай үялдуулан олон өөрчлөлтийг тусгасан Монгол Улсын Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ойрын хугацаанд батлах төлөвтэй байна.

### Монголын оролцогч талуудын гол сонирхож буй худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ

Монголын оролцогч талууд "Үл тооцох хувь/мөнгөн дүн"-ийг гаалийн дэглэмд тэргүүлэх чиглэл болгон эрэмбэлж, тээвэрлэлтийн зардлыг бууруулах, экспорт, импортод хамаарах татвар, хураамжийг ил тод байлгах, тухайлбал Дэлхийн гаалийн байгууллагаас саяхан боловсруулсан Хил дамнасан цахим арилжааны ерөнхий стандартад тусгасан арга хэмжээг<sup>86</sup> хэрэгжүүлэхэд илүү анхаарах шаардлагатай гэж үзэв (Зураг 24). Мөн жижиглэнгийн импортыг хөнгөвчлөх бүсийг бий болгох хэрэгтэй гэж онцлов.

A-16&chapter=11&clang=\_en; Олон улсын хооронд авто тээврээр ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенц (1956), [https://treaties.un.org/doc/Treaties/1961/07/19610702%2001-56%20AM/Ch\\_XI\\_B\\_11.pdf](https://treaties.un.org/doc/Treaties/1961/07/19610702%2001-56%20AM/Ch_XI_B_11.pdf).


<sup>83</sup> Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр (ЕРА), 4 дүгээр бүлэг.

<sup>84</sup> ДХБ-ын Худалдааны бодлогыг хянан үзэх, 'Монгол Улсын худалдааны бодлого, 2021 (нэмэлт)', 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр, <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/WT/TPR/M406A1.pdf&Open=True>.

<sup>85</sup> МҮХАҮТ, 'Монгол Улсад Цахим нэг цонхыг хөгжүүлж буй байдал', хуудас 11–12, [https://www.unescap.org/sites/default/files/Session%202-2.%20Choidog%20Oyunjargal\\_MNCCI.pdf](https://www.unescap.org/sites/default/files/Session%202-2.%20Choidog%20Oyunjargal_MNCCI.pdf). MNCCI, pts 11–12.

<sup>86</sup> ДГБ, 'Хил дамнасан цахим арилжааг хөгжүүлэх стандартын тухай', 2022 оны 6 дугаар сар, [wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/facilitation/activities-and-programmes/ecommerce/wco-framework-of-standards-on-crossborder-ecommerce\\_en.pdf?la=en](https://wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/facilitation/activities-and-programmes/ecommerce/wco-framework-of-standards-on-crossborder-ecommerce_en.pdf?la=en). WCO.

**Зургаг 24:** Худалдааг хөнгөвчлөх, логикийн тэргүүлэх чиглэл (%)  
(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын - 92, хувийн хэвшлийн - 28)



- 1 Де-минимис гаалийн дэглэм (хамгийн бага бүрдүүлэлт, бага өртөгтэй тээвэрлэлтийн импортын хувьд татвар байхгүй)
- 2 Нэг цонх (бүрдүүлэлтийн бичиг баримтыг хил дамнанас худалдаачид нэг байршилд/ нэг хуулийн этгээдэд ирүүлэх боломжийг олгох)
- 3 Тээвэрлэлтийн зардал (гаалийн бусад татварыг оруулаад)
- 4 Худалдааг дэмжих байгууллага хоорондын уялдаа (яамд, агентлаг, бизнесийн холбоод хооронд)
- 5 НӨАТ/ Бараа, үйлчилгээний татвар / Борлуулалтын болон бусад холбогдох татварын мэдээлэл
- 6 Тээвэрлэлтийг цахимаар хянах
- 7 Хаягжилтын систем
- 8 Онлайн орчинд залилан хийх эрсдэлгүй эсхүл хамгийн бага байх
- 9 Гааль, шуудангийн мэдээлэлд цахимаар хандах (маягт бөглөх боломжийг оруулаад)
- 10 Үр ашигтай шуудангийн үйлчилгээ байгаа эсэх
- 11 Орон нутгийн тээврийн үр ашигтай сүлжээ
- 12 Онлайн орчинд төлбөр төлөх аргууд байгаа эсэх
- 13 Илгээмж хүргэх компани байгаа эсэх

Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Монгол Улсын тээвэр, логикийн гүйцэтгэл

Монгол Улс логикийн гүйцэтгэлийг сайжруулах боломжтой. Монголын төмөр замын хуучирсан дэд бүтэц, Номхон далайн боомтуудад, ялангуяа Хятадын Тяньжин боомтод хүрэх гол транзит шугамд ашигладаг цариг нь Хятадын төмөр замын царигтай нийцдэггүй, бага хурдтай, төмөр замын үнэ тарифын талаар өрсөлдөөн байхгүй, авто зам (дотоод тээвэр хамаарна), агаарын ачаа тээвэрт хангалтгүй байгаа нь логикийн зохицуулалтыг төвөгтэй болгодог.

Монгол Улсын дотоод болон хил дамнанас тээврийг ихэвчлэн авто болон төмөр замаар, ачааны багахан хувийг (ихэвчлэн хил дамнанас) агаарын тээврээр гүйцэтгэдэг. Хүргэлтийн зориулалтаар дотооддоо усан замын тээвэр ашиглах нь ховор. Тэд зөвхөн мөсгүй үед буюу 5 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд усан тээврийг ашиглаж болно.



Төмөр замын коридорын дагуу хүн ам суурьшсан, эдийн засгийн идэвхжил ихтэй хэдий ч төмөр замаар цахим арилжаагаар худалдаалж буй барааг жижиг, дунд оврын савлагаатай тээвэрлэхэд тохиромжгүй, одоогийн байдлаар хэрэглээ нь хязгаарлагдмал. Ийм савлагаатай барааг ихэвчлэн авто замаар тээвэрлэн хүргэдэг. КАРЕК-ын мэдээлснээр авто тээврээр тээвэрлэх гол шалтгаан нь зорьсон газартаа хүрэх хүртээмж сайтай, зардал багатай, хүргэлтийн хугацаа богино, тээвэрлэлтийн зохион байгуулалт илүү хялбар, илүү цаг алдалгүйгээр аюулгүй ажиллагааг хангах, мөн мөрдөх, мөшгих шийдлийн хувьд боломжтой, хөргөлтийн савтай байдаг гэжээ.

Сайжруулсан болон хатуу хүчилтэй авто замын уртыг аажмаар өргөтгөж байгаа хэдий ч замын хүртээмж, нөхцөл хангалтгүй хэвээр байгаа нь ашиглалт, хүрд зэрэгт нөлөөлж байна. . Монгол Улс 100 хавтгай дөрвөлжин км газар тутамд ердөө нэг км зам ногддог<sup>87</sup>. Монгол Улсад жижиг оврын савлагаатай барааг ихэнхдээ авто замаар тээвэрлэдэг тул цахим арилжааг хөгжүүлэхэд авто замын дэд бүтцийг тэр дундаа төр хувийн хэвшлийн түншлэлийн төсөл, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих зэрэг санаачилгаар дамжуулан сайжруулах нь чухал ач холбогдолтой. Замын дэд бүтцийг сайжруулснаар цахим арилжааны хил дамнан худалдаалж буй барааны хилээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг цаашид боловсронгуй болгон хөгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлж буй олон улсын авто тээврийн коридортой нэгтгэх хэрэгтэй.

Монгол Улсад 23 нисэх онгоцны буудал байдаг ч агаарын тээврийн чадавхыг бүрэн ашиглахгүй байна. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ агаарын тээврийн үйлчилгээг тусгайлан хөгжүүлэхийг зорьсон. Гэхдээ энэ салбарт өрсөлдөөн хязгаарлагдмал хэвээр байна.

Монгол Улсын эдийн засгийн тээврийн үйлчилгээний салбарын өрсөлдөх чадвар олон улсын өрсөлдөөн байхгүйгээс болж хоцрогдож байна. Монгол Улс ДХБ<sup>88</sup>-д элсэхдээ ямар нэгэн үүрэг амлалт хүлээгээгүй тул гадаадын логистикийн компаниудыг дотоодын зах зээлд нэвтрэхийг дэмжихгүй байна.<sup>89</sup>

Монгол Улсын “Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод логистикийн салбарт тулгарч буй өнөөгийн сорилтыг шийдвэрлэхээр тусгасан. Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоо, иргэний нисэхийн дэд бүтэц, иргэний нисэхийн агаарын тээврийг хөгжүүлэхийг тэргүүлэх ач холбогдолтой стратеги гэж тодорхойлсон. Мөн олон улсын стандартад нийцсэн холимог ачаа тээврийн зангилаа байгуулахаар тусгасан.

АНДЭЗК-оос Монгол Улсын хуурай боомтын талаар иж бүрэн үнэлгээ хийж, Монгол Улсын хуурай боомтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, зөвлөмж өгсөн, тухайлбал Монгол Улсын хуурай боомт болон БНХАУ-ын далайн боомтууд хооронд саадгүй холболт хийх, техникийн үнэлгээ хийж үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2022 оны 10 дугаар сард болсон семинарын үеэр ОХУ-тай Хуурай боомтын талаар Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах талаар Монголын оролцогч талуудад танилцуулсан<sup>90</sup>. Боомтын сэргэлтийн үндэсний хороог саяхан байгуулж, хилийн боомттой холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах болсон.

Агаарын тээврээр ирж буй илгээмж, тэдгээрт гаалийн бүрдүүлэлтийг хийхэд хугацаа их шаарддаг, төвөгтэй журам үйлчилдэг зэрэг нь цахим арилжаагаар худалдан авсан барааг хүргэхэд ихээхэн нөлөөтэй тул эдгээр арга хэмжээг хөнгөвчлөх зорилгоор журмыг дахин хянан үзэх шаардлагатай.

## Дотоодын хүргэлт

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар шуудангийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 145 аж ахуйн нэгж байдаг бөгөөд ихэнх нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг. 2016 онд төрийн өмчит Монгол шуудан компанийн хувьцааг олон нийтэд нэлтэй худалдсан бөгөөд “Монгол шуудан” ХК дотоодын хүргэлтийн 80 орчим хувийг, тэр дундаа Улаанбаатар хотоос гадна болон хөдөө орон нутагт хүргэж байгаа хүргэлтийн дийлэнх хувийг гүйцэтгэж байна. Энгийн шуудан, илгээмжийг (20 кг хүртэл жинтэй) Улаанбаатар хотод 2 хоногийн дотор, аймгуудад 12 хоногийн дотор тус тус хүргэдэг<sup>91</sup>.

Барааг хаалганаас хаалганд хүргэх, барааг авах боломжтой шуудангийн газар болон ухаалаг хайрцаг бүхий шуудангийн салбарт хувийн шуудангийн хайрцагт хүргэлт хийх зэрэг сонголт байдаг. Ачилтыг тусгай цахим (эсхүл компьютер) болон гар утасны платформ ашиглан хяналтын дугаараар мөшгөх боломжтой. Мөн цахим мессеж (SMS) илгээж хүргэлтийн талаар мэдэгддэг<sup>92</sup>. Дотоодын хүргэлтийн зах зээл дээр ажилладаг хувийн хүргэлтийн компаниуд Монгол шуудантай төстэй үйлчилгээний багцыг санал болгодог. Тэд ихэвчлэн Улаанбаатар болон томоохон хотуудад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр компаниуд заримдаа хөдөө орон нутагт хүргэлт хийхдээ Монгол шуудангийн үйлчилгээг ашигладаг. Тэдний зарим нь хэсэгчлэн (PickPack) эсхүл бүхэлдээ (Stora) дотоодын зах зээлд цахим арилжаа явуулдаг бизнестэй холбоотой ажилладаг.

Судалгаанд оролцсон хэрэглэгчид цахим арилжааны хүргэлтэд юуг онцлон үздэг талаар асуухад хурдан хүргэх нөхцөлийг чухал гэдгийг онцолж, (Зураг 25), мөн худалдан авсан бараагаа гэртээ хүлээж авах, өөрөөр хэлбэл “хаашаа ч явахгүйгээр дэлгүүрээс шууд хүргэлтээр авах” хүсэлтэй байдаг байна. (Зураг 26 ба Зураг 27). Иймд энгийн хүргэлт нь дотоодын цахим арилжааны цаашдын өсөлтөд хувь нэмэр оруулах чухал хүчин зүйл юм. Логистикийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал нь барааг орон нутаг

<sup>87</sup> Дэлхийн банк, ‘Монгол Улсын дэд бүтцийн салбарыг үнэлэх хөтөлбөр: Харилцан холбогдох ба эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц’ (Вашингтон, 2020 оны 11 сарын 10-ны өдөр), <https://doi.org/10.1596/34779>.

<sup>88</sup> Монгол Улс ДХБ-д нэгдэн орсон тухай, үүрэг амлалт- СХХХIV8, II хэсэг – Үйлчилгээний худалдааны талаарх үүрэг амлалтын жагсаалт, Дэлхийн худалдааны байгууллага, 1996 оны 6 дугаар сарын 27.

<sup>89</sup> НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал, Далайд гарцгүй хөгжиж буй зарим орнуудын эдийн засгийг төрөлжүүлэх: Бэрхшээл, бодлогын хувилбар ба ирээдүй (Бутан, Казахстан, Монгол ба Түркменистан) (Женев/Нью Йорк: Нэгдсэн үндэстний байгууллагын Худалдаа, хөгжлийн бага хурал, 2020).

<sup>90</sup> ‘Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр’, 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр, <https://www.unescap.org/resources/intergovernmental-agreement-dry-ports>; АНДЭЗНК, ‘Зүүн болон Зүүн Өмнөд Азийн тогтвортой уялдаа холбоо: Хуурай боомтыг хөгжүүлэх асуудлаарх Техникийн зөвлөлдөх үүлзэлт, 2022 оны 10 сарын 18-ны өдөр, <https://www.unescap.org/events/2022/sustainable-connectivity-east-and-north-east-asia-technical-consultation-workshop-dry>.

<sup>91</sup> ‘Монгол шуудан’, 2022 оны 12 дугаар сарын 1-ны өдөр, <https://mongolpost.mn:8088/dotood-shuudan/>.

<sup>92</sup> Хүргэлт 24, ‘Монгол шууданг мөшгөх нь | Монголын шуудангийн илгээмж, ачааны түгээлт’, 2022 оны 12 дугаар сарын 1-ны өдөр, <https://www.ship24.com/couriers/mongol-post-tracking>.

шуурхай хүргэхэд хүндрэл учруулж байгаа ч цахим арилжаагаар гүйлгээ хийж авсан бүтээгдэхүүнийг худалдан авагчдад шуурхай хүргэх зориулалттай бүсийн агуулах бий болгох зэрэг шийдэл хэрэгтэй.

**Зураг 25:** Та цахимаар бараа худалдан авахдаа хүргэлтийн нөхцлөөс юуг чухалчлан үздэг вэ? (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)


**Зураг 26:** Та ямар шалтгааны улмаас цахим арилжаа хийдэг вэ? (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

**Зураг 27:** Та бараагаа ямар нөхцлөөр хүлээн авахыг хүсдэг вэ? (%)

(Хэрэглэгчийн судалгаа, 151 хэрэглэгч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Хаягжуулалт

Хаягжуулалтын үндсэн зарчмыг Монгол Улсын Хаягжуулалтын тухай хуульд тодорхойлсон бөгөөд энэ хуульд заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн хаягт “гудамж, зам, талбай, хороолол, хотхон, хашааны нэр, дугаар, барилгын нэр, дугаар, болон хаалганы дугаар [...]” хамаардаг. Өөр хоорондоо уялдаа холбоогүй хоёр мэдээллийн сантай. Иргэдийн байнгын оршин суугаа хаягийн мэдээллийг Иргэний мэдээллийн нэгдсэн санд, харин хүлээн авагчийн утасны дугаар, шуудан зөөгчид туслахуйц “гурван үгээс бүрдэх” товчилсон хаягийн мэдээлэл нь Монгол шуудангийн мэдээллийн санд байдаг. Улаанбаатар хотын захын дүүрэг, хөдөө орон нутагт хүргэлт хийх нөхцлийг хөнгөвчлөх, хотын доторх хүргэлтийг хурдасгах зорилгоор өөрийн түншүүдийн тусламжтайгаар “гурван үгээс бүрдэх” товчилсон хаягийн мэдээлэл ашигладаг<sup>93</sup>. Хөдөө орон нутаг, гэр хороололд хүргэлт хийхэд тухайн газарт очиж хайлт хийх нь хугацаа их шаарддаг тул ерөнхийдөө үр ашиггүй байдаг.

### Хил дамнасан хүргэлт

Монголын хил дамнасан шуудангийн үйлчилгээний зах зээлийг тусгай зөвшөөрөлтэй 79 байгууллага гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрийн 4 нь (Монгол шуудан ХК, DHL болон UPS зэрэг) олон улс оронд үйлчилгээ үзүүлдэг бол зарим нь олон улсын шуудангийн үйлчилгээг зөвхөн сонгосон (Австрали Улс, БНХАУ, БНСУ, АНУ зэрэг)<sup>94</sup> улсад үзүүлдэг. Монгол шуудан ХК нь гадаадын 192 улсад хүч ажилладаг бөгөөд улс хоорондын шуудан, илгээмж хүргэлтийн зах зээлийн томоохон хувийг эзэмшдэг. Бүртгэлтэй болон буухиа шууданг сонгосон улс руу болон тухайн улсаас 4-8 хоногийн дотор агаарын тээврээр хүргэдэг. Тогтмол энгийн шуудан хүргэх хугацаа 14-21 хоног ба үүнээс их хугацаа зарцуулах үе байдаг. Олон улсын шуудангийн илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийхэд хугацаа их зарцуулж байгаа нь Монголын гаалийн байгууллагын ашигладаг Олон улсын шуудангийн төв (IMC)-ийн гаалийн бүрдүүлэлтийн журамтай холбоотой. Үүнийг цаашид хялбарчлах, өгөөжтэй байлгах боломжтой бөгөөд одоогоор

<sup>93</sup> Гурван үгээс бүрдэх товчлол, ‘Гурван үгээс бүрдэх товчилсон хаягаар хийх хүргэлтийн ахиц ба Монгол шуудан’, 24 May 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр, <https://what3words.com/news/government/mongol-post.what3words>.

<sup>94</sup> ХХЗХ, ‘Шуудангийн тусгай зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэлд дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй’, Харилцаа, холбооны зохицуулах хороо, 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, <https://www.crc.gov.mn/articles/shuudangiin-tusgaj-z-vsh-r-l-ezemshighch-azh-ahuj-negzh-dijn-teevriin-heregsl-dijg-dugaaryn-hyazgaarlaltaas-ch-l-l/mn>.

цахимжаагүй болно. Олон улсын шуудангийн төвийн ашигладаг UPost систем нь хүргэлтийн үйлчилгээ эрхлэгчдийн (Mongol Post, UPC, DHL зэрэг) ашигладаг системтэй нийцдэггүй тул мэдээллийг гараар бичиж оруулах шаардлагатай байдаг. Үүний зэрэгцээ төлбөр хийх, татвар төлөх үйл явцыг хэсэгчлэн хялбарчилж, нэхэмжлэхийг түргэн хариулт бүхий код ( QR code)-оор дамжуулан зарим хэрэглэгчид хүргэж, төлбөр тооцоог цахимаар хийхийг зөвшөөрдөг.

“Үл тооцох хувь буюу мөнгөн дүн”-ийн хэмжээг “Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам” (2014)-д заасны дагуу импортын бараанд ногдуулах татвар, дүрмээр тогтоосон.<sup>95</sup>

---

<sup>95</sup> Сангийн яам, ‘Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамг’, дугаар 269/264, (2014), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206713&showType=1>. MOF.

## 5. ТӨЛБӨРИЙН ШИЙДЭЛ

*Монгол Улсын хүн амын банкны үйлчилгээний хэрэглээ өндөр байгаа нь үндэсний хэмжээнд өргөн ашиглаж буй цахим банк, цахим хэтэвч зэрэг олон шийдэл бүхий цахим санхүүгийн үйлчилгээ, төлбөр тооцоо давамгайл байгаа байдлаас харж болно. QR код ашиглан төлбөр тооцоо хийх нь түгээмэл. Цахим төлбөр тооцооноос гадна Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги нь банкны хяналт, хөрөнгийн хүрэлцээтэй холбоотой асуудлыг шийдэхийг зорьж байна. Эдгээр алхам нь дотоодынхтай харьцуулахад гүйлгээ харьцангуй бага, гүйлгээний шимтгэл өндөр учраас олон оролцогч талууд хүндрэлтэй гэж үздэг хил дамнасан төлбөр тооцоог хийх аргыг бий болгож магадгүй. Тэдгээрийн ихэнх нь мөнгөн гуйвуулга хэрэглэдэг бөгөөд одоогоор хил дамнасан төлбөр тооцооны цөөхөн шийдэл байна.*

### 5.1 Монгол Улсын төлбөрийн системийн хууль эрх зүйн орчин, бодлого

#### Салбарын стратеги

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги нь асуудлыг цогц байдлаар авч үзэх 9 үндсэн зорилтын хоорондын уялдааг хангахад чиглэсэн, эдгээрээс I) хууль эрх зүйн тогтолцоо; III) жижиглэнгийн төлбөрийн систем; IV) Засгийн газрын төлбөр; V) валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл; VII) хил дамнасан төлбөр, түүний дотор олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; VIII) хяналтын тогтолцоо; IX) хамтын ажиллагааны хамрах хүрээ зэрэг нь цахим арилжаанд онцгой ач холбогдолтой. Уг стратеги нь үндэсний төлбөрийн системийн оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, бизнесийн болон засаглалын зохистой загварыг сонгох, эрсдэлийг удирдах, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам болон холбогдох яам, төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэгчид болон системийн операторууд хоорондын өмчлөл, хариуцлагыг бий болгох (нэгдмэл байдлыг хангах, эрсдэлийг удирдах, ил тод байдлыг хангах, зохистой засаглалыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх) зэргийг онцгойлон дурдсан.

Монгол Улсын Үндэсний төлбөрийн стратегийн өндөр түвшний зорилго, зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлтийг 5 дугаар хүснэгтэд харуулсан. Эдгээр нь Сингапурын худалдааны түнш оронтойгоо байгуулсан холбогдох дүрмийн хамгийн нарийвчилсан "кодчилол"-ыг хэрэглэдэг цахим эдийн засгийн хэлэлцээр (Дижитал эдийн засгийн тухай Сингапур, Австралийн хооронд байгуулсан хэлэлцээр-SADEA, Дижитал эдийн засгийн түншлэлийн тухай Чили, Шинэ Зеланд, Сингапурын хооронд байгуулсан хэлэлцээр-DEPA, Дижитал эдийн засгийн тухай Их Британи, Сингапурын хооронд байгуулсан хэлэлцээр-UKSDEA)-т заасан цахим төлбөрийн орчин үеийн зарчимтай ихэнхдээ нийцэж байгаа юм. Энэхүү цахим эдийн засгийн тухай хэлэлцээрийн цахим төлбөрт хамаарах заалтууд нь зохицуулалтын ил тод байдлыг хангах, төлбөр хийх дотоодын зохицуулалтыг оновчтой болгох, цахим төлбөр тооцоонд оролцож буй санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагыг хооронд нь ялгавартай авч үзэхгүй байх, нээлттэй платформын шийдлийг хөхиүлэн дэмжих, нээлттэй программ хангамж (OSS) болон Хэрэглээний программчлалын интерфейс (API) ашиглахыг дэмжих, хил дамнасан баталгаажуулалт болон харилцагчийн хувийн мэдээллийг таньж, баталгаажуулах үйл ажиллагаа (KYC) (жишээлбэл, Олон улсын хэмжээнд хуулийн этгээд таниулагчийн сан (GLEIF)<sup>96</sup>-аар дамжуулах); эрсдэлд суурилсан зохицуулалтын хандлагыг дэмждэг. Олон улсын стандартын тухайд, Олон улсын стандартчиллын байгууллагын ISO 20022 стандарт, санхүүгийн салбарын бүх нийтийн мессеж солилцох схем (Universal Financial Industry Message Scheme) -ийг ашиглахыг Дижитал эдийн засгийн тухай Сингапур, Австрали улсын хооронд байгуулсан хэлэлцээр (SADEA) санал болгож, цахим төлбөр тооцоо хоорондоо харилцан уялдаатай байхын тулд санхүүгийн байгууллага, үйлчилгээ нийлүүлэгчид хоорондоо цахим мэдээлэл солилцохыг зөвлөдөг.

<sup>96</sup> Хуулийн этгээдийг тодорхойлогч дэлхийн холбоо (GLEIF), 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, <https://www.gleif.org/en/>.

**Хүснэгт 5:** Монгол Улсын 2022-2026 он хүртэлх үндэсний төлбөрийн стратеги: Өндөр түвшний зорилго, зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлт<sup>97</sup>

Өндөр түвшний зорилго	Зорилтот түвшин болон шалгуур үзүүлэлт
Эдийн засгийн бүхий л оролцогч талууд (Засгийн газар, аж ахуйн нэгжүүд, иргэд, санхүүгийн байгууллагууд) түргэн шүүрхай, аюулгүй, найдвартай төлбөрийн үйлчилгээ авна.	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын мөнгөн гүйвүүлга, хил дамнасан жижиглэнгийн гүйлгээний үр ашгийг нэмэгдүүлэх, хураамж шимтгэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх.</li> </ul>
Монгол Улс цахим төлбөрийн хэрэгсэл болон финтекийн хэрэглээг түгээн дэлгэрүүлснээр бэлэн мөнгөний хэрэглээ багатай нийгэм рүү шилжилт хийнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Бэлэн мөнгөний харьцааг М2 болгон бууруулах</li> <li>Орон нутаг дах үйлчилгээ авах цэгүүдийн тоог өсгөж төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (алслагдсан бүс нутагт).</li> <li>Орон нутаг дахь ПОС терминал, цахим мөнгө хүлээн авагчийн тоог 40 хүртэл хувиар өсгөж, цахим төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;</li> <li>Засгийн газрын төлбөр тооцоо цахимжиж, Үндэсний төлбөрийн системд нэгдсэн байх</li> <li>Цахим төлбөрийн үйлчилгээг Монгол Улсын нийт хүн амд хүртээмжтэй болгож, хэрэглээг нэмэгдүүлэх</li> </ul>
Үр ашигтай, аюулгүй, нэгдмэл байдлыг хангасан, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тасралтгүй, найдвартай ажиллагаа бүхий төлбөр тооцооны дэд бүтэцтэй болно.	<ul style="list-style-type: none"> <li>Цахим эрсдлийг удирдах олон улсын стандартыг нэвтрүүлэх</li> <li>Системийн хувьд нэн чухал бүх дэд бүтцүүд болон бусад холбогдох улсын стандартыг хангаж байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийх</li> <li>Валютын арилжааны төлбөр тооцоог Төлбөрийн эсрэг төлбөр (ТЭТ) зарчмын дагуу хийж, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах</li> <li>Төлбөр тооцооны одоо байгаа болон шинэ систем (платформ), төлбөрийн хэрэгслийн харилцан зохицолдоог хангах</li> </ul>
Хууль тогтоомж, дүрэм журам нь тэнцвэртэй, төлбөрийн систем, хэрэглэгчийн эрхийг хамгаалж, төлбөрийн үйлчилгээний өрсөлдөөн, инновацийг дэмжинэ.	
Эрх бүхий байгууллагууд төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ, хэрэгсэлд үр дүнтэй хяналт тавина.	
Төлбөрийн системийн экосистем дэх бүх оролцогч талууд хамтран ажиллаж, шинэчлэлийг хийнэ.	


Эх сурвалж: Монголбанк.

## 5.2 Монгол Улсын төлбөр тооцооны ерөнхий зохицуулалт

Судалгаанд оролцогч бүх талууд дотоодын болон хил дамнасан цахим төлбөр тооцоог цаашид хөнгөвчлөх хэрэгтэй гэж үзсэн. (Зураг -28 ).

<sup>97</sup> Үндэсний төлбөрийн системийн стратеги 2022-2026.

**Зураг 28:** Төлбөрийн шийдэлтэй холбоотой энэ тэргүүнд хийх үйл ажиллагаа (%)  
(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 91, хувийн хэвшлийн 26)



- 1 Олон улсын цахим (мобайлыг оруулаад) төлбөрийг зөвшөөрдөг зохицуулалт
- 2 Дотоодод цахим (мобайлыг оруулаад) төлбөрийг зөвшөөрдөг зохицуулалт
- 3 Янз бүрийн цахим төлбөрийн горимын өөр хоорондоо харилцан үйлчилж, ажиллах чадвар
- 4 Аюулгүй байдал, итгэлцлийг бий болгох боловсролын санаачлага, ж нь, бодлого боловсруулагчид, банк, худалдаачид, хэрэглэгчид зориулсан.
- 5 Мөнгө угаахын эсрэг, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хууль тогтоомжийн талаарх ойлголт
- 6 Найдвартай кибер хамгаалалт, итгэлцлийг бий болгох үйлчилгээ
- 7 Онлайн санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг хэрэглэгчдийг хамгаалах зохицуулалт
- 8 Цахим болон мобайл төлбөрийн олон улсын сайн туршлагын талаарх мэдлэг
- 9 Төлбөрийн үйлчилгээ (финтек) эрхэлдэг банк бус байгууллагад хамаарах зохицуулалт
- 10 Цахим төлбөрийн инновацийг дэмжих (жишээлбэл, тохируулагч нарын хяналтан дор шинэ санааг тодорхой хугацаанд, шууд турших боломжийг олгодог sandbox хэмээх аргаар дамжуулан)
- 11 Банканд данс нээх явцыг хялбарчлах

Эх сурвалж: НУБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Санхүүгийн салбарт мөрдөж буй үндэсний хууль тогтоомж

Монгол Улсын төлбөрийн систем нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль (2017), Төв банкны тухай хууль (1996), Банкны тухай хууль (2010), Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002), Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009), Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай (2021), Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013); түүнчлэн Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль (2018) зэрэг олон хуульд үндэслэсэн байдаг. Эдгээрийн зарим нь нэмэлт, өөрчлөлт болон хуулийг хэрэгжүүлэх олон журамтай. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр банк бус санхүүгийн үйл ажиллагааг хялбаршуулсан эрх зүйн орчныг бий болгох хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, 2023 онд багтаан батлуулах хүлээлттэй байна.<sup>98</sup> Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хувийн нууцыг хамгаалахад чиглэсэн хэд хэдэн хууль эрх зүйн актыг боловсруулж байгаа гэж мэдээлжээ.

<sup>98</sup> Энэ хуулиар үндсэн үйл ажиллагаа (зээл олгох, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх зэрэг) эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ нь хоёрдогч үйл ажиллагаа (жишээ нь: мөнгөн гуйвуулга, санхүүгийн түрээс, санхүүгийн хэрэгсэл



Цахим төлбөр тооцооны хууль эрх зүйн орчны талаар судалгаанд оролцогч талуудын мэдлэг дутмаг байна. Төрийн байгууллагын оролцогчдын дөнгөж 29 хувь нь, хувийн хэвшлийн оролцогчдын 36 хувь нь цахим арилжааны судалгаанд хамрагдаж, холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байв. Гэхдээ эдгээр оролцогчдын ихэнх нь холбогдох эрх зүйн баримт бичгийн нэрийг дурдаж чадаагүй.

### **5.3 Институцийн тогтолцоо, оролцогч талын хамтын ажиллагаа**

Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратегид Монголбанкны манлайллын дор бүх оролцогч талууд хамтран зөвшилцлийн зарчмаар ажилладаг болохыг онцолжээ. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ), Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) зэрэг байгууллага төлбөр тооцооны чиглэлээр зохицуулагч чиг үүрэгтэй оролцдог. Цахим төлбөр тооцоо хийхтэй холбоотой асуудлаар хэрэглэгчид зарим үед ШӨХТГ-т ханддаг боловч тухайн байгууллагын цахим төлбөрийн үйлчилгээтэй холбоотой гүйцэтгэх үүрэг нь тодорхойгүй, дэд бүтцийг нь Монголбанк хүлээн зөвшөөрөөгүй байдаг, гэхдээ хэрэглэгчид төлбөр тооцоонд хамаарах дүрэм журамд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн гэж үздэг. Бусад агентлагийн зохицуулалтын хүрээнд давхцал байдаг а) банк бус санхүүгийн байгууллага (Монголбанк, СЗХ) болон б) мобайл төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч (Монголбанк, СЗХ, ХХЗХ). Ийм үйлчилгээ үзүүлэгчдийн нэг болох Мобиком Корпорацийн үүсгэн байгуулсан МобиФинанс ББСБ зөвлөгөөний үеэр “гүрвалсан” тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж баталгаажсан байна. Цахим худалдааны домэйн дэх цахим төлбөр тооцоонд ихээхэн хамааралтай эдгээр давхцлыг арилгаж, холбогдох байгууллагууд (Монголбанк-СЗХ, Монголбанк-СЗХ-ХХЗХ) хоорондоо санамж бичиг байгуулж, Монголбанкны ерөнхий удирдлагын хүрээнд байгууллага тус бүрийн чиг үүргийг тодорхой болгожээ. Гэхдээ энэхүү санамж бичиг нь дотоод баримт бичиг бөгөөд энэ чиглэлээр стандарт, дүрэм журмын зохицуулалт байхгүй хэвээр байгаа нь ил тод, тодорхой байх байдалд нөлөөлж байна.

Үүний зэрэгцээ төлбөрийн системийн зохицуулагчид болон төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэгч, оператор зэрэг бусад оролцогчдын хамтын ажиллагаа хязгаарлагдмал хэвээр байгаа бөгөөд Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн (2017) 9 дүгээр зүйлд заасны дагуу 2018 онд Монгол Улсын Банкны Ерөнхийлөгчийн тогтоолоор байгуулсан Төлбөрийн системийн үндэсний зөвлөлөөр дамжин хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг. Үндэсний зөвлөлд Монголбанк, арилжааны банк, Сангийн яамны Төрийн сангийн хэлтэс, СЗХ, ХХЗХ, МХБХ, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны төлбөр тооцооны төв ХХК, Монголын банкны холбоо, Монголын банк бус байгууллагуудын төлөөлөл<sup>99</sup> оролцог. Банк бус санхүүгийн байгууллагууд, түүнчлэн төлбөрийн системийн оролцогч, операторын төлөөлөл, хэрэглэгчийн бүлгүүдийн хүрээнд зөвлөлдөх, түршлага хуваалцах механизм байхгүй.

### **5.4 Цахим арилжааны төлбөр тооцооны дэд бүтэц**

Монголбанк цахим төлбөр тооцоог хурдан, аюулгүй, үр ашигтай болгохын тулд хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тодруулбал, Монголбанкны дэргэдэх Цахим гүйлгээний үндэсний төв (ЦХҮТ)-өөс орчин үеийн шинэ Автомат клиринг хаус (ACH+)-ийн системийг нэвтрүүлсэн. Энэхүү систем нь бага дүнтэй цахим төлбөрийг дангаар нь эсхүл багцаар нь бодит цаг хугацаанд, тасралтгүй (24/7) гүйцэтгэдэг. Бодит цаг хугацаанд гүйцэтгэснээр мөнгийг хүлээн авагчийн дансанд нэн даруй бэлэн болгож, эцсийн төлбөр тооцоог бодит цагийн горимоор, нэг бүрчлэн гүйцэтгэх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ систем (RTGS)-ийг удахгүй нэвтрүүлнэ. Банк хоорондын төлбөрийн картын шилжүүлэгчийг Цахим гүйлгээний үндэсний төв (NETC) болон Худалдаа хөгжлийн банк (ХХБ) өөрсдийн болон 5 салбар банканд ашиглаж байна. Хоёр системд тухайн гүйлгээг цэвэр дүнгээр хийгдэж, эцсийн

---

гаргах, худалдан авах, худалдах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх зэрэг) эрхлэх боломжтой бөгөөд заавал бүрэн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах шаардлагагүй. Энэ нь ББСБ-үүдийн үйл ажиллагааг хялбарчлахаас гадна Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг мөнхлалт байгаа юм. Төслийг ЕСБХБ дэмжиж, ЕХ-ны Азийн хөрөнгө оруулалтын сангийн нэгдмэл, иж бүрэн чөлөөт худалдааны бүсийн хөтөлбөр (DCFTA) -өөс санхүүжүүлж байгаа болно.

<sup>99</sup> Монгол банк, ‘Төлбөрийн систем’, Монгол банкны сайт, 2022 оны 12 сарын 1-ний өдөр, <https://www.mongolbank.mn/eng/>.

тайлан нь Банкны сүлжээ системээр дараагийн өдөр нь гардаг. Монголбанк токен (token) дээр суурилсан боловсруулалтыг нэвтрүүлэх асуудлыг авч үзэж байгаа. Цахим болон бусад аюултай нөхцөл байдал үүссэн үед төлбөрийн системийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг нэмэгдүүлэх, мөн шинэчлэлт хийх арга хэмжээг авч байна. Арилжааны банк өөр хоорондоо гадаад валют арилжаалах, Монголбанкнаас боловсруулсан FX цахим арилжааны системээр дамжуулан Монголбанк Төлбөрийн эсрэг төлбөр /ТЭТ/ зарчмаар гадаад валют арилжаалах замаар валютын зах зээлийг либералчилж байна. Системийн шинэчлэлийг хийж байгаа болно.

### **5.5. Монгол Улсын санхүүгийн салбарын онцлог**

Монгол Улсын хүн амын банкнаас үйлчилгээ авах хувь маш өндөр бөгөөд (15-аас дээш насны) эмэгтэйчүүдийн 99 хувь, эрэгтэйчүүдийн 98 хувь нь банканд данстай байна<sup>100</sup>. Монголын банкны салбарт системийн ач холбогдол бүхий 11 банкттай. Эдгээрээс 5 банк нь Худалдаа, хөгжлийн банк (ХХБ)-тай, тэр дундаа кредит картын чиглэлээр хамтран ажилладаг. Монголын бүх банк тус тусдаа вэбсайтаар бөгөөд интернэт банкны портал, гар утасны банкны программ, мэдээллийг машинаар маш түргэн хугацаанд олох болон унших арга бүхий QR код (QRPay) төлбөрийн сонголтуудтай. Мөн зарим банкнууд ХХБ-ны MostMoney эсхүл WeChat зэрэг худалдааны байгууллагын бүртгэлтэй механизмыг зах зээлд нэвтрүүлж, бүртгэлтэй хэрэглэгчдээс (Капитрон банк, Трансбанк) төлбөр хүлээн авах боломж бүрдүүлж, төлбөр тооцоог дэмжсэн сонголт бий болгосон. Ай Эн Жи (ING), Сумитомо Мицуй Банк (Sumitomo Mitsui bank), Токио Митцубиши Банк (Tokyo Mitsubishi bank), Хятадын Банк (Bank of China), Хятадын Аж үйлдвэр, худалдааны банк (Industrial and Commercial Bank of China) зэрэг гадаадын 5 банк Монголд төлөөлөгчийн газартай<sup>101</sup>. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2022 оны наймдугаар сарын байдлаар Монголын зах зээлд 527 ширхэг ББСБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба 83 хувь нь Улаанбаатар хотод байна. Банк бус санхүүгийн 36 байгууллага төлбөрийн үйлчилгээнд нэгджээ.

### **5.6. Төлбөрийн хэрэгсэл**

Монгол Улсад бэлэн болон бэлэн бус төлбөрийн 2 хэрэгслийг ашигладаг бөгөөд Ковид-19 цар тахлын дараа бэлэн бус төлбөрийн хэрэгслийг ашиглах байдал давамгайлж эхэлсэн. Үүнтэй зэрэгцээд арилжааны банкны үйлчилгээ хөгжсөн. Монгол Улсын иргэний хуулийн (2002) 445.3 дугаар зүйлд заасны дагуу бэлэн бусаар төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон бусад хэрэгслээр гүйцэтгэж болно. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, системийг ажиллуулах зөвшөөрөл олгох, эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд (2021) заасны дагуу Монгол Улсад дараах төлбөрийн үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгодог. Үүнд: мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг; Төлбөрийн карт олгох /Карт дээр нэрийг бичих/ Төлбөрийн карт хүлээн авах (2022 оны 9 дүгээр сарын байдлаар 17 үйлчилгээ үзүүлэгч байна), Цахим мөнгө гаргах (7 үйлчилгээ үзүүлэгч байна), Системийн үйлчилгээ (1 үйлчилгээ үзүүлэгч байна), Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх, Аутсорсингийн үйлчилгээ авах, Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зэрэг болно<sup>102</sup>.

### **5.7. Дотоодын төлбөр тооцоо**

<sup>100</sup> Дэлхийн банкны групп, 'The Global Findex Database 2021', Text/HTML, 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, <https://www.worldbank.org/en/publication/globalfindex/Data>;


Азийн хөгжлийн банк, Монгол Улсын эдийн засгийн төлөв: Хоёр их гүрний дунд орших байгалийн баялагтай ба далайд гарцгүй орон (Азийн хөгжлийн банк, 2020), <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>.

<sup>101</sup> 'Монгол Улсад хөрөнгө оруулагчдад зориулсан гарын авлага', 2020, <https://investmongolia.gov.mn/wp-content/uploads/2021/03/investment-guide-2020.pdf>.

<sup>102</sup> Монгол банк, 'Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, системийг ажиллуулах зөвшөөрөл олгох, эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам' (2021), <https://www.mongolbank.mn/documents/regulation/2021/paymentservice.pdf>.

Хэрэглэгчид болон бизнес эрхлэгчид дотооддоо төлбөр тооцоо хийхдээ тэдэнд байгаа боломжит олон төрлийн аргыг ашигладаг. Улаанбаатар хотоос илүү аймаг, орон нутагт бэлэн мөнгийг хэрэглэсэн хэвээр байгаа боловч цахим худалдааны бэлэн байдлын судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 15 хувь нь өөрсдийн хүссэн төлбөрийн хэрэгсэл ашиглажээ. (Зураг 29). Цахим төлбөр тооцоог илүү өргөн ашиглахад нэмэлт хураамж авдаг нь саад болдог гэж зарим оролцогч дурдсан байв. Цахим худалдааны бэлэн байдлын судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 68 хувь, ялангуяа Улаанбаатар хотоос бусад орон нутагт цахим арилжаа хийхдээ урьдчилж төлөхөөсөө илүү дараа нь төлөхийг илүүд үздэг байна.

**Зураг 29:** Хэрэглэгчийн илүүд үздэг төлбөрийн хэрэгсэл (%)  
(Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НУБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Интернэт банк болон Хөдөлгөөнт үүрэн холбооны (Mobile) банк

Монгол Улсын бүх арилжааны банк цахим болон Mobile банкны хэрэглээний программыг санал болгодог бөгөөд эдгээрийг их түгээмэл ашиглаж байна. Монголбанкны мэдээгээр, хэрэглэгчдийн 90.2 хувь нь гар утаснаас, ердөө 9.8 хувь нь компьютерээр дамжуулан эдгээр үйлчилгээг авдаг аж. 2020 оны 3 дугаар сард гүйлгээг хөнгөвчлөх зорилгоор олон улсын банкны дансны дугаар (IBAN)-т нийцсэн шинэ стандартыг баталсан. Эдгээр стандартад нийцсэн шилжилт хөдөлгөөнийг 2024 он гэхэд дуусгана. Аж ахуйн нэгж, байгууллагууд харилцагчтай хийх гүйлгээг хялбар болгохын тулд банкны хэрэглээний программаас хөдөлгөөнт үүрэн холбоо (Mobile)-ны үйлчилгээг тусгайлан харуулах түншлэлийн гэрээг банктай байгуулж байна. Энэ төрлийн түншлэлийн гэрээг Улаанбаатар хотод 926, бусад аймагт 97-г тус тус байгуулжээ.

### Цахим хэтэвч


Улаанбаатар хотод бусад аймгийг бодвол илүү олон хэрэглэгч цахим арилжаанд цахим хэтэвч ашигладаг. Тэдгээрээс дурдвал Голомт банкны SocialPay, Мобиком Корпорацийн MonPay, Худалдаа хөгжлийн банк (ХХБ)-ны MostMoney, QPay, HiPay, Databank-ны Pass буюу төлбөрийн картын үйлчилгээний шийдэл хөгжүүлэгчийн Pass аппликэйшн; AND Global-ийн LendMN болон SuperUp зэрэг. Мобайл банкны апп буюу хэрэглээний программтай харьцуулахад дотроо хэд хэдэн төлбөрийн картыг нэг дор нэгтгэж, зарим талаар төлбөр тооцоог илүү саадгүй хийх боломжтой зэрэг олон нэмэлт үйлчилгээ бүхий эдгээр хэрэглээний программ хангамжийг нэвтрүүлэхэд дараах ялгаатай хууль эрх зүйн орчин Монгол Улсад үйлчилж байна<sup>103</sup>.

- Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл: MonPay; LendMN, SuperUp, and HiPay;
- Төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл: QPay, Pass;
- Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх тусгай зөвшөөрөл: QPay, MostMoney.

## Төлбөрийн карт (дебит, кредит, урьдчилсан төлбөрт карт, үндэсний төлбөрийн карт (T-card), хамтын брэндийн кредит карт)

Монголбанкны 2022 оны хоёрдугаар улирлын мэдээгээр 4.4 сая ширхэг төлбөрийн карт гүйлгээнд ашиглаж байна. Монголбанкны мэдээгээр Монгол Улсад хэрэглэдэг хамгийн түгээмэл төлбөрийн хэрэгсэл бол дебит карт (Зураг 30). Одоогоор UnionPay (22.6 хувь), Visa (17.3 хувь), Мастер карт (3.2 хувь), Amex (0.1 хувь), JCB (0.2 хувь), Үндэсний төлбөрийн карт (56.6 хувь, EMV чипийг нэвтрүүлэх замаар олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлсэн) хэрэглээнд байгаа бөгөөд Үндэсний төлбөрийн карт нь зах зээлд тэргүүлэх байр суурьтай байна (Монголбанкны мэдээгээр энэхүү карт нь 2020 онд нийт картын хэрэглээний 63.6 хувьд хүрсэн). Хамтын брэндийн кредит карт (олон улсын + дотоодын карт гаргагч нар) мөн үйлчилгээнд нэвтэрсэн. Бусад тусгай төрлийн картад төлбөрийн карт ба лоялти үнэнч хэрэглэгчийн карт (loyalty card), хосолсон карт (жишээ нь, ХХБ болон Mint клуб нарын хамтарсан брэндийн кредит карт), олон валютын карт (жишээ нь, ХХБ-ны нэг картад гурван төрлийн валютыг нэгтгэсэн карт), хүүхдэд зориулсан тусгай карт, бэлгийн карт болон QR кодтой картууд багтана (хялбаршуулсан төлбөрийн баримт хүлээн авах боломжтой). Пин кодгүй, түүний оронд хамгаалагдсан CVV код бүхий онлайн төлбөрийн хэлбэр нээгдсэн. Мөн КОВИД-19 цар тахлын үед **цахим**, зайнаас төлбөр тооцоо хийх боломжийг **бүрдүүлсэн**.

**Зураг 30:** Үндэсний дебит болон кредит картын хэрэглээнд орсон эргэлт, 2019-2021




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн картыг ПОС терминал буюу цахим мэдээ үүсгэгч (хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаа), гар утасны аппликейшн, цахим банк, Бэлэн мөнгөний автомат теллер машин (АТМ)-аар дамжуулан шилжүүлэг, төлбөр тооцоо хийх (ялангуяа нийтийн үйлчилгээний төлбөрийг төлөх) зэрэгт ашигладаг. Цахим арилжаанд төлбөрийн картаар хийсэн гүйлгээний тоо өссөөр байна (Зураг 31).

**Зураг 31:** Цахим арилжаанд оролцохдоо төлбөрийн картаар хийсэн гүйлгээ, мянгаар

<sup>103</sup> Монголбанк, 'Төлбөрийн систем', Монголбанк, 2022.10.19, <https://www.mongolbank.mn/documents/paymentsystems/zuvshuurul.pdf>. Монголбанк.



Эх сурвалж: МонголБанк

### QR Pay (буюу QR кодыг ашиглан дансаар төлбөр хүлээн авах, шилжүүлэх үйлчилгээ)

Монголбанкны мэдээгээр, Монгол Улсад QR кодоор хийсэн төлбөр тооцоо 2019 онд 3.8 сая гүйлгээ байсан бол 2021 онд 21.3 сая болж өсчээ.

Хувийн компанийн боловсруулсан QR код дээр суурилсан Qpay хэмээх цахим төлбөрийн шийдлийг арилжааны бүх банк ашигладаг бөгөөд худалдаа эрхлэгчид ашиглаж эхэлж байна. Мөн зарим банк худалдаа эрхлэгчдэд зориулан WeChatPay-ээр дамжуулж төлбөр хүлээн авах боломжийг олгоод байна. Монголбанкны мэдээгээр одоо ашиглаж буй QR кодыг хэрэглэх үндэсний стандарт байхгүй, харилцан хоорондоо ажиллах боломжгүй байгаа бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд үндэсний стандартыг боловсруулж байна.

### 5.8. Хил дамнасан төлбөр тооцоо

Монголчуудын хувьд хил дамнасан төлбөр тооцоо хийхэд илүү төвөгтэй, саад бэрхшээлтэй, зардал өндөр байдаг.

Гадагшаа чиглэсэн төлбөр тооцоог ихэвчлэн кредит картаар хийдэг бөгөөд ийм төрлийн гүйлгээ нь нэлээд өндөр хураамжтай. ХХБ-аас карт эзэмшигчиддээ зориулан Visa картын бизнесээс бизнест (Visa B2B Connect) чиглэсэн үйлчилгээг үзүүлж байна. Тус улсаас мөнгө шилжүүлэхэд PayPal болон зарим цахим хэтэвчийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь Монголчууд гадаадын цахим арилжааны платформ дээрээс худалдан авалт хийх боломжийг бий болгосон. Мөн арилжааны банкуудын мөнгөн гуйвуулга ашиглан гадаад руу мөнгө шилжүүлэх боломжтой.

Дотоодын төлбөр тооцоонд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ давамгайлдаг. Бүх банкнаас үзүүлж буй үйлчилгээг ихэвчлэн 18 улсад байрладаг корреспондент банкны SWIFT (Олон улсын банк хоорондын санхүүгийн цахилгаан холбооны нийгэмлэг) сүлжээгээр дамжуулан хийдэг. Солонгос улсаас мөнгө гуйвуулах тохиолдолд Contact or PayEasy зэрэг мөнгөн гуйвуулгын өөр хувилбар бүхий механизм ашиглахыг дотоодын зарим банк санал болгодог. Европын Холбоо болон Сингапураас мөнгөн гуйвуулга хийх бол Wise, MoneyGram, Western Union, Remitly, зарим сонгосон орнуудаас мөнгөн гуйвуулга хийх XE зэрэг гадаад мөнгөн гуйвуулгын хэд хэдэн үйлчилгээг Монголчууд ашиглах боломжтой байдаг. Монголбанкны мэдээгээр, Stripe эсхүл PayPal-ийг Монгол Улсад ашиглах, хил дамнасан төлбөр тооцооны зах зээлд нэвтрүүлэх талаар хэлэлцээ үргэлжилж байна.

### 5.9. Монгол Улсын санхүүгийн салбар дахь цахим гүйлгээ, дэвшилтэт технологийн хэрэглээ

Цахимаар таньж баталгаажуулах буюу тоон гарын үсгийг Монголын банкны салбарт хязгаарлагдмал түвшинд хэрэглэж эхэлсэн байна. Саяхан баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2020 он)”-ийн 7 дугаар зүйлд “банкууд зөвхөн цаасан хэлбэр буюу бичгээр гэрээ байгуулж данс нээлгэсэн харилцагчид холбогдох санхүүгийн үйлчилгээг үзүүлж болох” бөгөөд “Банк, эрх бүхий хуулийн этгээд дансгүй, эсхүл банктэй санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээдэд цахим хэлбэрээр аливаа данс нээхийг хориглоно” гэж заасан. Бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр данс нээлгэсний дараа “цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нүүцлалын шаардлага хангасан нүүц үг, нүүц код, тоон гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ” гэж заажээ. ББСБ-ууд мөн энэ туршлагыг хэрэгжүүлж эхэлж байна. Монголбанкны мэдээгээр хэрэглээний программчлалын интерфейс буюу API-г банк болон ББСБ аль аль нь Монгол Улсын санхүүгийн үйлчилгээний салбарт эрчимтэй ашиглаж эхлэж байгаа боловч албан ёор хууль эрх зүйн хувьд зохицуулалтгүй буюу стандарт тогтоогоогүй. Open banking буюу хэрэглэгчийн банкны мэдээллийг бусад банк, гуравдагч этгээдтэй хуваалцах зохицуулалт байхгүй. Саяхан Олон улсын төлбөр тооцооны банкны (Bank for International Settlements-BIS) дүрьдсанаар, "харилцан холболтын зохицуулалт нь банкууд болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг тухайн ижил төлбөрийн системд оролцох эсхүл дундын зүүчлагчийг (жишээ нь, корреспондент банк) ашиглах шаардлагагүйгээр, өөр хоорондоо гүйлгээ хийх боломжийг олгодог."<sup>104</sup> Цахим төлбөр тооцоог хөнгөвчлөх, дотоодын зах зээл дээр байгаа [цахим платформын] харилцан уялдаатай ажиллахг шийдвэрлэхээс гадна, API нь Монгол Улсын оролцогч талуудын хүсэн хүлээж буй, илүү зардал багатай, үр ашигтай хил дамнасан төлбөр тооцооны шийдэлд хүрэхэд тулгарч буй бэрхшээлийг хурдан шийдвэрлэж ашигтай нөхцөлийг бий болгох магадлалтай.

---

<sup>104</sup> Олон улсын төлбөр тооцооны банк, “Төлбөрийн системийг хооронд нь холбох ба хэрэглээний программчлалын интерфейсний үүрэг: Хил дамнасан төлбөрийн тогтолцоо”, G20-д гаргах тайлан, 2022,07, 1, <https://www.bis.org/cpmi/publ/d205.pdf>. Олон улсын төлбөр тооцооны банк, 1

## 6. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

Монгол Улс “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай” НҮБ-ын конвенцид нэгдэж мөн мэдээллийг нээлттэй болгох дүрмийг зохицуулсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай шинэ хуулиудыг баталж, түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай зэрэг хуулийг шинэчлэн найруулж баталснаар цахим арилжаатай холбоотой хууль тогтоомжийг шинэчилж, үр өгөөжийг нь хүртэж байна. Эдгээр шийдлийг олон улсын шилдэг туршилагад үндэслэн хэсэгчлэн тусгажээ.


2022 оны 5 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн шинэ хуулиуд болон цахим арилжаатай холбоотой бусад эрх зүйн актууд бүрэн хэрэгжиж эхлээгүй байна. Төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудын аль аль нь одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн бүтэц, хамрах хүрээний талаар мэдлэг хомс байна. Холбогдох салбарын бүх оролцогч талууд Цахим гарын үсгийг хэрэгжүүлэхийг нэн тэргүүний ач холбогдолтой гэж үзэв.

### 6.1. Монгол Улсын цахим арилжааны дүрэм

2016 оноос хойш УИХ-ын дэргэд ажиллаж байсан Цахим бодлогын түр хороог 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдөр УИХ-ын Инноваци, цахим бодлогын байнгын хороо болгон шинээр байгуулсан. Тус хороо нь цахим засаглалын бодлого, түүнийг хэрэгжүүлэх, тэдгээрийн хөгжлийг дэмжсэн хууль тогтоомжийг боловсруулах үүрэгтэй. Цахим гарын үсгийн тухай хууль (шинэчлэн найруулсан), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (шинэ), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (шинэчлэн найруулсан), Кибер аюулгүй байдлын тухай хууль (шинэ), Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль (шинэ) гэсэн таван шинэ болон шинэчлэн найруулсан хуулийг 2021 оны 12 дугаар сард батлуулсан. Тус хороо байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагаагаа ил тод байлгаж, хуралдааны тэмдэглэлийг цахим хэлбэрээр тогтмол нийтэлж байна.

Оролцогч талуудын дунд явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд цахим арилжааны хууль тогтоомжийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг ялангуяа төрийн байгууллагын оролцогчдын дөнгөж 10 орчим хувь нь энэ талаар ойлголттой байв. (Зураг 32).

**Зураг 32:** Цахим арилжааны хууль тогтоомжийн талаарх төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын ойлголт мэдлэг (%) (Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 91, хувийн хэвшлийн 24)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)



Олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхийн тулд, холбогдох хууль тогтоомжийг нийтэд түгээх, (цаашид) санал болгож буй эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн саналыг авах зориулалттай нэгдсэн платформ бүхий legalinfo.mn хэмээх цахим хуудсыг ашиглах зэргээр Монгол Улс ахиц дэвшил гаргасан.

## **6.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон бүс нутгийн цахим арилжааны дүрэм**

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт (1992 онд батлагдаж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан. Монгол Улс цахим арилжааг хөгжүүлэхэд түлхэц болсон олон улсын хэд хэдэн гэрээ, хэлэлцээрт нэгдсэн бөгөөд заримд нь саяхан нэгдсэн. Гэвч цахим арилжааг хөгжүүлэх сүүр үндсийг бий болгож буй олон улсын хууль тогтоомжийг бүрэн дүүрэн ашигладаггүй бөгөөд эдгээр нь зарим талаараа Монгол Улсын холбогдох үндэсний хууль тогтоомжоос илүү уян хатан байдаг.

**Хүснэгт 6:** 2022 оны 9 дүгээр сарын байдлаар, Монгол Улсын нэгдэн орсон цахим арилжаатай холбоотой олон улсын гэрээ

Олон улсын гэрээ	Үндсэн агуулга	Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн огноо
Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенц (1958)	Арилжааны маргаан болон зөвхөн хэлэлцэн тохирогч нөгөө талын улсад гаргасан арбитрын шийдвэрээс үүдэлтэй гадаадын арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх	1995 оны 1 дүгээр сарын 22
Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын Конвенц (1980)	Барааг олон улсад худалдах, худалдан авахтай холбоотой тодорхой асуудал (бизнесээс бизнест чиглэсэн худалдааны харилцаа)	1999 оны 1 дүгээр сарын 1
ДХБ-ын тухай Хэлэлцээр (1994)	Барааны худалдаа, үйлчилгээний худалдаа, оюуны өмчийн эрхийн зохицуулалтын талаарх олон улсын худалдааны дүрэм	1997 оны 1 дүгээр сарын 29
ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр (2013)	Олон улсын худалдааг хөнгөвчлөх	2016 оны 11 дүгээр сарын 28
Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенц (2005)	Олон улсын цахим гүйлгээ	2021 оны 7 дугаар сарын 1
НҮБ-ын Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (2021)	Олон улсын худалдааг хөнгөвчлөх ба хил дамнасан цаасгүй худалдаа	2022 оны 7 дугаар сарын 27

Монгол улс НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (UNCITRAL) гаргасан загвар хуульд нийцүүлэн Олон улсын арбитрын тухай хууль (2017), мөн Эвлэрүүлэн зүүчлалын тухай хуулийг (2012) баталсан. Маргаан шийдвэрлэх чиглэлээр Монгол Улс мөн Эвлэрүүлэн зүүчлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай НҮБ-ын конвенц (2018)-д нэгдэх асуудлыг авч үзэх боломжтой бөгөөд энэ нь тус улсын аж ахуйн нэгжүүд хил дамнасан цахим арилжаатай (бизнесээс бизнест чиглэсэн худалдааны харилцаа) холбоотой маргааныг шийдвэрлэх нэмэлт үр дүнтэй хувилбарыг олгох боломжтой юм.

Монгол Улсын хувьд өнөөдрийг хүртэл, цахим арилжааны агуулгыг багтаасан ердөө ганцхан чөлөөт худалдааны хэлэлцээрийг Япон улстай байгуулаад байна (2015 он). Энэхүү чөлөөт худалдааны хэлэлцээрт (Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр-ЕРА) цахимаар мэдээлэл дамжуулах явцад гаалийн татвар ногдуулахгүй байх, цахим бүтээгдэхүүнүүдийг үл ялгаварлах, тоон гарын үсэг, цахим хэрэглэгчийн эрхийг хамгаалах, спам (spam) буюу үхүүлгын мэдээлэл, зар сурталчилгааг цахим


мэдээллийн хэрэгслийг ашиглан хэрэглэгчдэд бөөнөөр нь хавтгайруулан, замбараагүй илгээх үйлдэл, цахим гүйлгээ, цаасгүй худалдаа, хил дамнасан тоон өгөгдөл, мэдээллийн урсгал ба тоон өгөгдлийг нутагшуулах, түүнчлэн эх кодын талаарх журам зэргийг багтаасан болно.

Монгол Улс ДХБ-ын 87 гишүүн оронтой хамтран, ДХБ-ын Цахим арилжааны талаарх Хамтарсан санаачилга (JSI)-д нэгдэн оролцдог бөгөөд энэ нь цахим арилжаатай холбоотой 30 гаруй чиглэлийн хууль тогтоомжийг тодорхойлох зорилготой юм.

### 6.3. Цахим арилжааны эрх зүйн зохицуулалтад оролцогч талуудын тэргүүлэх чиглэл ба хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагаа

Монгол Улсын Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээний (eT Ready) судалгаанд оролцогч төрийн болон хувийн хэвшлийн төлөөллийн аль аль нь Монгол Улсын цахим арилжаатай холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ, түүний дотроос цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтын асуудлыг нэн тэргүүнд хэрэгтэй гэж үзжээ. Оролцогч талууд аль аль нь кибер орчны цахим гэмт хэргийн тухай хууль тогтоомж, тоон өгөгдөл мэдээллийн эрх зүйн зохицуулалт чухал ач холбогдолтой гэж санал нэгдэж байв. Түүнчлэн хувийн хэвшлийн оролцогчид д хил дамнасан тоон өгөгдөл мэдээллийн урсгалд санаа зовж байгаа тул асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаарал хандуулж байгаа бол төрийн байгууллагын төлөөлөл хувь хүний мэдээллийг хамгаалах тал дээр илүү анхаарал хандуулж байна. Зуучлагч талуудын хүлээх үүрэг, худалдааг хөнгөвчлөх, цаасгүй худалдаа, цахим хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудал анхаарал татсан чухал сэдвийн хүрээнд багтаж байна (Зураг 33).

**Зураг 33:** Цахим арилжааны эрх зүйн зохицуулалтын тэргүүлэх асуудал (%) (Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 91, хувийн хэвшлийн 24)



- 1 Тоон гарын үсэг болон Хэрэглэгчийн жинхэнэ болохыг цахим хэлбэрээр таньж баталгаажуулах
- 2 Хувийн нууц
- 3 Хил дамнасан мэдээлэл, тоон өгөгдлийн урсгал болон байршлын зохицуулалтын дүрэм
- 4 Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомж
- 5 Дундын зуучлагчдын хүлээх үүрэг (жишээлбэл, цахим платформ, зах зээл гэх мэт)
- 6 Цахим арилжааны үйл ажиллагаанд татвар ногдуулах
- 7 Онлайн орчинд (Спамыг оруулаад) хэрэглэгчдийг хамгаалах хууль тогтоомж
- 8 Маргаан шийдвэрлэх
- 9 Цахим арилжаа, цаасгүй худалдаатай холбоотой гаалийн үйл ажиллагааг хөнгөвчлөх
- 10 Цахим гүйлгээ
- 11 Онлайн орчинд борлуулагч, үйлдвэрлэгчдийг хамгаалах

Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

2022-2023 онд Монгол Улсын цахим арилжаатай холбоотой эрх зүйн орчныг үнэлэх судалгааг ЦХХХЯ-ны захиалгаар АХБ-ны дэмжлэгтэйгээр хийсэн. Судалгааны үр дүн, зөвлөмжийг тусгасан тайланг 2023 оны 1 дүгээр сард оролцогч талууд баталгаажуулсан<sup>105</sup>. Тайлангаас үзвэл Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөж буй цахим арилжаатай холбоотой хууль тогтоомжийг нэгтгэхгүйгээр цаашид уялдуулахыг зөвлөж байна. Мөн Монгол Улсын цахим арилжааны дүрмийг олон улсын жишиг нийцүүлэхэд чиглэсэн тодорхой зөвлөмжийг тодруулбал, цахим гүйлгээний зохицуулалт, тоон гарын үсэг, цахим платформ, хувийн мэдээллийг хамгаалах, тоон өгөгдлийг хамгаалах, кибер гэмт хэрэг, кибер аюулгүй байдал, иргэний хариуцлага, түүнчлэн олон улсын болон бүс нутгийн гишүүнчлэл гэсэн ангиллаар гаргажээ. Тус дүгнэлт, зөвлөмж нь энэхүү үнэлгээний үр дүнтэй ерөнхийдөө нийцэж байна.

#### **6.4. Цахим арилжаатай холбоотой үндсэн асуудлыг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт**

##### **Цахим гүйлгээ**

Монгол Улсын цахим гүйлгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь гэрээний ба гэрээний бус үүрэг хүлээсэн, эсхүл хэсэгчилсэн үүрэг хүлээсэн тус тусдаа эрх зүйн актаас бүрддэг. Тухайлбал Иргэний хууль (2002), Нотариатын тухай хууль (2011), Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (2020), Цахим гарын үсгийн тухай хууль (2021), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021) зэрэг хэд хэдэн хуультай бөгөөд холбогдох асуудлын зүйл заалтыг төрөлжүүлэн эмхэтгэн нэгтгэсэн эрх зүйн акт байхгүй. Цахим үйлчилгээг хүргэж буй хэрэгслийг хялбархан хүлээн зөвшөөрөх боломжийг олгосон журмыг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тоон гарын үсэг, нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавих шаардлагыг сулруулж, шаардлагатай тохиолдолд гэрчилгээжүүлэх аргыг хэрэгжүүлж байна.

Эдгээр хууль нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (UNCITRAL) холбогдох загвар хуульд үндэслэж гараагүй (Цахим арилжааны тухай UNCITRAL-ийн загвар хууль (1996), Цахим гарын үсгийн тухай UNCITRAL-ийн загвар хууль (2001)) бөгөөд дээрх загвар хуулийн үндсэн зарчмыг зөвхөн хэсэгчлэн тусгасан болно. Иргэний хуульд (2002) цахим баримт бичгийг үл ялгаварлах зарчмыг тусгасан мэт харагдаж байгаа бөгөөд “зөвхөн цахим гарын үсгээр таньж баталгаажуулсан бол уг баримт бичгийг албан ёсны баримт бичигтэй адилтган хүчин төгөлдөрт тооцно” гэсэн боловч, тусгайлсан хуульд урьдчилан заасан стандартад нийцсэн дижитал гарын үсгийн тухайн цорын ганц төрөл бүхий баримт бичиг болохыг баталгаажуулсан тохиолдолд л зөвхөн үүнийг хууль ёсных гэж хүлээн зөвшөөрч болно” гэсэн нь технологийн хувьд төвийг сахисан байдал ажиглагдахгүй байна.

Одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд цахим харилцааны эрх зүйн чадамжтай холбоотой хэд хэдэн нийтлэг дүрэм үгүйлэгдэж байна. Үүнд: тухайн цахим харилцааг жинхэнэ, хууль ёсны эсэхийг гэрчлэн, таньж тогтоох (Засгийн газрын байгууллагаас олгосон баримт бичгийг заримдаа хамруулдаг); үр дүнтэй байдал (илгээх, хүлээн авах хугацаа), автоматжуулсан гүйлгээ, тэдгээрийн алдаа зэрэг асуудалтай холбоотой хэд хэдэн нийтлэг журам дутмаг байна.

##### **Тоон гарын үсгийг таньж баталгаажуулах ба тоон гарын үсэг**

Монгол Улсын хууль тогтоомжид баримт бичгийг жинхэнэ, хууль ёсны хүчинтэй эсэхийг таньж баталгаажуулах хэд хэдэн арга бий. Эдгээрийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021 он. 19 – 21, 24 дүгээр зүйл) болон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай (2020 он. 38 дугаар зүйл) хуулиудад тусгаж, төрийн үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг хэрэглэгчийг тодорхойлох (identification) болон бүртгүүлж нэвтрэх системийг (login system) бүрдүүлсэн болно, үүнд цахим гарын үсэг (де факто - Нийтийн түлхүүрийн дэд бүтэц (PKI)), төрийн албан ёсны цахим шуудан, албан ёсны бичиг хэргийн нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл дамжуулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон

<sup>105</sup> АХБ, Цахим арилжаанд ээлтэй орчныг бий болгох нь, Тайлангийн төсөл, 2023.01.01, дараах холбоосоор үзнэ үү <https://lpr.adb.org/sites/default/files/event/1768/DRAFT-Report-on-Mongolia-revisions-January%202023-EN.pdf>

өвөрмөц дугаарыг баримт бичигт хамааруулан хавсаргах зэрэг болно. Хэрэгжүүлсэн арга зам нь практикт суурилсан, ерөнхийдөө бизнест ээлтэй шинжтэй бөгөөд шийдэл тус бүрийн санал болгож буй аюулгүй байдлын түвшинг кибер аюулгүй байдлын үүднээс авч үзэхдээ, тухайн тодорхой тохиолдол тус бүрийг үнэлэх хэрэгтэй. Бизнесээс-бизнес (B2B), бизнесээс-хэрэглэгчид (B2C), хэрэглэгчээс-хэрэглэгчид (C2C) гэсэн гүйлгээ бүхий цахим баримт бичгүүдийн хууль ёсны хүчин төгөлдөр болохыг нь илэрхийлэх цорын ганц сонголт нь тоон гарын үсэг хэвээр байгаа учир энэ шийдэл нь зөвхөн улсын хэмжээнд ба төрийн эрх бүхий байгууллагаас олгож буй баримт бичигт хамаарна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсад Цахим гарын үсгийн хууль эрх зүйн үндсийг 2021 оны 12 дугаар сард шинэчлэн найруулсан хууль 2022 оны 5 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Цахим гарын үсгийг нарийвчлан тодорхойлоогүй боловч товч дурдсан байдаг. Энэ хууль нь цахим/тоон гарын үсэг (16 болон түүнээс дээш насны хувь хүнд), цахим/тоон тамга (хуулийн этгээдэд) мөн цахим/тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тухай асуудалд голлон анхаарчээ. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд цахим/тоон гарын үсэгт тавих дараах шаардлагыг заасан байдаг: а) Дижитал тоон гарын үсгийн хувийн түлхүүрийг ашиглан мэдээллийг шифрлэж хувиргалтад оруулж үүсгэсэн байна; б) тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийг ашиглан, цахим гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийг таньж баталгаажуулах нөхцлийг хангах; в) мэдээлэлд тоон гарын үсгийг хавсаргасан, эсхүл нэгтгэсний дараа мэдээлэлд өөрчлөлт оруулсан, мэдээллийн бүрэн бүтэн эсэхийг мэдэх боломжтой байх нөхцлийг бүрдүүлэх зэрэг болно. Эдгээр шаардлага нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (UNCITRAL) Цахим гарын үсгийн загвар хуулийн 6 дугаар зүйлд заасан “цахим/тоон гарын үсгийн найдвартай байдлын параметрууд”-тэй нэг зүйлээс бусад тохиолдолд нийцэж байгаа юм. Тэр үл хамаарах зүйл нь гэвэл - гарын үсэг зурах үед уг гарын үсгийг үүсгэж буй тоон өгөгдөл нь гарын үсэг зурсан этгээдийн хяналтан дор байсан гэдгийг нотлох баримт байхгүй нөхцөлд өөр ямар ч хүн байгаагүй гэдгийг нотлох баримт байхгүй нөхцөлд (ийм учраас, тийм хяналт тавьсан гэж үзнэ). Хяналт тавьсан байх гэсэн таамаглалыг уг хуульд гарын үсэг үүсгэгч тоног төхөөрөмжийг өмчилсөн байх шаардлагыг (үүнд хяналт тавих гэхээс илүүтэйгээр) тусган оруулж өгснөөр үндэслэлтэй гэж зөвтгөж болох юм.

Гадаадын тоон гарын үсгийг (эсхүл, гэрчилгээг) Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас эсхүл олон улсын гэрээний үндсэн дээр хүлээн зөвшөөрч болох юм. Энэ тухай хуулинд тусгаагүй тул гадаадын тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөөгүй байна гэж үзнэ.

Монгол Улсын үндэсний хууль тогтоомжид цахим гарын үсгийн хувьд технологийн талаасаа төвийг сахисан байдал буюу “хувь хүн, байгууллага өөрт тохирох технологийг сонгох эрх” дутмаг байна, ийм нөхцөл нь зөвхөн Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд суурилсан цахим/тоон гарын үсэг ашиглахыг зөвшөөрсөн, мөн сонирхогч талыг гэрээний талын хувьд бие даасан байдалдаа найдах боломжийг олгосон, тодорхой хоёрдмол утгагүй хэллэг бүрдүүлээгүй, эсвэл өөрсдийн цахим гарын үсгээ шүүхийн өмнө хүчин төгөлдөр болохыг батлах боломж муутай зэрэг нь Монгол Улсын зүгээс, НҮБ-ын Цахим харилцаа холбооны тухай конвенцийн 9 дүгээр зүйлийн 3 (B2B гүйлгээний тухай), Монгол-Японы хооронд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 5, түүнчлэн бусад олон улсын хэмжээнд хэлэлцсэн дүрэм тухайлбал ДХБ-ын дэргэдэх цахим арилжааны тухай Хамтарсан мэдэгдэлээр хүлээсэн үүрэгтэй зөрчилдөхүйц байна. Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт (2019 он) “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байдаг боловч судалгаанд оролцогч талуудын үзэж байгаагаар тэдгээрийг жишээлбэл шүүхийн өмнө шууд авч хэрэглэх зэрэг нь хязгаарлагдмал байна гэжээ.

### **Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ба Спам**

Монгол Улсын Иргэний хуулийн (2002) 200-202 дугаар зүйлүүдээр борлуулалтын ерөнхий нөхцөл, түүний дотор хэрэглэгчийн гэрээний хүчин төгөлдөр байдал, нөгөө талын эсрэг тайлбар хийх зэрэг асуудлыг нарийвчилсан зохицуулсан байдаг.

Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003) нь Иргэний хуулийн (2002) борлуулалттай холбоотой заалтуудад үндэслэсэн байдаг ба үүнд хэрэглэгчдийг хууран мэхлэх арилжаатай холбоотой үйлдлээс хамгаалах, хохирлыг нөхөн төлж барагдуулахад хамаарах ерөнхий дүрмийг тусгасан байдаг.

Хууль нь дараах зарчимд үндэслэсэн байдаг. Үүнд: бараа, ажил, үйлчилгээ [...] нь хэрэглэгчийн аюулгүй байдал, тоо хэмжээ, чанар, хугацаа, зориулалтын зохих шаардлагыг хангасан байх; хэрэглэгчийг бараа, ажил, үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл олж авах, хэрэглээний соёлтой болох боломжоор хангасан байх; хэрэглэгчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхол, байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх [боломжийг] хангах ёстой. Хэрэглэгчийн эрх гэдэгт: чанартай, аюулгүй байдлыг хангасан бараа, үйлчилгээ авах; үйлчилгээ үзүүлэгчийн буруугаас учирсан хохирлыг арилгуулах / нөхөн төлүүлэх эрх; барааны талаархи мэдээлэл авах эрх; шүүхэд хандах эрх; хэрэглэгчийн боловсрол олж авах эрх гэх мэтийг хамруулсан байдаг. Хариуд нь бараа, үйлчилгээ үзүүлэгчид баталгаат болон эдэлгээний хугацааны талаар тодорхой үүрэг хүлээхээр заасан байдаг.

Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т хэрэглэгчтэй байгуулсан гэрээний нөхцөл нь Монгол Улсын хуулиар тогтоосон хэрэглэгчийн эрхийг хамгаалах нөхцөлөөс дордуулсан бол хүчин төгөлдөр бус гэж заасан. Энэ дүрэм нь хил дамнасан / олон улсын хувийн эрх зүйн хүрээнд " жишиг хэм хэмжээ" болж хэрэгжих магадлалтай.

Уг хуулийн хэрэгжилтийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (AFCCP)-ын Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хэлтсээс хариуцан ажилладаг. Хэрэглэгчид шууд шүүхэд хандах эсхүл хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагад хандаж заавар/тусламж авах боломжтой. Гэсэн хэдий ч цахим маргааныг шийдвэрлэх зэрэг маргаан шийдвэрлэх хувилбар бүхий бүтэц механизм одоогоор алга байна.

Спам хэмээх цахилгаан холбооны мэдээллийн технологийн мессеж/мэдээллийг зохицуулах тусгайлсан заалт байгаа эсэхийг олж тогтоосонгүй. Харин Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны 2019-2024 онд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийн 5.2.1.4-т “ Хууль бус телемаркетингийн үйлчилгээг (SMS, зар сурталчилгаа, робот дуудлага) зогсоож, спамаас хамгаалах төслийг хэрэгжүүлэх” гэж заажээ. Хэрэглэгчийн санал асуулгын үр дүнгээс харахад цахим хэрэглэгчид аливаа асуудал гарсан тохиолдолд зөрчилдөөнийг зохицуулах албан бус аргад найдан, үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барьж, хэлэлцээ хийхийг эрмэлздэг болохыг харуулж байна. Захиргааны арга хэмжээ авах тохиолдол ховор хэвээр байна (Зураг 34).


**Зураг 34:** Асуудал гарвал (барааг буцаах, мөнгөө буцаан авах хүсэлт гаргах гэх мэт) хэрхэн шийдэх вэ? (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай шинэ хуульд (2021) холбогдох сайн арга туршлагыг тусгасан болно (төрийн байгууллагын мэдээллийг хянагч нарт хамаарна). Уг хуульд тийм байгууллагыг олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэж ажиллахын тулд холбоо барих мэдээлэл, түүний дотор нийгмийн сүлжээний хаяг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тайлан, мэдээг танилцуулж байхыг хуулиар үүрэг болгон заасан байдаг.

Судалгаанд оролцогчид болон өмнөх тайланд хуулийг хэрэгжүүлэхэд тухайлбал, чанар/аюулгүй байдлын<sup>106</sup> стандартыг тогтоох, дагаж мөрдөхтэй холбоотой хуулийн заалт амьдрал дээр хэрэгжихгүй байгаа талаар тэмдэглэжээ. Үүнтэй төстэй асуудлыг (худалдан авсан бүтээгдэхүүний талаар өгсөн амлалт болон бодит чанарын ялгаа) хэрэглэгчдийн судалгаанд оролцогчид тэмдэглэсэн байна (Зураг 35). Уг асуудал ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон хэрэглэгчээс хэрэглэгчид хандсан бизнесийн (С2С) борлуулалтын хүрээнд байсан хэвээр байна.

**Зураг 35:** Онлайн орчинд худалдан авахад тулгардаг бэрхшээл (%)  
(Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчилсэн найруулах төслийн ажил үргэлжилж байна. Энэхүү төсөлд олон зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна цахим арилжаатай хамааралтай "Алсын зайн болон цахим бизнесийн үйл ажиллагаа"-д тусгайлан зориулсан бүлгийг нэмж байгаа болно.

### Хүний хувийн мэдээлэл, тоон өгөгдлийн нүүцлал ба хамгаалалт

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай шинэ хууль (2021)-ийг баталснаар Монгол Улс хүний хувийн нүүцыг хамгаалах тогтолцоог саяхан шинэчилсэн. Уг хууль нь хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд үүнд уг мэдээллийг тодорхойлохдоо: “хүнийг шууд болон шууд бусаар таньж, эсвэл таних боломжтой - хүний эмзэг мэдээлэл, түүний эцэг, эхийн нэр, овог нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим/электрон цахим тодорхойлогч, болон бусад мэдээлэл” гэжээ.

Уг хууль нь Засгийн газар болон бусад сонирхогч талуудын зүгээс хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах төрөл бүрийндэгийг тогтоосон бөгөөд тоон өгөгдөл, мэдээллийн эзэмшигч, тоон өгөгдөл мэдээллийн хянагч / боловсруулагч нарын эрх, үүргийн каталогт оруулан бүртгэлжүүлсэн

<sup>106</sup> Со Янг Ли нар, ‘Монгол болон Өмнөд Солонгосын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа’ (Солонгосын Хууль зүйн судалгааны хүрээлэн, 2013.08.31), <https://www.klri.re.kr/kor/publication/1390/view.do>. Ли нар.

байна. Тоон гарын үсгийн хувийн түлхүүрийг агуулсан "эмзэг" гэж тооцогдох хүний хувийн мэдээллийг цуглуулахад зориулж илүү хязгаарлагдмал дүрмийг тогтоож болох юм.

Тус хуулиар Хүний эрхийн үндэсний комиссыг мэдээлэл хамгаалагчаар томилсон. Гэсэн хэдий ч Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд (2020) тоон өгөгдөл, мэдээллийн эрх зүйн зохицуулалттай холбоотой ямар нэгэн чиг үүрэг, журмыг тодорхой заагаагүй байна. Уг хуулийн хэрэгжилтийн техникийн талын асуудлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам хариуцна.

### Кибер гэмт хэрэг

Монгол Улсын Эрүүгийн хуулийн (2015) 26 дугаар бүлгийн "Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" гэсэн гурван зүйлд цахим гэмт хэрэгтэй холбоотой заалтыг тусгажээ.

Уг хууль нь компьютерийн өгөгдөл, системийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлын эсрэг зарим гэмт хэргийг шийтгэдэг. Үүнд: Кибер орчинд хууль бусаар халдах (Зүйл 26.1.), Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах (Зүйл 26.2.), Хор хөнөөлтэй программ үүсгэж бүтээх, ашиглах, түгээх.

Эдгээр заалтууд нь Кибер гэмт хэргийн тухай ETS 185 (Будапешт) конвенцид тусгасаны дагуу бүхэлд нь биш ч гэсэн тухайн бүс нутагт загвар болохуйц агуулгын дүрмийг тусгажээ. Үүнд: хууль бусаар хандах (Зүйл 26.1.1 – Зүйл 2, Будапештийн конвенц), өгөгдөлд хөндлөнгөөс нөлөөлөх (Зүйл 26.1.2 – Зүйл 4, Будапештийн конвенц), системд хөндлөнгөөс нөлөөлөх (Зүйл 26.1.2 болон 26.1.3 – Зүйл 5, Будапештийн конвенц), болон төхөөрөмжийг буруугаар ашиглах (Зүйл 26.2 болон 26.3 – Зүйл 6, Будапештийн конвенц).

Залилах гэмт хэрэг (17.3-р зүйл) нь бусад зүйлсээс гадна, "цахим хэрэгсэл" түүнчлэн хуурамч мөнгө, үнэт цаас, төлбөрийн хэрэгслүүд (18.7-р зүйл) болон/эсвэл технологийг бүтээн хийж, ашиглах зэрэг бусад илүү тодорхой гэмт хэргийн чанартай үйлдлийг - залилан мэхлэх үйлдлийг агуулсан төвийг сахисан гэмт хэрэг гэж үздэг бөгөөд үүнд тэдгээрийг цахим орчинд хийх боломжтой, эсхүл энэ нь зарим талаараа, компьютертэй холбоотойгоор хуурамч бичиг үйлдэх, компьютертэй холбоотойгоор залилан хийх зэрэг агуулгатай холбоотой гэмт хэргийг дор хаяж хэсэгчилсэн байдлаар тусгасан гэж үзэж болох юм (Будапештийн конвенцийн 7, 8-р зүйл). Монгол Улсын Эрүүгийн хуульд (16.8, 16.9-р зүйл) тусгагдсан хүүхдэд садар самууныг сурталчилах, уруу татах гэмт хэргүүд нь мөн технологийн хувьд төвийг сахисан байгаа нь Будапештийн конвенцийн 9-р зүйлтэй параллель болж байна. Энэ нь мөн Зохиогчийн эрхийг зөрчих асуудлыг тусгасан, тус хуулийн 18.7-р зүйлийн хувьд ч энэ нь мөн адил хамаарна (Будапештийн конвенцийн 10-р зүйл). Уг төрөлжсөн хуулийн хамрах хүрээнээс орхигдуулсан цорын ганц анхаарал татахуйц зүйл бол өгөгдөл дамжуулах явцад хөндлөнгөөс оролцохтой холбоотойгоор, мэдээллийг хууль бусаар саатуулах гэмт хэрэг байгаа юм байна (Будапештийн конвенцийн 3-р зүйл).

Үүний зэрэгцээ, [интернэтийн сүлжээн дэх] тоон өгөгдөл, мэдээллийн урсгалаас (traffic data) хайлт хийх, мэдээлэл хураан авах, бодит цаг дээр мэдээлэл цуглуулах зэрэг үйлдэлтэй холбоотой компьютерийн гэмт хэргийн харъяаллыг/шүүн таслах ажиллагааг өргөтгөсөн тодорхой тохиолдлууд зэрэгтэй холбоотой ямар нэгэн нарийвчилсан зүйл, заалтууд хараахан гараагүй байгаа юм байна.<sup>107</sup>

Цахим кибер гэмт хэрэг, ялангуяа Эрүүгийн хуулийн 26-р бүлэгт (2015 онд) заасан цахим кибер гэмт хэргийг, цахим хуудас, шууд утас, Facebook, Twitter данс/хаягуудтай холбоотой цахим гэмт хэрэгтэй тэмцэх тусгайлсан эрүүгийн цагдаагийн хэлтэс ажиллаж, хуулийг сахиулдаг.<sup>108</sup> Нийт иргэдийн дунд цахим кибер гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголт идэвхтэй өрнөж байна.

### 6.5. Цахим арилжаатай холбоотой бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

<sup>107</sup> 'Mongolia - Octopus Cybercrime Community', Европын зөвлөлийн портал, 2022.12.06-нд хандсан, <https://www.coe.int/en/web/octopus/-/mongolia>. 'Mongolia - Octopus Cybercrime Community'.

<sup>108</sup> "Цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн цагдаагийн хэлтэс", 2022.12.06-нд хандсан, <http://www.cyber.police.gov.mn/>.

## Цахим нотлох баримт

Монгол Улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дотоодын ба гадаадын цахим электрон нотлох баримтыг хүлээн авах талаар нарийвчлан тусгаагүй нь оролцогч талуудад тодорхойгүй байдлыг бий болгож, эргэлзээ төрүүлдэг талаар тэд хэлэлцүүлгийн үеэр илэрхийлсэн бөгөөд энэ асуудал улмаар 2019 онд тус улсын цаасгүй худалдааны бэлэн байдлын үнэлгээний төслийг боловсруулахад хүргэж байжээ.<sup>109</sup> Ийм нотлох баримтыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хүлээн зөвшөөрч байгаа мэт боловч тэдгээр баримтыг цуглуулахтай холбоотой процессын ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж өгөөгүй байна.

## Цахимаар таньж тогтоох

Цахим засаглал зэрэг үйлчилгээний олон салбарт дижитал шилжилт өрнөхийн зэрэгцээ эхний алхамд [тухайн этгээдийн] албан ёсны, жинхэнэ мөн эсэхийг таньж тогтоох үйлдэл нь биет байдлаар явагддаг хэвээр байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд (2020 он) (7-р зүйл) зааснаар, банк, эрх бүхий хуулийн этгээд нь зөвхөн бичгээр гэрээ байгуулж, данс үүсгэсэн харилцагчдад тэдний данстай холбоотойгоор хадгаламж үүсгэх, мөнгө шилжүүлэх, кредит зээлийн үйлчилгээг санал болгохыг зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч, тоон гарын үсэг нь хувь хүн эсхүл хуулийн этгээдийн албан ёсны жинхэнэ эсэхийг танихад үйлчилдэг байж болох нөхцлийг хангаж өгсөн Цахим гарын үсгийн тухай хууль (2021) хэрэгжиж эхэлснээр цахим үнэмлэх буюу албан ёсны, жинхэнэ эсэхийг таньж баталгаажуулах зарчим рүү шилжих байх гэсэн хүлээлт байна. Саяхан баталсан НҮБ-ын Олон улсын Худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-ийн "Хуулийн этгээдийн жинхэнэ эсэхийг таниулах ажлын удирдан зохицуулалт ба Итгэлцлийн үйлчилгээг ашиглах ба хил дамнан хүлээн зөвшөөрөх тухай" загвар хууль нь (2022 - UNCITRAL Model Law on the Use and Cross-border Recognition of Identity Management and Trust Services)<sup>110</sup> эдгээр стандартыг бий болгоход тусална. Олон улсын хэмжээнд хуулийн этгээд таниулагчийн сан (GLEIF) / Хуулийн этгээд таниулагч (LEI) нартай заавал биелүүлэх журмаар эсвэл сайн дурын үндсэн дээр нэгдэж, Хуулийн этгээд таниулагч (LEI)-ийн мэдээллийн жагсаалтыг ашиглах нь, хуулийн этгээдүүдийг цахимаар таньж тогтоох үйлдлийн загвар боловсруулах ажлын нэг хэсэг болгон авч үзж болно. Хэдийнээ олон орны хэрэглэж буй энэ арга нь хувийн хэвшлийн салбарынхныг хил дамнан худалдаанд оролцох боломжийг нь хөнгөвчилж өгөх боломжтой юм.

## Платформ ба дундын зуучлагчийн хариуцлага

Одоогоор үйлчилж байгаа олон улсын туршлагатай харьцуулбал, дундын зуучлагчийн үүрэг, хариуцлагын талаар Монголын хууль тогтоомжид илүү идэвхтэй байр суурь баримталж ирсэн байдаг.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.1, 9.1.2-р зүйлийг (2001) хэрэгжүүлэхэд, дундын зуучлагчдын нийтэлсэн, хууль бус гуравдагч этгээдийн агуулгатай нь холбоотой үүрэг, хариуцлагыг Харилцаа холбооны зохицуулах хороо (CRC)-ноос баталсан Онлайн контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам (2011)-д контентын үйлчилгээ үзүүлэхэд тавих нийтлэг шаардлага, контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнчлэн мэргэжлийн дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахдаа, бүх төрлийн өмчийн аж ахуйн нэгж, иргэд зэрэг зах зээлд оролцогч талуудад зориулан үр дүнтэй, шударга өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхийг үүрэг болгосон байдаг. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нарт тавих нөхцөл нь дараах субъектэд хамаарна. Үүнд: Үүрэн (mobile) харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчид, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид, IP Телевизийн үйлчилгээ үзүүлэгчид, Үүрэн (mobile) телевизийн үйлчилгээ үзүүлэгчид, (дижитал тоон агуулга, мэдээлэл дамжуулах боломжийг олгодог бусад үйлчилгээ үзүүлэгчид), Агуулга, мэдээллийг нэгтгэгч нар; Агуулга, мэдээллийг байршуулах

<sup>109</sup> НҮБ-ийн Ази, номхон далайн бүсийн э дийн засаг, нийгмийн комисс, "Хил дамнан цаасгүй худалдаанд бэлэн байдлын үнэлгээ". 2019

<sup>110</sup> Одоогоор материалыг зөвхөн ноорог хэлбэрт, дараах холбоосоор үзэх боломжтой. <https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/acn9-1112-e.pdf>



үйлчилгээ үзүүлэгчид, Цахим хуудасны үйлчилгээ үзүүлэгчид зэрэг орно. Хориглосон агуулгуудыг бүхэлд нь багтаасан жагсаалтаар тодорхойлох ба үүнд: порнограф, гэмт хэрэг үйлдэхэд уруу татсан сурталчилгаа, терроризм, шашинд суурилсан харгислал, олон нийтийн эмх замбараагүй байдал, хориотой эм, бодис хэрэглэх, согтууруулах ундаа, насанд хүрээгүй ба нийгмийн цөөнх хүмүүсийн эрхийг зөрчсөн агуулга, зохиогчийн эрхийг зөрчсөн агуулга эсхүл хүүхдийн зан төлөвт сөргөөр нөлөөлж буй агуулга, мэдээлэл зэрэг орно.

Эрх зүйн зохицуулалтын ерөнхий нөхцөл нь хууль бус агуулгатай холбоотойгоор дундын зуучлагчаас авах арга хэмжээг (төрлөөр нь) нарийвчлан тусгасан болно. Арга хэмжээ авахгүй эсвэл хариу өгөхгүй тохиолдолд дундын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно. Түүнчлэн өдөрт 300-аас дээш хүн зочилдог цахим хуудсыг Харилцаа холбооны зохицуулах хороонд (CRC) бүртгүүлэх шаардлагатайг нөхцөлд тусгасан байдаг.

Түүнчлэн Харилцаа холбооны зохицуулах хороо (CRC) нь Фэйсбүүк олон нийтийн сүлжээнд болон Фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ, зөвлөмжийг танилцуулсан байдаг. Тус ХХЗХ нь Meta [Metaverse буюу Фэйсбүүк-ийн шинэ нэр бүхий байгууллага]-тай "Засгийн газрын хэргийн талаарх ажлын суваг" гэсэн хэлбэрээр хамтын ажиллагаа бий болгож, Фэйсбүүк олон нийтийн сүлжээнд нэгдсэн хэрэглэгчийн дагаж мөрдөх хэм хэмжээг зөрчсөн, хууль бус агуулга бүхий мэдээллийг Фэйсбүүк платформоос арилгах чиглэлээр ажиллаж байна. 2021 оны тавдугаар сараас ХХЗХ нь YouTube платформтой хамтран "итгэмжлэгдсэн түнш" хэмээх горимыг ашиглан хууль бус агуулга, мэдээллийн талаар мэдээлж эхэлсэн. ХХЗХ нь цахим орчинд үүссэн гомдлыг хүлээн авч, статистик мэдээллийг тусгайлан тайлагнадаг.

### **Өгөгдлийг хил дамнасан цахимаар дамжуулах ба өгөгдөлийг нутагшуулах**

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)-ийн 14-р зүйлд Монгол Улсын хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд мэдээллийг гадаад улс дахь хүн, хуулийн этгээд болон олон улсын байгууллагад дамжуулан өгөхийг хориглоно гэж заасан. Үүнийг хэрэгжүүлэх дүрмийг боловсруулаагүй бөгөөд энэ шаардлага нь хувийн хэвшилд сөрөг дагавар хүргэж болзошгүй, тухайлбал, групп хоорондын болон хил дамнасан корпорацийн тоон өгөгдөлийг дамжуулахад хүндрэл учруулж болзошгүй юм.

Монгол Улсын Япон Улстай байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээрийн цахим худалдааны нөхцлийн тухай 9.12.5 дугаар зүйлд зааснаар “Тал бүр мэдээллийн хил дамнасан үрсгалыг дэмжиж ажиллах нь цахим худалдааны идэвхтэй орчинг бүрдүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг хүлээн зөвшөөрнө.” гэж заасан. Түүнчлэн энэхүү чөлөөт худалдааны хэлэлцээрийн Харилцаа холбооны үйлчилгээний (Communication Services) 5 дугаар хавсралтад тоон мэдээлэл, өгөгдлийн үрсгалын талаарх дүрмийг заасан байдаг. Уг заалтад “Тал бүр нь нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийг өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл хилээрээ дамжуулан, үйлчилгээ үзүүлэгчийн корпорацийн доторх холбоог оролцуулан, Дэлхийн худалдааны байгууллагын аливаа гишүүний, эсхүл Талуудын мэдээллийн санд байгаа, эсхүл төхөөрөмжөөр унших боломжтой хэлбэрээр хадгалагдаж буй мэдээлэлд нэвтрэх зорилгоор нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээг ашиглах боломжоор хангана” гэжээ Энэ чиглэлийн илүү нарийвчилсан/үүрэг хүлээсэн, заавал биелүүлэх дүрмийн талаар Дэлхийн худалдааны байгууллагын Хамтарсан мэдэгдэл (JSI)-д тусгахаар хэлэлцэж байна.

Монгол-Японы Чөлөөт худалдааны хэлэлцээрийн 7 дугаар бүлэгт санхүүгийн мэдээллийг хил дамнан шилжүүлэхэд хязгаарлалт тавихыг хориглох тухай нэмэлт заалтыг багтаасан байна. Монголбанкны мэдээгээр одоогийн байдлаар санхүүгийн мэдээлэл нь Монголбанк дээр биет хэлбэрээр байрлаж байгаа хадгалж, агуулах зориулалтын серверүүд дээр хадгалдаг. Бусад, тухайлбал, арилжааны тоон мэдээлэл, өгөгдлийг хил дамнан шилжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоогоогүй байна.

Монгол-Японы Чөлөөт худалдааны хэлэлцээр нь бизнес эрхлэх нөхцөл болгож, тоон өгөгдөлийг тухайн газарт нь нутагшуулах шаардлагыг хориглодог бөгөөд онцгой тохиолдолд, төрийн бодлогын хууль ёсны зорилтыг биелүүлэхийн тулд шаардлагатай гэж үзсэнээр тухайн газарт нь [тоон өгөгдөл] нутагшуулахыг зөвшөөрдөг ба хэрэв зүй зохистой хэрэглээгүй тохиолдолд энэ нь дур зоргоороо эсхүл үндэслэлгүй ялгаварлан гадуурхсан эсхүл худалдаанд нуугдмал хязгаарлалт тавьсан гэх үтгыг илэрхийлэх болно.

Үүлэн тогтолцоонд (cloud) тоон өгөгдөлийг хадгалах шийдэл нь Монголын хувийн хэвшлийн салбарынханд шинэ зүйл биш юм. Тухайлбал, Монголын цахим арилжаа эрхлэгчдийн нэг болох Shopru.mn компани хэрэглэгчидийнхээ тоон өгөгдөлийг Amazon EC2 ( бүс нутгийн хэмжээнд тухайн өгөгдөлийг нутагшуулах боломжгүй учраас) дээр хадгалдаг байна.<sup>111</sup> Монгол Улсад байрладаг Дата төвөөр дамжуулан өгөгдөлийг Azura Stack хэмээх нэртэй үүлэн тогтолцоонд байршуулан хадгалах шийдлийг Монголын цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэгчдийн нэг болох Мобиком ХХК-ийн охин компани Мобинет нь саяхан нэвтрүүлж эхлүүлсэн. Үйлчилгээ байдлаар ажилладаг дэд бүтэц (IaaS) ба Платформ байдлаар ажилладаг дэд бүтэц (PaaS)-тэй, Microsoft Azure хэмээх үүлэн тогтолцоонд уялдуулан нэгтгэсэн системийн өргөтгөлийг Azure Stack хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь тухайн газарт нь нутагшуулсан (localized) тоон өгөгдөл, мэдээллийг агуулж, хадгалах боломжийг бүрдүүлж өгсөн байна.

### Нээлттэй мэдээлэл

Саяхан баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021 он) нь нээлттэй мэдээллийн зарчим, үйлчлэх хүрээг бий болгосон бөгөөд энэ нь эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, дүн шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой. Сонирхсон этгээд нь тодорхой мэдээллийг нээлттэй болгох хүсэлтийг мэдээллийг хариуцагч этгээдэд гаргах эрхтэй.

Нээлттэй мэдээллийг мэдээлэл хариуцагчийн цахим хүүдас болон 2020 онд байгуулсан төрийн нэгдсэн нээлттэй мэдээллийн систем (<https://opendata.gov.mn>) дээр "давхар" хэвлэн нийтлэх ёстой боловч энэ нь үндсэндээ хоосон хэвээр байна. Уг мэдээллийг боловсруулсан этгээд нь уг мэдээллээ тогтмол шинэчилж байх ёстой. Уг хууль нь дараах тохиолдолд нээлттэй мэдээллийг нийтлэхийг хуулиар хориглоно. Үүнд: хэрэв нээлттэй мэдээллээр дамжуулан төрийн болон албаны нууц, хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлэх боломжтой бол; хэрэв нээлттэй мэдээлэл нь оюуны өмчийн эрхийг зөрчсөн бол; хэрэв нээлттэй мэдээллийг нийтлэх нь хувь хүнс, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байгаа бол. Нээлттэй мэдээллийг хэвлэн нийтлэхтэй холбоотой гарсан маргааныг уг мэдээлэл хариуцагч шийдвэрлэхээс гадна шүүхэд гомдол гаргах боломжтой.

Үүний зэрэгцээ, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэд хэдэн асуудлыг тодорхой болгон тайлбарлах эрхээ хадгалж авч үлдсэн байдаг. Эдгээрт мэдээлэл хариуцагчаас нээлттэй, мэдээллийг үүсгэх, нийтлэх, ашиглах нөхцөл ба журам, нээлттэй мэдээлэлд тавих шаардлага, төрийн нэгтгэсэн нээлттэй мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам; үнэ төлбөргүй нийтлэх мэдээллийн ангилал; үнэ төлбөргүй нийтлэхгүй эсхүл урьдчилан нийтлэхгүй мэдээллийг хураамж төлж авах бол төлбөрийг тооцох аргачлал зэрэг хамаарна. Эдгээр журмын заримыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ) баталсан болно.

Машинд унших формат, хайлт хийх, мета мэдээллийг оруулах, Хэрэглээний програм члалын интерфейс (API)-ийг ашиглах зэрэг тус хуулийн эх бичвэрт хараахан тусгаагүй, нээлттэй мэдээллийн зохицуулалтын шилдэг туршлагыг хуулийг хэрэгжүүлэх журамд тусгаж болно. Мэдээллийг нийтэд нээлттэй болгохын тулд тухайн агуулгын талаар төрийн байгууллагатай тогтмол зөвлөлдөж байх нь зүйтэй.

## Нууцлал ба арилжааны нууцыг хамгаалах

Байгууллагын нууцын тухай хууль (1995) нь хуулийн этгээдийн нууцыг хамгаалах үндсэн бүтэц, үйлчлэх хүрээг бий болгож, “Хүний эрх, нэр төр, алдар хүндтэй холбоотойгоор байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор, холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлс” хэмээн тодорхойлжээ. Дээрх зүйлсэд байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор тухайн байгууллага өөрөө нууцалж хамгаалалтаа авсан, задруулбал тус байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй” технологийн шийдэл, төсөл, судалгаа, шинжилгээ зэргийг хамруулсан байж болно. Холбогдох бодлогыг бий болгох замаар байгууллагын мэдээллийг заавал хамгаалах үүрэг хариуцлагыг тухайн байгууллага өөрөө хариуцдаг. Байгууллагын мэдээллийн зарим нь зохиогчийн эрх (компьютерийн программ хангамж, мэдээллийн сан), патент, худалдааны нууц болон бусад төрлийн оюуны өмчийн эрхийн (IP) хамгаалалттай байж болно.

## Кибер аюулгүй байдал

УИХ-аас 2010 онд баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд (48 дугаар тогтоол) мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болгон тунхагласан байдаг. Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах нь “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын нэг хэсэг. Монгол Улс 2021 оны 12 дугаар сард Кибер аюулгүй байдлын тухай хуулийг баталснаар, кибер аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтаа шинэчилсэн бөгөөд 2022 оны тавдугаар сард хууль ёсоор хүчин төгөлдөр болсон боловч хэрэгжүүлтэд анхаарах шаардлагатай хэвээр байна. Тус хууль нь тухайн салбарын ялангуяа хянан шийдвэрлэх процессийн хувьд олон улсын шилдэг туршлагад бүрэн нийцээгүй байна.

Уг хууль нь кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах, уг хуулийн хэрэглээг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур өргөжүүлэхийг зорьж байгаагаас гадна, Монгол Улсын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээгээр дамжуулан үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэн, харъяа лалгүй хүн, гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд энэ хууль нэгэн адил үйлчилнэ. Хуулийн үндсэн зарчимд нэгдсэн удирдлага; шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацийн арга хэмжээ; үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүний нөөцийн чадавх; эрсдэлд суурилсан үнэлгээ; төр болон хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах; олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг хамаарч байна.

Уг хуульд, одоогоор хараахан байгуулаагүй орон тооны бус Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ерөнхий удирдлаган дор төрөл бүрийн ажлыг гүйцэтгэхээр, мөн кибер аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцийг тусгасан. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх гурван төв (үндэсний, нийтийн, зэвсэгт хүчний төв) байгуулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн тус хуулинд кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хамаарах байгууллага, бүлгийн үүрэг, хариуцлагыг тогтоож өгсөн. Үүнд: онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага (тухайлбал нэгдсэн төлбөр, тооцоо, гүйлгээний цахим систем бүхий банк санхүүгийн байгууллага), зүй ёсны монополь буюу давамгайл байдалтай харилцаа холбоо, мэдээллийн технологийн (ICT) үйлчилгээ эхлэгчид болон мэдээлэл, шуурхай удирдлагын төв; дата төв, түүний салбар болон нөөц төвийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага, нүндсэн болон дэмжих мэдээллийн систем, суурь мэдээллийн сан хариуцагч байгууллага; хилийн боомтын хяналт, удирдлагын систем хариуцсан байгууллага, мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын чиглэлээр харилцаа холбоо, мэдээллийн технологийн (ICT) үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд болон бусдадаж ахуйн нэгж, багйууллага хамаарна.

### Цахим дамжуулалт ба дижитал бараанд ногдуулах гаалийн татвар

Барааг тодорхойлох, кодлох үялдуулсан систем (БТКУС)<sup>112</sup> -ийн бүлэгт цахим дамжуулалтын тарифын мөрийг агуулаагүй байдаг тул Монгол Улсын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн тухай хуулийн дагуу цахимаар дамжуулсан бараанд гаалийн татварыг ногдуулах боломжгүй. Монгол Улс дижитал бараанд гаалийн татварыг ногдуулах талаар техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа (feasibility study)-г хараахан хийгээгүй байгаа ба ДХБ-ын Үйл ажиллагааны хөтөлбөр болон Хамтарсан санаачилга (JSI)-ын хэлэлцээнд энэ талаар хатуу байр суурь илэрхийлээгүй байна. Монгол-Японы чөлөөт худалдааны хэлэлцээрийн 9.3 дугаар зүйлд зааснаар цахимаар дамжуулсан бараанд гаалийн татвар ногдуулахыг хориглосон байдаг. Одоогоор Монгол Улс энэ амлалтаа биелүүлж байгаа.

Монгол Улсад дижитал бараа (компьютерийн программ хангамж, текст, дүрс бичлэг, зураг, дууны бичлэг болон дижитал код бүхий бусад бүтээгдэхүүн, зөөвөрлөгч төхөөрөмж дээр байршуулсан эсхүл цахимаар хэлбэрээр дамжуулсан эсэхээс үл хамааран)-ийг өргөн хэрэглэж байгаагийн зэрэгцээ, ийм бүтээгдэхүүнд олгосон Үндэсний нөхцөл (NT) болон үндэстний нэн тааламжтай нөхцөл (MFN) олгох эрх зүйн зохицуулалт байхгүй боловч Монгол-Японы чөлөөт худалдааны хэлэлцээрийн 9.2-р зүйлд заасан үүрэг хариуцлагатай зөрчилдөж болзошгүй байна. Инновацийн тухай хуульд (2012) компьютерын программ хангамжийг дотооддоо боловсруулан хөгжүүлэхийг дэмжсэн гэж зарим талаар ойлгож болох ч гэсэн, ийм татаасыг олгохоор тогтоосон байсан ч гэсэн, холбогдох дүрэм, журмын дагуу үл хамаарах зүйлд хамаарах болно.

---

<sup>112</sup> ДХБ, "Монгол улс, Тарифын жагсаалт CXXXIV (134)", Дэлхийн Худалдааны Байгууллага I Барааны тарифын жагсаалтын цахим сан, 2022.12.01-нд хандсан <https://goods-schedules.wto.org/member/mongolia>.

## 7. ЦАХИМ АРИЛЖААНЫ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ

*Мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT), цахим хэрэглэгч, дижитал бизнес эрхлэх болон хэлний ур чадварыг хөгжүүлэх нь Монгол Улсын цахим арилжааны цаашдын өсөлт хөгжилд зайлшгүй шаардлагатай юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) ур чадварыг хөгжүүлэх асуудал нь хангалттай анхаарал татаж, дутуу орон зайг нөхөх хэтийн зорилгоос үр өгөөж хүртдэг. Харин албан ёсны боловсролын сургалтын хөтөлбөр, цахим арилжаанд шаардлагатай ур чадварын хооронд ихээхэн зөрүү байсаар байна. Ийм ур чадварыг ажлын байрны сургалтын үе шатыг нэмэгдүүлэх замаар нь ихэвчлэн ажил эрхлэх явцад бий болгодог. Ихэнх албан ёсны боловсролын байгууллагад Мэдээлэл, харилцаа холбооны технологийг сургалтын үйл явцад нэвтрүүлэхэд шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж, чадварлаг боловсон хүчин дутмаг байдаг. Цахим арилжаатай холбоотой янз бүрийн ур чадварыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй тохиолдлын чанартай гарсан санаачилгыг гарааны бизнес эрхлэгчдийг (startups) бойжуулагч нар болон хурдасгуур хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нар гарган хэрэгжүүлсэн байдаг. Ихэнхдээ өрсөлдөөний үндсэн дээр ийм туслалцааг үзүүдэг бөгөөд тэдгээр нь харьцангуй цөөн тооны холбогдох аж ахуйн нэгж, хувь хүмүүст ашиг тусгаа өгдөг.*

### 7.1. Цахим арилжааны ур чадвар

Дижиталчлал нь олон улсын хөрөнгө оруулалтын байршлыг тодорхойлогч хүчин зүйлсийг өөрчилж, боловсролын стандарт, ур чадвар чухлыг харуулж байна. Цахим арилжаатай холбоотой орчин үеийн ур чадвар, дижитал эдийн засагт оролцох оролцоо нь чухал боловч эдгээрийг мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадамжаар хязгаарлаж болохгүй. Энэ салбарт ажиллаж буй бизнес эрхлэгчид болон хэрэглэгчид мөн дараах ур чадвар шаардлагатай. Үүнд: нийгэм, ажил хэрэг, бизнесийг манлайлах чадвар, хэрэглэгчийн дижитал чадамж, хэлний чадвар хамаарна. Монгол Улсын судалгаанд оролцогчдын эдгээр багц ур чадвар, тэдгээрийн хөгжүүлэлтийн талаар дүн шинжилгээ хийж дараах хэсэгт харуулав.

#### Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) ур чадвар

Цахим арилжаанд оролцоход компьютер, ухаалаг утас зэрэг мэдээлэл, харилцаа холбооны технологийн тоног төхөөрөмжийг тодорхой түвшинд эзэмшсэн, мэдээлэл, харилцаа холбооны технологийн ур чадвартай байх шаардлагатай. Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) нь эдгээр ур чадварын даалгаврыг биелүүлэх чадвараас нь хамааруулан хэд хэдэн бүлэгт хуваадаг (Хүснэгт 7).

**Хүснэгт 7:** Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн ур чадварын төрөл ба ур чадварын хөгжүүлэлт, 2021 он

МХХТ-ийн ерөнхий ур чадвар	МХХТ-ийн стандарт ур чадвар	МХХТ-ийн Ахисан түвшний ур чадвар
<ul style="list-style-type: none"> <li>● Файл (Files) эсхүл хавтсыг (Folder) хуулах, зөөх.</li> <li>● Баримт бичиг доторх мэдээллийг хуулах, зөөхийн тулд хуулах, буулгаж тавих (Copy, Paste) командыг ашиглах.</li> <li>● Хавсаргасан файл бүхий и-мэйл илгээх.</li> <li>● Компьютер болон бусад төхөөрөмж хооронд файл (Files) дамжуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Хүснэгтэд арифметикийн үндсэн томъёог ашиглах.</li> <li>● Шинэ төхөөрөмжийг холбох, суурилуулах.</li> <li>● Илтгэлийн программ ашиглан цахим илтгэл боловсруулж, бэлтгэх.</li> <li>● Программ хангамж хайх, татаж авах, суулгах, тохиргоо хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Программчлалын хэлээр компьютерийн программ бичих.</li> </ul>


Эх сурвалж: Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)

Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын мэдээллээс харахад, Монгол Улс Мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь болон стандартурчадвар дунд гэсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2021 онд нийтхүн амын 31 хувь нь ерөнхий, 22 хувь нь стандартурчадвартай байна.<sup>113</sup> Хүн амын 3 хувь нь Мэдээлэл, харилцаа холбооны технологийн ахисан түвшний ур чадвартай гэжээ. Ийм нөхцөл байдал нь чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлтыг ур чадварын бүх түвшинд гаргах хэрэгтэй байгааг нотлон харуулж байна.

### Хэрэглэгчийн дижитал чадамж


Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) ур чадвар нь дангаараа хэрэглэгчид онлайн орчинд итгэлтэй, найдвартай харилцаа тогтооход хангалтгүй юм. Хэрэглэгчдийг харилцан үйлчлэлийн янз бүрийн элементийг ойлгох, мэдээллийн найдвартай болон чухал эсэхийг үнэлэх, шаардлагатай бол эрхээ хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээх арга зам хайх зэрэг боломжийг олгодог хэд хэдэн чадамж маш хэрэгтэй байдаг. Монгол Улсын хэрэглэгчид барааны сонголт, үнэ, хүргэлтийн нөхцөл зэргийг нэн тэргүүнд тавьдаг бололтой, харин борлуулалтын нөхцөл, мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдал, цахим хуудас болон худалдагчийн талаарх мэдээлэл (нөхөн төлөх тохиолдолд нэн чухал байж болох), хэрэглэгчийн өгсөн шүүмж зэрэгт маш бага анхаарал хандуулдаг байна (Зураг 36 ба Зураг 37). Энэ нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын мэдээллээр нотлогдож байгаа бөгөөд Монгол Улсын иргэдийн дөнгөж 18 хувь нь онлайнар олж авсан мэдээллийн найдвартай байдлыг шалгаж, 13 хувь нь тоног төхөөрөмж, компьютерийг нь хамгаалах аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээг авч чаддаг байна.<sup>114</sup>

**Зураг 36:** Онлайнар худалдан авалт хийх цахим хуудас сонгоход ямар шалгуур чухал вэ? (%)  
(Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

**Зураг 37:** Та онлайнар худалдан авалт хийх захиалга хийхээсээ өмнө ямар мэдээллийг хамгийн их шалгадаг вэ? (%) (Хэрэглэгчийн судалгаа, 151 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

### Нийгэм, бизнес, манлайлал, бизнес эрхлэх үр чадвар

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр чадвар ба бизнес эрхлэх чадамжийн хэд хэдэн бүлэг асуудал нь цахим арилжааг амжилттай хэрэгжүүлэхэд улам бүр чухал болж байна. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO) -ын мэдээгээр, ажил олгогчид МХХТ-ийн үр чадвараас гадна харилцааны үр чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч байдал, манлайлал<sup>115</sup> зэрэг нийгэм-зан үйлийн шинж чанартай үр чадварыг сонирхдог. МХХТ-ийн салбарт ажиллах онолын бэлтгэл хангалттай байгаа хэдий ч, Монгол Улсын их, дээд сургуулийн МХХТ-ийн чиглэлээр сурч төгсөгчдөд дээрх төрлийн үр чадвар дутмаг байдаг. Хэдийгээр монгол оюутнуудын бизнесийн үр чадвараа хөгжүүлэх сонирхол дутмаг биш ч инженерчлэл, компьютерийн шинжлэх ухаан, математикийн чиглэлээр суралцагч, хувь хүн, төслийн багийн хувьд ч өөр өөр үр чадварууд их чухал.

### Хэлний чадамж

Цахим хэлбэрээр нийтэлж буй контентын дийлэнх хувийг Монгол хэлнээс өөр хэлээр хүргэж байгаа тул Монголын хэрэглэгчид болон онлайн худалдаа эрхлэгчийн аль алинд нь гадаад хэлний мэдлэг чухал хүчин зүйл. Монгол хэл дээрх мэдээллийн хүртээмжийг Монголын хэрэглэгчид өндрөөр үнэлж, цахим худалдан авалтын шийдвэр гаргахад нь нөлөөлдөг бол (Зураг 36: Онлайнар худалдан авалт хийх веб хуудас сонгоход ямар шалгуур чухал вэ?), Англи болон бүс нутгийн бусад орны, түүний дотор Хятад, Орос хэл нь тодорхой платформ болон хэрэглэгчийн бүлэгтэй харилцахад дэм тустай. Энэ хандлагыг

<sup>113</sup> "Дижитал хөгжлийн хяналтын самбар", ОУЦХБ, 2022.12.01-нд хандсан <https://www.itu.int:443/en/ITU-D/Statistics/Dashboards/Pages/Digital-Development.aspx>.

<sup>114</sup> "МХХТ-ийн үр чадвартай хүмүүс, үр чадварын төрлөөр нь", ОУЦХБ-ын DataHub, 2022,12,04-нд хандсан <https://datahub.itu.int/data/?i=100082&e=MNG&c=1892>.

<sup>115</sup> Боловсролын салбар дахь МХХТ-ийн бодлогын тойм тайлан: Монгол Улс' (ЮНЕСКО, 2021), <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379606>

нотолж, ЖАЙКА-гийн судалгаанд хамрагдсан гарааны бизнес эрхлэгчдийн нэлээд хэсэг нь гадаадын орны хоёр хэл эзэмшсэн байдаг гэж мэдээлсэн. Холбогдох хэлний чадамжийг илүү хөгжүүлэхийн тулд дутуу орон зайг хиймэл оюун ухаан, тухайлбал онлайн орчуулгаар нөхөж байна.


## 7.2. Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэх, үр чадварын зөрүүг арилгах арга зам

Монгол Улсын иргэдийн цахим арилжаа, дижитал үр чадварыг албан боловсрол, түүний дотор заавал болон сонгон суралцах хичээлээр (дээд боловсролын) дамжуулан хөгжүүлэх төлөв ажиглагдав. Албан боловсролыг заримдаа ажлын байрны сургалт эсхүл хөгжлийн түншийн зохион байгуулдаг тусгай курс, сургалтаар нөхдөг. Гарааны бизнес эрхлэгчдийн цахим арилжааны үр чадварыг бойжуулагч/инкубатор, хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэгчид хөгжүүлдэг боловч тэдгээр нь маш богино хугацаатай учраас сонгосон бизнес дээр хэрэгждэг. Эдгээр хэлбэрээр олон нийтэд тустай сургалтын үйл ажиллагаа бас явуулдаг.

### Үндэсний боловсролын системээр дамжуулан Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) үр чадварыг хөгжүүлэх

Монгол Улсын хүн ам мэдэгдэхүйц өсөж байгаа ба ҮСХ-ны тооцоогоор 2030 онд 3.76 сая, 2040 онд 4.33 сая, 2050 онд 5 сая хүрэх нь, ийм нөхцөлд үндэсний боловсролын тогтолцоог шинээр гарч ирж буй дижитал нийгмийн хэрэгцээнд нийцүүлэх нь онцгой чухал юм. МХХТ-ийн боловсрол нь Монгол Улсын албан боловсролын сургалтын хөтөлбөрт дунд сургуулиас эхлээд ЕБС төгсөх хүртэл тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Мөн мэдээллийн технологийн хичээл нь их сургуулийн нэгдүгээр курсын сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болдог. ҮСХ-ны мэдээгээр, сүүлийн жилүүдэд МХХТ-д хамааралтай техникийн мэргэжил эзэмшсэн их дээд сургууль төгсөгчдийн тоо тогтвортой байгаа бол бизнесийн удирдлагын мэргэжлээр төгсөгчдийн тоо 2016-2019 онд буурсан ба эргээд өссөн байна (Зураг 38).

**Зураг 38:** Их, дээд сургууль, коллежийн төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (NSO)



Монгол Улсын МХХТ-ийн боловсролын бодлогын талаар 2021 онд ЮНЕСКО-оос хийсэн цогц үнэлгээнд, МХХТ-ийн боловсролыг сайжруулах талаар нарийвчилсан зөвлөмж өгсөн нь тус улсын цахим арилжааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Уг үнэлгээний дүгнэлтэд орчин үеийн МХХТ-ийн төхөөрөмжийн хүртээмж сургуулийн болон гэр бүлийн орчинд хангалтгүй хэвээр байгааг тэмдэглэсэн, мөн боловсролын салбар дахь МХХТ-ийн соёл хараахан төлөвшөөгүй байгаа бөгөөд дээд боловсролын салбарын багш нарын МХХТ-ийн чадамжийн стандартыг нарийвчлан боловсруулж, холбогдох сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн хэвшүүлэх шаардлагатай байна гэжээ. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (TVET)-д цахим сургалт сайн хөгжиж байгаа боловч багш нарыг дижитал орчинд илүү сайн ажиллахад нь туслах нэмэлт сургалт шаардлагатай байна. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний чиглэлээр техникийн болон мэргэжлийн (TVET) боловсрол, өндөр технологийн хөдөө аж ахуй, гидропоник, аквапоник, аэропоникийн шинэ технологийг ашиглан хот суурин газрын аж ахуй, өндөр технологийн мал аж ахуйн үйлдвэрлэл, ба үйлдвэрлэлийн лаборатори / Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (FAB-LABS / STEM)-т түшиглэсэн хөнгөн нэмэлт орц материалын үйлдвэрлэл (Light Additive Manufacturing) зэрэг нь ялангуяа МХХТ-ийн элементүүдийг дотроо улам бэхжүүлэх нь үр өгөөжтэй байж, залуучуудын сонирхлыг татахуйц болж чадна.

Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо (MOSA)-ны мэдээгээр, Монгол Улсын МХХТ-ийн хөгжлийн зах зээлд программист, дизайнер зэрэг дунд шатны мэргэжлийн боловсон хүчин нь чанарын болон тооны хувьд хомсдолтой байгаа аж. Ихэнх гүйцэтгэх даалгавар нь аутсорсинг (outsourcing) буюу гадаадын нөөц, хүн хүчээр гүйцэтгүүлэх захиалгаас шалтгаалж байгаа тул ажилчид программчлалын үр чадвараас гадна хэлний зохих чадамжтай байх нь чухал юм. Түүнчлэн Монгол дахь олон жижиг бизнес эрхлэгчдийн хүрээнд хүний нөөцийн сайн арга түршлага, тухайлбал ажлын байрны тодорхойлолт, ажил олгогч болон ажилтан хоёрын аль алиных нь үүрэг, хариуцлага, байгууллагын соёл дутагдалтай байна.<sup>116</sup>

### Шигтгээ 1: Косен Техник мэргэжлийн коллеж

Монгол Улсын техникийн, тэр дундаа инженерийн боловсролын тодорхой дутуу орон зайг арилгахын тулд Жайка (JAICA) байгууллага болон Японы түншүүд, ялангуяа Японы Косэн (Kosen) үндэсний технологийн хүрээлэн, Үндэсний технологийн хүрээлэн, Сасебо (Sasebo) коллежийн дэмжлэгтэйгээр гурван коллежийг нээжээ. Тус коллежууд нь [сургуулиудын] 9-р ангийн (15 настай) оюутнуудыг 5 жилийн хугацаатай курст элсүүлдэг бөгөөд амжилттай төгссөний дараа, оюутнууд мэргэжлийн дунд түвшний инженерийн дипломыг авдаг байна. Диплом нэээмшигчдээ их сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжийг олгодог байна (4 жилийн хугацаатай бакалаврын хөтөлбөрийн 3-р курсээс эхлэн). Косэн [техник мэргэжлийн] коллежуудын сургалтын хөтөлбөр, заах арга зүй нь техникийн боловсролын чиглэлээр олон жилийн турш баримталжирсэн Японы арга хандлагыг Монголын үйлдвэрүүдийн инженерүүдэд онол, практик, харилцаа холбоо, манлайлах үр чадвар, бүтээлч чадварыг хослуулан одоогийн хэрэгцээтэй хослуулсан байдлаар хүргэдэг байна.

Эх сурвалж: Монгол улс дахь Косен техник мэргэжлийн коллеж

### Дагалдан ажиллах, дагалдан суралцах, ажлын байран дахь сургалтын бусад хэлбэр

Цахим арилжаатай холбоотой сургалтыг албан ёсны боловсролын байгууллагаас гадуур жишээлбэл, ажлын байран дээр ажилаа хийтэй хослуулан сургах замаар хийж байна. Эдгээр нь ихэвчлэн албан ёсны боловсролын дараах үр чадварын зөрүүг арилгах зорилготой байдаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар (2011) ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр ажилтныхаа үр чадварыг дээшлүүлэх, сургалтаас мэдлэг хуримтлуулах боломжоор хангах үүрэг хүлээсэн. Ийм байдлаар үр чадварыг дээшлүүлэхэд МХХТ-ийн сургалтыг багтааж болно. Туршилтын хугацаанд буюу гурван жил хүртэлх хугацаанд дагалдан ажиллах зохицуулалтыг хуульчилсан бөгөөд үүнийг бусад асуудлаас гадна дижитал үр чадварыг хөгжүүлэхэд ашиглаж болно. МХХТ-д идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг зарим хувийн хэвшлийн компаниуд их дээд сургуулийн ахлах ангийн оюутныг "урт хугацаанд дадлагажуулах", улмаар шинэ ажилчдаа бүрэн

<sup>116</sup> АХБ, "Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв", 139.

хариуцлага хүлээх чадвар эзэмшүүлэхэд сургадаг. Тухайлбал, Мобиком компани ажилтнуудаа сургахад гурван жил орчим хугацаа зарцуулдаг учраас алдагдалд орохгүйн тулд зохион байгуулалтын бүтээлч шийдлийг гаргадаг ажээ.<sup>117</sup> Их сургуулийн сургалтын хөтөлбөр болон ажлын байранд шаардагдах үр чадварын хооронд илт зөрүүтэй байгааг шинэчлэхэд чиглэсэн боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй хэвээр байна.


### Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэхтэй холбогдуулан тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нийгмийн бүлэг

Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөөгийн хүн ам, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн тодорхой бүлгийн цахим арилжааны үр чадвар нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Эдгээр бүлгийн үр чадварын зөрүү болон тэдгээрийг арилгахын тулд авсан арга хэмжээний талаар авч үзье.

Насан түршийн боловсролын болон цахим номын сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх, шинжлэх ухааны салбарт үндэсний тэтгэлэгт хөтөлбөр, залуучуудын хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр өндөр технологи, инноваци, судалгаа шинжилгээний, мөн Залуучуудын хөгжлийн тухай хуульд (2017) заасан залуучуудад тусгайлан чиглэсэн боловсролын арга хэмжээнд сургалт багтсан байдаг. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай тогтолцоонд тэдний мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэхийн тулд, өндөр технологи, тусгай мэргэжил, үр чадвар эзэмшсэн залуучууд, тэр дундаа ажилгүй залуусыг сургалтад хамруулах зэрэг арга хэмжээ багтдаг.

НҮБ-ын Хүүхдийн сангаас саяхан хийсэн үнэлгээгээр, Монголын 15-24 насны залуучуудын МХХТ-ийн үр чадварын хөгжлийн ерөнхий түвшин нэлээд хязгаарлагдмал байгааг нотолсон бөгөөд текст болон баримт бичиг (files)/ баримт бичгийн хавтасыг (folders) хуулж, буулгаж тавих (copy/paste) чадварыг хамгийн их ашигладаг болохыг харуулсан (Зураг 39).

**Зураг 39:** 15-24 насны өсвөр үе, залуучуудад зориулсан МХХТ-ийн үр чадвар, Хүйсээр



Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн сан<sup>118</sup>

МХХТ-ийн үр чадвар нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудтай (31 хувь) харьцуулахад хөдөлгөөний бэрхшээлгүй залуучуудын хувьд (44 хувь, улсын дундаж) илүү сайн хөгжсөнийг тогтоосон. Боловсролын

<sup>117</sup> "Цахим бэлэн байдлын үнэлгээ: Цахим эрин дэх Монгол улс" (ХХМТГ, огноо байхгүй), 28, <https://artnet.unescap.org/sites/default/files/file-2019-11/Digital%20Readiness%20Assessment%20Final%20Draft%20%2009.09.pdf>.

<sup>118</sup> "MICS-EAGLE Mongolia, 2021 боловсролын мэдээллийн хуудас", огноо байхгүй, 31, [https://data.unicef.org/wp-content/uploads/2021/11/MICS-EAGLE\\_Education\\_Fact-sheets\\_2020\\_Mongolia.pdf](https://data.unicef.org/wp-content/uploads/2021/11/MICS-EAGLE_Education_Fact-sheets_2020_Mongolia.pdf)

түвшний хувьд их, дээд сургууль, ахлах сургуулийн төгсөгчид (тус бүр 54 хувь) МХХТ-ийн үр чадварын хамгийн өндөр түвшинтэй байсан бол техник мэргэжлийн боловсрол эзэмшиж буй хүмүүс зөвхөн 18 хувийн үзүүлэлттэй байжээ. Эцэст нь газарзүйн байршлын хувьд Улаанбаатар хотын залуучуудад (55 хувь) МХХТ-ийн үр чадвар хамгийн сайн хөгжсөн байсан бөгөөд чинээлэг орон сууцны хорооллоос судалгаанд оролцогчид 64 хувь хүртэл өндөр оноо авчээ. Хамгийн бага буюу 20 хувийн дундаж оноог хөдөө орон нутгийн төлөөлөл авсан байна.<sup>119</sup>

Монгол Улсад интернэт, компьютерийн хэрэглээний хүртээмж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд энэ тоо ойролцоогоор 129,979 (2019 онд 4.1 хувь) байна. Монгол Улс Дижитал хүртээмжийн эрхийн үнэлгээний (DARE) индексийн үзүүлэлтээр 42/100 оноо авсан ба энэхүү үнэлгээний индекс нь тухайн улс орны өмгөөлөгчид, Засгийн газар болон бусад оролцогч талыг улс орныхоо ахиц дэвшлийг олон улсын жишиг үзүүлэлттэй харьцуулан үнэлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм.<sup>120</sup> Хараагүй, харааны бэрхшээлтэй ба хэвлэмэл бүтээлийг унших чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэгдсэн бүтээлийн хүртээмжийг хөнгөвчлөх тухай Марракешийн хэлэлцээр (2013), мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006) зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын томоохон гэрээ, хэлэлцээрийг соёрхон баталж, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг тусгайлан баталж (2016), түүнчлэн хэрэгжүүлэгч агентлаг байгуулсан боловч Монгол Улс нь олон улсын жишиг<sup>121</sup> суурилсан МХХТ-ийн хүртээмжийг хангах стратегийг хараахан хэрэгжүүлээгүй байна. Ийм стратегийг боловсруулах, уг стратегийг дээд боловсролын сургалтын хөтөлбөрт уялдуулан оруулах замаар МХХТ-ийн хүртээмжийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд хөгжлийн түнш байгууллагуудыг (DPOs) татан оролцуулах тал дээр хоцрогдолтой байна. Үүрэн гар утас, интернэтийн хүртээмж ба хэрэглээ, цахим засаглал, боловсрол ба хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь МХХТ нь хүртээмжтэй байдлыг сайжруулах төслүүдийн хувьд төдийлөн хөндөгдөөгүй салбаруудын нэг юм. Нөгөө талаар, "Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги: 2019-2024" баримт бичигт төр болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх салбарт хамтран ажиллах талаар тусгасан байдаг.

Хөдөөгийн хүн амын дижитал үр чадварыг хөгжүүлэх нь, жишээлбэл, хөдөө аж ахуй, мал нядалгаа, мах, арьс шир, утас ээрч боловсруулах гэх мэт салбарт баримталдаг орчин үеийн стандартыг тайлбарласан онлайн сургалтын материал ашиглах, курст сурах зэрэг боломжийг хөнгөвчилж болох юм. Энэ чиглэлээр Дэлхийн банкны санхүүжилттэй экспортыг дэмжих төслийн хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагаас (UNIDO) Монгол хэлнээ орчуулж буй сургалтын нэг жишээ бол Монгол Улсад итгэмжлэл, баталгаажуулалтын үйлчилгээг бэхжүүлэх<sup>122</sup> явдал юм. Эдгээр стандартыг хэрэгжүүлснээр олон улсын зах зээл дээр Монгол Улсын экспортын чадавхид эерэгээр нөлөөлнө. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) зэрэг бусад хөгжлийн түншүүд 2022 оны 4 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны яам (MDDC)-тай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн<sup>123</sup> үндсэн дээр хөгжлийн

<sup>119</sup> "MICS-EAGLE Mongolia 2021 боловсролын мэдээллийн хуудас", 32.

<sup>120</sup> G3ICT: "Дижитал тоон хүртээмжтэй холбоотой эрхийн үнэлгээний индекс (DARE Index): Монгол улс, Хяналтын самбар", G3ict: МХХТ-уудыг оролцуулсан Дэлхий нийтийн санаачилга, 2022,12,03-нд хансан, <https://g3ict.org/country-profile/mongolia>

<sup>121</sup> "Хараагүй, харааны бэрхшээлтэй болон бусад хэлбэрийн хэвлэлийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэвлэгдсэн бүтээлд нэвтрэх боломжийг хөнгөвчлөх Марракешийн гэрээ", 2022,12,12-нд хандсан <https://www.wipo.int/treaties/en/ip/marrakesh/index.html>; "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (CRPD)", 2022,12,12-нд хандсан <https://www.un.org/development/desa/disabilities/convention-on-the-rights-of-persons-with-disabilities.html>.

<sup>122</sup> "Жижиг, дунд хөдөө аж ахуйн бизнесүүдийн экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд баталгаажуулалтын үйлчилгээг бэхжүүлэх нь", НҮБ-АҮХБ (UNIDO) нээлттэй мэдээллийн платформ, 2022,12,04-нд хандсан <https://open.unido.org/projects/MN/projects/200021>.

<sup>123</sup> "Цахим бэлэн байдлын үнэлгээ: Цахим эриндэх Монгол улс"; НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 'UNDP Mongolia Accelerator Lab' нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг интернэтэд илүү хамруулахыг уриалж байна', НҮБХХ, 2022,12,15-нд хандсан, <https://www.undp.org/mongolia/blog/undp-mongolia-accelerator-lab-pushes-more-internet-inclusion-people-disabilities>.

бэрхшээлтэй хүмүүст хүрэх хүртээмжийг хөнгөвчлөх, мэдээллийн технологийн программ хангамжийн агуулгыг Монгол хэл дээр орчуулах хөтөлбөрийг<sup>124</sup> хэрэгжүүлж байна.

Монгол Улсын эмэгтэйчүүдийн Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үндсэн болон ерөнхий үр чадвар эрэгтэйчүүдтэй эн зэрэгцдэг.<sup>125</sup> Их дээд сургуульд МХХТ-ийн чиглэлээр суралцаж буй эмэгтэйчүүдийн тоо ангийнхаа эрэгтэй оюутны тооноос давж байгаа хэдий ч Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт эмэгтэйчүүдийн бодит хөдөлмөр эрхлэлт нь эрэгтэйчүүдийн бараг хагас хувь дахин доогуур байна (ҮСХ-ийн мэдээгээр 2021 онд МХХТ-ийн салбарт 10,327 эрэгтэй, 5,648 эмэгтэй ажиллаж байсан). Энэ нь хэдийгээр өндөр боловсролтой ч Монголын ажиллах хүчний зах зээлд эмэгтэйчүүдийн оролцоо бага байгааг харуулж байна. Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагад хүргүүлсэн “Худалдааны бодлогыг хянан үзэх нь” тайлан (TPR)-г 2021 онд боловсруулсан асуулт, хариултаас эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдээс өндөр байгаа ч 2020 оны байдлаар ажиллах хүчний оролцоонд эмэгтэйчүүдийн (53.4 хувь) эзлэх хувь эрэгтэйчүүдээс (69.4 хувь) 16.1 нэгжээр доогуур байгааг олж тогтоосон байна.<sup>126</sup>

Олон эмэгтэйчүүдийг МХХТ-ийн салбарт татан оролцуулахын тулд 2014 онд МХХТ-ийн чиглэлээр их дээд сургууль төгссөн эмэгтэйчүүд болон эмэгтэй бизнес эрхлэгч нарт (WBOs) чиглэсэн хурдасгуур хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлж байна. Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн чиглэлээр их дээд сургуульд суралцаж буй эмэгтэйчүүдийн үр чадварыг дээшлүүлэх богино хугацааны хөтөлбөр саяхан хэрэгжиж эхэлсэн (Шигтгээ 2).

## Шигтгээ 2: Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжсэн санаачилга

Мэдээлэл, технологийн үндэсний парк-Улсын төсөвт инкубатор/бойжуулагч байгууллага нь 2014 оноос нийгмийн хөгжлийг дэмжих, шинэлэг санаатай эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж салбарын үйл ажиллагаанд татан оролцуулах, улмаар мэдээллийн технологийн эрин зуунтай холбоотойгоор эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн салбарт жендерийн эрх тэгш байдлыг бий болгох зорилгоор зорилтот салбар буюу "мэдээллийн технологийн эмэгтэйчүүдийн бизнес инкубатор"-ыг эхлүүлсэн байдаг. Энэхүү хөтөлбөр нь мэдээллийн технологийн салбарт таван жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж буй Монголын эмэгтэй бизнес эрхлэгчдийн өмчит аж ахуйн нэгжүүдэд нээлттэй бөгөөд уг аж ахуйн нэгжийн үндсэн ажилчдын 80%-аас доошгүй хувь нь мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн эмэгтэйчүүд бөгөөд удирдах албан тушаалтнууд нь эмэгтэй хүн байдаг байна. Мэдээллийн технологийн (IT/MT) чиглэлээр төгссөн эмэгтэй хувь хүн болон MT-ийн арга туршлага хуримтлуулсан эмэгтэйчүүд элсэх боломжтой бөгөөд тэдний элсэлтийн хувьд арай бага хатуу шаардлага тавьдаг.<sup>127</sup> Монгол дахь Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх сангаас 2021 онд санхүүгийн эрэлт хэрэгцээтэй гэдэг нь нотлогдсон, ирээдүйтэй эмэгтэй оюутнуудыг дэмжих зорилгоор Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн тэтгэлэгт хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэ нь МУИС-ийн Мэдээлэл, компьютерийн шинжлэх ухааны тэнхимд төвлөрсөн Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн аль нэгэн мэргэжлээр суралцаж буй хоёрдугаар курсын оюутнуудад зориулсан зургаан сарын хугацаатай хөтөлбөр юм. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөр нь Монголын МХХТ-ийн чиглэлээр суралцаж төгсөгчдөд ихэвчлэн дутагдалтай байдаг гол үр чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үйлдүүлэн нэгтгэсэн байдаг. Энэ хөтөлбөр нь мөн гадаад хэлний чадамжийг сайжруулах асуудлыг шийдвэрлэж, тэтгэлэг хүлээн авагчдын манлайлах чадавхийг нэмэгдүүлдэг. Тэтгэлэгт хэсэгчилсэн сургалтын төлбөр, англи хэлний эрчимжүүлсэн сургалт, дижитал тоон сургалтын арга хэрэгсэл, хувь хүний хөгжлийн боломж багтдаг.<sup>128</sup>

<sup>124</sup> ЦХХХЯ, 'Цахим хөгжил, харилцаа холбооны яам НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа', 2022,04,12, <https://mddc.gov.mn/eng/4731/>

<sup>125</sup> "Монгол дахь эмэгтэйчүүд ирээдүйн ажлын байр" 2019,09, <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/15735.pdf>

<sup>126</sup> Худалдааны бодлогын хяналтын байгууллага, 'Худалдааны бодлогын тойм – Монгол Улс 2021 (Нэмэлт)'.

<sup>127</sup> .MTYП, 'Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн мэдээллийн технологийн инкубатор' төслийн зорилтот салбарын үйл ажиллагааны удирдамж', 2014, [https://itpark.mn/eng/wp-content/uploads/2014/12/guideline\\_women.pdf](https://itpark.mn/eng/wp-content/uploads/2014/12/guideline_women.pdf).

<sup>128</sup> WE Mongolia, "STEM Тэтгэлэгт хөтөлбөр", WE Mongolia, 2022.12.15-нд хандсан, <https://www.wemongolia.org/stem-scholarship>.

### **7.3. ЖДҮ-ийн цахим арилжааны ур чадварыг бойжуулж, хурдасгах**

Монголын гарааны бизнес эрхлэгчдийн (startups) экосистемийн талаар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын хийсэн судалгаанаас харвал, үндэсний хэмжээнд 10-аас доошгүй инкубатор/бойжуулагч байгууллага идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Бойжуулах үйл ажиллагааг төрийн байгууллагууд (жишээлбэл, Мэдээлэл, технологийн үндэсний парк) болон хувийн хэвшлийн байгууллагын (жишээ нь Intelmind<sup>129</sup>) аль аль нь явуулдаг бөгөөд тэдгээр нь барилга байгууламжаар хангаж, сургалт ба зөвлөн туслах үйлчилгээг санал болгох хандлагатай байдаг.

---

<sup>129</sup> Intelmind, 'Intelmind Llc', intelmind.mn, 2022.12.15-нд хандсан, <https://intelmind.mn/>.

### Шигтгээ 3: Мэдээлэл, технологийн үндэсний парк, MonJa, KITE Mongolia хэмээх гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах, хурдасгуур хөтөлбөр

Мэдээлэл, технологийн үндэсний парк нь Улаанбаатар хотод байрладаг төрийн өмчит Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ИТС) инкубатор/бойжуулагч бөгөөд сургалт, судалгааны үйлчилгээг санал болгож ажилладаг гадна, мэдээллийн технологийн хэд хэдэн шалгалтуудад зориулан (Мэдээллийн технологийн инженерүүдийн шалгалт /ITEE/, Мэдээллийн технологийн практик үр чадварын шалгалт /TOPCIT, Олон улсын компьютерийн удирдлагын үнэмлэх /ICDL/) шалгалт авах төв байдлаар ажилладаг байна. 2003 онд анхэлсүүлж эхэлснээс хойш тус инкубатор/бойжуулагч нь 148 гарааны бизнесийг бүртгэж авснаас 15 нь хөтөлбөртөө хамрагдсан хэвээр байна. 2023-2030 онд 295 гарааны бизнесийг элсүүлэхээр төлөвлөж байна. Гарааны бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээний багцад инкубаторын/бойжуулалтын баг, зөвлөх үйлчилгээ, ажлын орчин, интернэт холболт, сургалт, шилдэг төгсөгчдийн урамшуулал зэрэг үйлчилгээ багтсан болно. Бойжуулж гаргасны дараах үйлчилгээг 2021 онд нэвтрүүлсэн.<sup>130</sup> Туспаркийн Мэдээлэл, сургалт, судалгааны төв нь “Цахим Монгол” (E-Mongolia) хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт явуулах үүрэгтэй. Энэ байгууллагыг нийслэл, хөдөө орон нутгийн оюутан, залуучууд, олон нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлж мөн хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор мэргэжлийн болон бусад холбогдох сургалтуудыг зохион байгуулахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.<sup>131</sup> Цахим хуудаснаас нь үзвэл, тус парк (National IT Park) нь дараах сургалтуудыг санал болгон ажилладаг байна, үүнд: CPanel дээр анхан болон дунд шатны сургалт; VmWare; Мэдээллийн технологийн аюулгүй байдал; PHP; LINUX; Oracle; Сүлжээний үндэс, зохион байгуулалт, тохиргоо; Firewall; Android болон iOS-ийн арилжааны суурь боловсрол болон бусад сургалтууд ордог.<sup>132</sup> Мөн тус Үндэсний парк нь Монголын сансар судлалын холбоотой хамтран “Сансрын академи”<sup>133</sup> хэмээх кодчиллын интерактив/харилцан ажиллах боломжтой хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд элсэгчдийн тоо 100-д хүрчээ.

“МонЖа хэмээх Гарааны бизнес эрхлэгчдийг хурдасгах хөтөлбөр (MonJa Startup Accelerator Programme)”-ийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA) нь KDDI корпорацийн охин компани болох Мобиком Корпораци ХХК болон Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран, 2020 онд байгуулсан байна. Зургаан сарын хугацаатай энэхүү хөтөлбөр нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, гадаад дахь хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоож өгч харилцах, бизнесээ өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүүжилт олгох, түүнчлэн КОВИД-19 цар тахлын нөхцөлд мэдээллийн технологийн шийдлүүдийг хөгжүүлэх хоёр эрчимтэй сурталчлах арга хэмжээг зохион байгуулахыг зорьжээ.<sup>134</sup> “Клиника (Clinica)” хэмээх цахилгаан холбоогоор дамжуулан алсын зайнаас үзүүлэх эмчилгээ, оношилгоо буюу телемедициний үйлчилгээний гар утасны аппликейшн хөгжүүлдэг ASAP Care ХХК нь КОВИД-19 цар тахлын асуудлын хүрээнд оруулсан хувь нэмэр, цаашдын өсөлтийн боломжийн хувьд 2021 оны Шилдэг шагналын (Best Pitch) ялагчаар тодорлоо. Тус компани нь 2020 оны 6-р сард зургаан ажилтантайгаар байгуулагдсан бөгөөд одоогоор 41 эмч, 19 эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллаж, уг аппликейшнээр дамжуулан телемедицинийн үйлчилгээг санал болгож байна.<sup>135</sup> 2020 онд байгуулагдсан КИТЕ Монголиа ХХК (KITE Mongolia LLC) нь Монголын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг<sup>136</sup> шийдэхэд чиглэсэн техник технологид суурилсан шийдлийг санал болгодог гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан анхны хурдасгуур хөтөлбөр бөгөөд энэ нь Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ИТС) салбарт боловсролын хэд хэдэн үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээрийн дотроос, жишээлбэл, Хөдөө орон нутгийн ахлах ангийн 105 сурагчдад зориулсан KodUpNomads мэдээллийн технологийн кодчиллын хөтөлбөрийг Шууд тусламжийн хөтөлбөр (DAP) болон Монгол дахь Австралийн ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. 16 гарааны бизнес эрхлэгч оролцогчдыг оролцуулсан, Монголын залуучуудын бизнес эрхлэлтийн цуврал нэвтрүүлгийг Боловсрол телевизээр орон даяар цацсан бөгөөд энэ нь залуучуудыг нийгэм, эдийн засагт идэвхтэй оролцох урам зориг өгөх зорилготой байлаа. Энэ нэвтрүүлэг нь хурдасгуурын хөтөлбөр, нөөц эх үүсвэрүүдийг хооронд нь олж тааруулж өгдөг, дэлхийн түвшинд зохион байгуулдаг өрсөлдөөнт тэмцээнүүдийг<sup>137</sup> хамруулсан, эмэгтэйчүүд болон технологид зориулан жил бүр дэлхийн түвшинд зохион байгуулагддаг, гарааны бизнес эрхлэгчдийн хамгийн том өрсөлдөөн болох Тэр эмэгтэй технологид дуртай (She Loves Tech (SLT)) хэмээх нэвтрүүлгийн орон нутгийн хувилбар байлаа. Мөн энэ хүрээнд, нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд буяны хөрөнгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд, Нийгмийн инновацийн долоо хоног (SIW) хэмээх арга хэмжээг Азийн хөгжлийн банкны венчур (ADB Ventures) болон корпорацийн ивээн тэтгэгчидтэй хамтран зохион байгуулдаг. КИТЕ нь мөн энэхүү тайланд дурдсан Монголын гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн талаарх судалгаа хийхэд нь Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-д тусалсан.

<sup>130</sup> МТҮП, 'Хронологи', Мэдээлэл, технологийн үндэсний парк, 2022.12.15-нд хандсан, <http://eng.itpark.mn/>

Мэдээлэл, технологийн үндэсний паркийн шалгуур болон сонгон шалгаруулах журам нь хоёулаа албан ёсны бөгөөд ил тод байдагч Intelmind [Хөрөнгө оруулалтын удирдлагын хувийн компани] венчур студи нь гарааны бизнес эрхлэгчидээ тэдэнтэй хамтран ажиллах болзол, нөхцөлийн талаар хэлэлцээ хийсний дараа сонгодог байна. Ингэхдээ хамтрах ажиллана гэдгээ урьдчилан судалсан байдаг. Хурдасгуурын үе шатыг ямар нэгэн урьдчилсан зохицуулалтгүйгээр санал болгохдоо, зөвхөн өрсөлдөөний зарчмаар сонгогдсон хэд хэдэн компанид чиглэсэн дэмжлэг үзүүлдэг байна.

### Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт инкубатор, хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлдэг бусад боловсролын болон сургалтын үйл ажиллагаа

Монгол Улсад байгаа төрийн болон хувийн хэвшлийн инкубатор, хурдасгуур хөтөлбөрийг эдгээр хөтөлбөрт хамрагдсан компанид хэрэгжүүлэхээс гадна, нийтэд зориулан сургалтын үйл ажиллагаа явуулдаг.

Судалгаанд хамрагдсан хувийн хэвшлийн оролцогчдын хариултаас харахад, тэд цахим арилжааны бизнесийг хөгжүүлэхэд инкубатор/бойжуулагчийн өгсөн зөвлөгөөнд нилээд итгэдэг бөгөөд энэ нь зөвлөх үйлчилгээний компанийн өгсөн зааврын дараа хоёрдугаарт оржээ. Хувийн хэвшлийн хувьд заавар зөвлөгөө авах хүсэлтэй байдаг бусад аж ахуйн нэгжүүд нь хөгжлийн түнш байгууллага болон банк байна (Зураг 40).

**Зураг 40:** Цахим арилжааны шийдлүүдэд зориулсан санхүүжилтийн хувилбар (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 23 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

<sup>131</sup> МТҮП, 'Мэдээлэл, сургалт, судалгааны төв', 2022.12.15-нд хандсан, [https://itpark.mn/eng/?page\\_id=31](https://itpark.mn/eng/?page_id=31).

<sup>132</sup> МТҮП, "Мэдээллийн технологийн сургалтууд" 2022.12.15-нд хандсан, [https://itpark.mn/eng/?page\\_id=71](https://itpark.mn/eng/?page_id=71).

<sup>133</sup> MOSTA, Сансрын Академи 'Space Academy', 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://www.facebook.com/SpaceAcademyMongolia/>.

<sup>134</sup> ЖАЙКА, 'КОВИД-19-ийн эсрэг MonJa Startup Accelerator хөтөлбөрт гарааны бизнес эрхлэгчдийг хамрагдахыг урьж байна', 2020.10.10, <https://www.jica.go.jp/mongolia/english/office/topics/201010.html>.

<sup>135</sup> ЖАЙКА, "Цахим үндэстэн болохыг зорьж буй Монгол Улсын бизнес эрхлэгчдийн хөгжлийг дэмжих нь" 2021.12.20, [https://www.jica.go.jp/english/news/field/2021/20211220\\_01.html](https://www.jica.go.jp/english/news/field/2021/20211220_01.html).

<sup>136</sup> Kite, 'Kite Mongolia', Kite, 2022.12.15-нд хандсан, <https://kiteaccelerator.com/>

<sup>137</sup> She Loves Tech, 'She Loves Tech - Эмэгтэйчүүд ба Технологид зориулсан хамгийн том гарааны хурдасгуур платформ', She Loves Tech - Эмэгтэйчүүд ба технологийн дэлхийн хамгийн том хурдасгуур платформ, 2022.12.15-нд хандсан, <https://www.shelovestech.org>

## **Төсвийн санхүүжилттэй эрдэм шинжилгээний байгууллагын үүсгэн байгуулсан гарааны болон зөвлөх үйлчилгээний компани**

Инновацийн тухай хуулийн (2012) 27 дугаар зүйлд зааснаар, улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагыг үндэсний хэмжээнд инновацийн үйл ажиллагаанд оролцох үндсэн бүтэц, хамрах хүрээг тогтоож өгсөн байдаг ба энэ нь ялангуяа технологи дамжуулах, гарааны болон зөвлөх компаний асуудал хариуцах нэгж байгуулах замаар оролцох, эх орондоо инновац шингэсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, үйлчилгээ үзүүлдэг гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих үндсэн гол зорилготой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаснаар шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийг хөгжүүлэх зорилгоор<sup>138</sup> Засгийн газар нь их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнтэй хамтран ажиллах, үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөц хөрөнгийг төвлөрүүлж ажиллана.

Монгол Улсын хэд хэдэн эрдэм шинжилгээний байгууллага МХХТ-тэй холбоотой судалгааны нэгжийг байгуулсан. Үүнд: Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн Технологи дамжуулах төв, Монгол улсын Их сургууль (МУИС)-ийн Инноваци ба Технологи дамжуулах төв байна. Гэсэн хэдий ч эдгээр хамтын ажиллагааны хүрээнд захиргааны хязгаарлалт байгаа тул эрдэм шинжилгээ судалгааны байгууллагаас бизнесийн салбарын аж ахуйн нэгж рүү технологи дамжуулах ажил удаашралтай байгаа талаар тэмдэглэжээ.

### **7.4. Хөгжлийн түнш байгууллагын цахим арилжааны үр чадварыг бий болгох санаачилгад үзүүлж буй дэмжлэг**

Монгол Улсын ард иргэд, бизнес эрхлэгчдийн цахим арилжааны үр чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон төрлийн санаачилгыг хөгжлийн түнш байгууллагууд хэрэгжүүлж, эсхүл дэмжин ажиллаж байна. Тэдгээрийн дотор:

- Мэдээллийн технологи, харилцаа холбоо, аутсорсингийн (outsourcing) чиглэлээр мэргэшсэн Атал Бихари Важпай Тэргүүн туршлагын төв – Энэтхэгийн санхүүжилттэй төсөл (Энэтхэгийн хөгжил, эдийн засгийн түслэмжийн схем (IDEAS)) 2013 онд байгуулагдаж, 2022 онд өргөжсөн ба жилд 16 чиглэлээр<sup>139</sup> 5000 мэргэжилтэн бэлтгэнэ гэсэн хүлээлттэй байна.
- БНХАУ-ын “Шинэ зууны боловсрол” зээлийн төслөөр дамжуулан тус улсын ерөнхий боловсролын бүх сургуулийг интернэтэд холбоход дэмжлэг үзүүлнэ.
- АХБ-ны дэмжлэгтэйгээр боловсролын дата төв, “Эрдэмнэт” сүлжээний төвийг байгуулна.
- НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн Хурдасгуур лаборатори (Accelerator Lab) нь 2021 онд нээгдсэн, энэ нь эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүсийн дижитал шийдлийн хүрээнд үүссэн ялгааг арилгахад хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байгаа бөгөөд Монгол Улсын хот суурин газрын ард иргэдийн хувьд хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих болон бусад олон асуудлыг тусгасан.<sup>140</sup>

<sup>138</sup> Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020, [https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2020-2024\\_-ActionPlan\\_GOM\\_Eng\\_Edited\\_OE-2.pdf](https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2020-2024_-ActionPlan_GOM_Eng_Edited_OE-2.pdf) Objective 2.4.

<sup>139</sup> UB Post, “5000 мэргэжилтэн бэлтгэх мэдээллийн технологийн төв”, 2022.02.16, <https://www.pressreader.com/mongolia/the-ub-post/20220216/281526524481449>.

<sup>140</sup> НҮБХХ, ‘UNDP Mongolia Accelerator Lab’, НҮБХХ, 2022.12.15-нд хандсан, <https://www.undp.org/acceleratorlabs/undp-mongolia-accelerator-lab>



## Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих

ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь ЖДҮ-ийн зах зээлийг өргөжүүлэх, борлуулалтыг нь дараах байдлаар дэмжих явдал юм. Үүнд:


- Дотоодын болон гадаадын бизнесийн боломжийн судалгааг дэмжих, мэдээллээр хангах, цахим арилжааг хөгжүүлэх;
- Бараа, үйлчилгээний маркетингийн талаарх мэдээлэл, мэдлэг олгох;
- Дотоод, гадаадад зохион байгуулах үзэсгэлэн яармаг, олон улсын үзэсгэлэн худалдаа, бизнес уулзалтад оролцоход дэмжлэг үзүүлэх;
- ЖДҮ-ийн зорилтот бүлэгт чиглэсэн хүний нөөцийн сургалт зохион байгуулах;
- ЖДҮ-ийн кластер, санаачилгыг дэмжиж, кластерын гишүүдэд нэн тэргүүнд дэмжлэг үзүүлэх.

Түүнчлэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн (2019) 8 дугаар зүйлийн 8.1.5-д зааснаар, Засгийн газар худалдан авалтаараа дамжуулан ЖДҮ-г дэмжлэг үзүүлнэ. Үүний дагуу Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)-д, ЖДҮ-ийг тендерт оролцогч бусад оролцогчоос дотоодын давуу эрхийн дагуу 15 хувийн давуу эрх олгохоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

### 7.5. Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

Дээр дурдсан судалгааны үр дүн нь Монгол Улсад цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэхэд хамгийн их хамааралтай хүчин зүйлсийн талаар оролцогч талуудын өгсөн саналтай нийцэж байна, энэ нь Монголын зах зээл дээр бойжуулалт, хурдасгуурын үйлчилгээ зарим талаар хязгаарлагдмал байгааг харуулж байна. Мөн хувийн хэвшлийн судалгаанд оролцогчдын 87 хувь нь цахим арилжааны чиглэлээр хөгжлийн түнш байгууллагаас хэрэгжүүлж буй аливаа хөтөлбөрийн талаар мэдээлэл дутмаг байна (Зураг 41).

**Зураг 41:** Цахим арилжааны үр чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай тэргүүлэх үйл ажиллагаа (%) (Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 91, хувийн хэвшлийн 23 )



Эх сурвалж: НУБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

## 8. САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН ХҮРТЭЭМЖ

*Бичил, жижиг, дунд үйлдвэрийн хувьд цахим арилжаа эрхлэхэд тулгарч буй хамгийн том бэрхшээл нь санхүүгийн хүртээмжгүй байдал, түүнчлэн бизнес эрхлэх боломжийн талаарх ойлголт бага төдийгүй чадавх сул зэрэг нь улам нэрмээс болж байна. ЖДҮ-ийн хүрээнд гаргасан санаачилга нь голчлон дотоодын зах зээлд чиглэж байна. Санхүүжилтийн бусад альтернатив хэлбэрийн хувьд эрхзүйн зохицуулалт дутмаг байгаа нь түүнд итгэх итгэл, улмаар Монгол Улсад тэдгээрийг ашиглахад нь саад болж байна. Монгол Улсын гарааны бизнес эрхлэгчдийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлдэггүй учраас хөрөнгө оруулагчид үр дүнтэй шийдвэр гаргах боломжийг хангах хэмжээний мэдээллийг хүлээн авч чадахгүй байна. Үүний улмаас, Монголын хэд хэдэн гарааны бизнес эрхлэгч “өсөлтийн стратеги”-дээ өөрсдийн бүтээгдэхүүнээ санхүүжүүлэх шийдлийг төрөлжүүлэхэд чиглүүлж байгаа бөгөөд үүнд гадаадад охин компани байгуулах зэрэг асуудал орж байна.*

### 8.1. Монгол Улсын технологийн чиглэлийн гарааны бизнесийн экосистемийн талаарх тооцоолол


Инновацийн тухай хуульд (2012) гарааны бизнес эрхлэгчдийг “инновацийн бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компани” гэж тодорхойлсон байдаг. Тэдний ойлголтоор, шинэлэг бүтээгдэхүүнийг “техник, эдийн засгийн үзүүлэлт, шинжлэх ухааны чадавх, нэмүү өртөг шингээсэн бүтээл бий болгох, өрсөлдөх чадвар зэргийн хувьд, зах зээл дээрх ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс илүү [...] шинэлэг бүтээлч үйл ажиллагааны үр дүн” гэж үздэг ажээ. Инноваци гэдэг нь “шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдэл” гэсэн үг. Энэхүү нэр томъёо нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох тодорхойлолттой үзэл баримтлалын хувьд нийцдэг. Гэсэн хэдий ч энэхүү судалгаа нь технологид суурилсан компаниуд болон тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг нарийвчлан судлахад анхаарлаа хандуулахыг шаардаж байна. Мэдээлэл технологийн үндэсний парк нь өөрсдийн бойжуулалт болон хурдасгуур хөтөлбөрийн үр ашгийг хүртэгч нарт зориулан тэдэнд тавигдах шаардлагыг тогтоохдоо "инноваци" гэдгийг “мэдээлэл, технологийн салбарт ажиллаж буй хувь хүмүүс, компани, аж ахуйн нэгжийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь мэдээлэл, технологийн салбарынх байхаас гадна, Монголын болон олон улсын зах зээлд гарах магадлалтай, эдийн засгийн хувьд үр ашигтай, бүтээлч санаа байх болно”<sup>141</sup> гэж тайлбарлажээ. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)<sup>142</sup>-аас Монголын технологид суурилсан гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн талаар сүүлийн үед хийсэн судалгааг СтартАп Женом (Startup Genome)-ийн Дэлхийн гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн талаарх тайлан (Global Startup Ecosystem Report/GSER)-д үндэслэн хийсэн бөгөөд энэ судалгаанд Монголын гарааны бизнес эрхлэгчийн ажлын гүйцэтгэл; санхүүжилт; зах зээлд нэвтэрч ажиллаж буй байдал; түршлага, авъяас чадвар, мэдлэг; түүнчлэн дэд бүтцийн холболт (нэмэлт үзүүлэлт) зэрэг асуудлыг хэмжиж үзсэн байна. Уг судалгааны хүрээнд 80 гарааны бизнес эрхлэгч, 10 инкубатор/бойжуулагч, хурдасгуур хөтөлбөр, инновацийн зангилаа төв, уулзалтын бүлэг, 9 их сургууль, технологийн коллеж, судалгааны байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийсэн ба тэд Монголын гарааны бизнесийн экосистемийн талаар гуравдагч талын мэдээлэл дутмаг байгааг тэмдэглэсэн байдаг. Үүний нэг шалтгаан нь сүүлд дурдсан "насны хувьд" залуу байгаа (гарааны бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувь нь 3 жил хүрэхгүй жилийн өмнө байгуулагдсан гэж мэдээлсэн) нь нөлөөлж байж болох юм. Энэ судалгааг хийхдээ шууд гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн оролцогч талуудаас мэдээлэл цуглуулсан.

<sup>141</sup> МТҮП, ‘Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн мэдээллийн технологийн инкубатор’ төслийн зорилтот салбарын үйл ажиллагааны удирдамж’.

<sup>142</sup> JICA, Kite, MMC, ‘Монголын гарааны бизнесийн экосистемийн сүүр судалгаа’ (Монгол улс, 2022.10.3), [https://www.jica.go.jp/mongolia/english/office/topics/gh13tc000000yef0-att/220413\\_02\\_en.pdf](https://www.jica.go.jp/mongolia/english/office/topics/gh13tc000000yef0-att/220413_02_en.pdf).

Судалгаанаас харахад, хэдийгээр шинээр үүсч байгаа боловч Монголын гарааны бизнес эрхлэгчдийн экосистем нь харьцангуй төрөлжсөн шинж чанартай (Зураг 42), үүнд орлогоор нь авч үзвэл санхүүгийн технологи (FinTech), AdTech (Зар сурталчилгааны технологи), Blockchain (Блокчэйн буюу бие даасан хэрэглэгчдийн сүлжээ хооронд цахим мэдээллийн сан үүсгэх болон хуваалцах боломжтой болгох мэдээллийн зохион байгуулалт), Боловсролын технологи (EdTech), Их тоон өгөгдөл, мэдээлэл (BigData) зэрэг чиглэлээр ажилладаг гарааны бизнес эрхлэгчид манлайлж байна.

**Зураг 42:** Монголын гарааны бизнес салбараар (давхардсан тоогоор), 2022 он (%)



Эх сурвалж: Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA)

Үүний зэрэгцээ Мэдээлэл, технологийн үндэсний паркийн бойжуулагчаас гаргасан статистик мэдээллээс үзэхэд, түүнтэй хамтран ажиллаж буй гарааны бизнес эрхлэгчид дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулжээ. Үүнд: Агуулгын хөгжүүлэлт – 58 хувь; Нийгмийн маркетинг – 23 хувь; Хэрэглээний программ хангамжийн хөгжүүлэлт – 10 хувь, Системийн хөгжүүлэлт – 9 хувь.

Монголын гарааны бизнес эрхлэгчид (давхардсан тоогоор) бизнесээс хэрэглэгч (B2C, 75 хувь), бизнесээс бизнес (B2B, 65 хувь), бизнесээс засгийн газарт (B2G, 18 хувь) чиглэсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна гэж мэдээлжээ. Тэдний зарим нь тодорхой гадаад зах зээл рүү (АНУ, Япон, Солонгос, Төв Ази, Филиппин) аль хэдийн хүрч чадсан, эсхүл хүрч ажиллахаар төлөвлөж байна. Үүний зэрэгцээ Монголын гарааны бизнес эрхлэгчдийн багахан хувьд нь л (10 хувь) албан ёсны үнэлгээ хийсэн байгаа тул тэдний үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэн зөв нарийвчлалтай тооцоход дэндүү эрт байгаа бололтой.

**Шигтгээ 4:** АНД Глобал ба СуперАп (AND Global ба SuperUp) хэмээх программ хангамж

Mongolian AND Global нь санхүүгийн болон өөр хувилбар бүхий санхүүгийн технологийн шийдлийг өөрийн бизнес болон өдөр тутмын амьдралдаа Санхүүгийн технологийг үйлчилгээ мэт ашигладаг (Fintech-as-a-Service) өмчийн эрх зүйн программ хангамжийг ашиглан (Хэрэглээний программчлалын интерфейс /API/-ийг болон бусад арга хэрэгслийг ашиглан) саадгүй уялдуулан нэгтгэх боломжийг үйлчлүүлэгчдээ олгодог технологийн дэвшилтэт, санхүүгийн технологийн компани юм. Одоогийн байдлаар тус компанийн санал болгож буй шийдлүүдэд цахим хэтэвч (e-wallet), цахим KYC (e-KYC), цахим арилжааны платформ, зээл олгох, онооны шийдлүүд байна. Тус компани нь 2016 онд Монголын анхны үүрэн гар утсанд суурилсан бичил зээлийн платформ байдлаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд одоогоор Монгол, Япон, Филиппин, Сингапур зэрэг улсад охин компаниудтай. Энэ нь Ази даяар илүү хурдан тэлэх урам зориг өгч байна. And Global компанийн амжилттай үйлчлүүлэгчдийн дунд Mongolian LendMN, SuperUP, ShoppuMN, Banana Mall, Mobicom болон бусад компаниуд байдаг.<sup>143</sup>

SuperUp аппликейшн нь түншийн хүрээний сүлжээнээс үр ашиг хүртэхийн зэрэгцээ бүгдийг нэг дор ашиглах боломжийг Монголын зах зээлд нэвтрүүлсэн. Энэхүү өдөр тутмын аппликейшн буюу хэрэглээний программ хангамж нь олон функц, онцлог шинж чанарыг нэг дор уялдуулан нэгтгэж, хэрэглэгчдэд өөр хэрэглээний программ хангамж татаж авахгүйгээр, хэрэгцээтэй бүх зүйлсээ олж авч нэвтрэх боломжийг олгодог. Энэхүү апп буюу хэрэглээний программ нь дотроо цахим арилжаа, хоол хүнс хүргэлтийн үйлчилгээнээс эхлээд даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээ, олон төрлийн жижиг хэмжээний хэрэглээний программуудыг агуулдаг тул, энэ нь үүрэн гар утасны санах ойг хэмнэж, олон талын арга туршлагыг хөнгөвчилж өгдөг учраас хэрэглэгчид энэ хэрэглээний программд үнэнч байх хандлагатай байдаг. SuperUp хэмээх хэрэглээний программын интегратор буюу нэтгэн уялдуулсан программын шийдэл нь хэрэглэгчдийн хувьд хэтэрхий олон сонголттой байгаад байдаг ханасан зах зээлд маш тохиромжтой байсан. SuperUp нь одоо байгаа зөвхөн нэг зорилготой хийгдсэн байдаг бусад апп буюу хэрэглээний программуудтай өрсөлдөхийн оронд, гуравдагч талын бизнесүүдтэй хамтран бүтээлцэж, сүлжээний түвшинд үр ашгийг хүртэхийн зэрэгцээ, экосистемийн дизайнер, чиглүүлэгч болж хөгжиж байна. SuperUp хэмээх хэрэглээний программ нь олон тооны өндөр давтамжийн гүйлгээнүүдийг хийж гүйцэтгэхийн тулд, AND Global хэмээх компанийн цахим хэтэвч (e-wallet), түүний дотор үнэнч хэрэглэгчдэд зориулсан шийдэл ба тоглоомд ашигладаг зарим шийдлүүдийг уялдуулан ашигласан байна. Нээлттэй Хэрэглээний программчлалын интерфейс (API)-тэй хамт боловсруулан бүтээсэн AND хэмээх цахим түрийвч нь (AND wallet) банкны данс, бусад цахим хэтэвч, банкны карт, зуулагчгүй буюу биржийн бус худалдааны (over the counter/OTC) сувгууд гэх мэт гуравдагч талын системтэй уялдуулан нэгтгэх чадвартай байдаг. Үүний үр дүнд хэрэглэгчид түрийвчиндээ мөнгө хийн цэнэглэж, хүссэн суваг руугаа мөнгө шилжүүлэх боломжтой болсон. Уг цахим хэтэвч нь мөн банкны төлбөрийн гарц замтай уялдуулан нэгтгэсэн байдаг тул, хэрэглэгчид ямар ч шимтгэлгүйгээр цахим түрийвч болон банкны данс хооронд мөнгө шилжүүлэх боломжтой.<sup>144</sup>

Эх сурвалж: AND Global болон AND Solutions

## 8.2. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан боломж ба санхүүжилтийн шинэ гарц

Монгол Улсын Инновацийн тухай хуулийн (2012) 12 дугаар зүйлд, инновацийн үйл ажиллагааг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж; мөн эргэн төлөгдөхгүй санхүүжилт; болон инновацийн грант зэргийг ашиглан дэмжиж болно гэж заасан байдаг. Үүнд цаашлаад дараах зүйлсийг хамруулан жагсаасан байдаг. Үүнд: улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө; Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгө; Засгийн газрын бусад тусгай сангийн хөрөнгө; хөрөнгө оруулалтын компанийн хөрөнгө; гарааны компанийн хөрөнгийн анхдагч зах зээлээс бүрдүүлсэн хөрөнгө; инновацийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын өөрийн хөрөнгө; гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив; мөн ийм хөрөнгийн эх үүсвэрүүдийн дунд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр хэмээн заажээ.

<sup>143</sup> AND Global, 'AND Global. Жинхэнэ Финтек компани', AND Global. Жинхэнэ финтек компани, 2022.12.15-нд хандсан, <http://www.and.global/>; AND Solutions, 'AND Solutions', And Solutions Pte. Ltd., 2022.12.15-нд хандсан, <https://andsolutions.net/company/>

<sup>144</sup> AND Solutions, "Супер программ цахим экосистемийг хэрхэн төгс болгосон бэ", And Solutions Pte. Ltd., 2022.12.15-нд хандсан, <https://andsolutions.net/use-cases/how-a-super-app-perfected-a-digital-ecosystem/>

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) -аас Монголын гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн талаар хийсэн судалгаанд, гарааны бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн хүртээмжтэй холбоотой томоохон бэрхшээл тулгарсан гэдгийг тодорхойлсон. Үүнд: нэлээд төрөлжсөн боловч хуваагдмал портфелийн хувьд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хэлбэр (гэр бүл, найз нөхдийн хандивыг оруулаад) нь үндсэн хөрөнгийн эх үүсвэр болж байгаа ба түүнээс гадна бизнесийн бусад орлого, зээл, түүнчлэн анжел хөрөнгө оруулагчид болон венчур капиталын хязгаарлагдмал хувь нэмэр (ихэвчлэн хурдасгуурын үе шатанд) болон бусад (Зураг 43).

**Зураг 43:** Монголын гарааны бизнес эрхлэгч нарт оруулсан анхны болон явцын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр 2022 он (%)




Эх сурвалж: Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)

Судалгааны үр дүнгээс харахад, тодорхой гарааны бизнесийн санхүүжилтийн портфельд мөнгөн болон бэлэн бус хэлбэр (оффисын байр, нийтийн үйлчилгээ, сурталчилгааны санхүүжилт гэх мэт) чухал байр эзэлдэг, төрийн санхүүжилт гэж шууд заагаагүй боловч (эсхүл төрийн болон хувийн санхүүжилт гэж ялган зааглаагүй) энэ нь хэрэг дээрээ зарим талаар ийм санхүүжилт байдаг ба зарцуулалтын хэмжээ хязгаарлагдмал тул бодит хүртээмж нь бага байна.

Судалгаанд оролцогчид, цахим арилжаа болон бусад технологийн/дигитал венчур бизнест хөрөнгө оруулахад хөрөнгө оруулалтын орчин таатай бус байгаа нь гарааны бизнест зориулах санхүүжилтэд гол саад болж байна гэж тодорхойлсон. Үүнийг дагаад санхүүжилтийн янз бүрийн хувилбарын талаарх

мэдлэг ойлголт дутмаг, цаашид гарааны бизнесийн санхүүжилтэд саад болж буй тодорхой хүндрэл бэрхшээлийг илүү нарийвчлан судлах шаардлагатай юм. ЖДҮ-ийн зориулалтын бүтээгдэхүүний олдоц муу байгаа талаар хувийн хэвшлийнхэн онцгойлон дурдсан. Оролцогч талууд Засгийн газрын дэмжлэгийг маш бага хэмжээтэй, энэ талын зохицуулалт бага гэдгийг, мөн хувийн хэвшлийнхэн гарааны бизнесийн системийг хөгжүүлэх доороос дээш чиглэсэн горимыг хэрэгжүүлэх талаар тэмдэглэн хэлжээ (Зураг 44).

**Зураг 44:** Санхүүжилтийн хүртээмжтэй холбоотой тэргүүлэх үйл ажиллагаа (%)  
(Судалгаанд оролцогчид: төрийн байгууллагын 91, хувийн хэвшлийн 23 )




- 1 Цахим арилжааны хөрөнгө оруулалтын таатай орчин (хөрөнгө оруулалтын боломжийн талаарх мэдлэг гэх мэт)
- 2 Санхүүжилтийн янз бүрийн хэлбэр, түүнийг хослуулах талаар мэдлэг бий болгох (жишээ нь, хөрөнгө оруулалтын санхүүжилт, хамтын санхүүжилт, зээл, тэтгэлэг, дансны улайлт, нэхэмжлэхийн санхүүжилт, лизинг, актив хөрөнгийн санхүүжилт)
- 3 Цахим арилжааны венчур бизнесийг санхүүжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг олж тодорхойлох
- 4 Бичил, ЖДҮ-д тусгайлан зориулсан санхүүгийн арга хэрэгсэл (зээл, урамшууллын хөтөлбөр гэх мэт)
- 5 Санхүүгийн эрсдэл, өгөөжийг хуваалцахад дөхөм болох төр, хувийн хэвшлийн хоорондын түншлэлд тохирсон бүтэц, тогтолцоо
- 6 Цахим арилжааны шийдлийг үйл ажиллагаандаа уялдуулан нэгтгэхийг эрэлхийлж буй бичил, ЖДҮ-ийн онцлог/сорилтуудын талаарх Банкны зээлийн эдийн засагч нарын мэдлэг.
- 7 Цахим арилжаанд зориулсан санхүүжилтийн хүртээмжтэй холбоотой асуудлаар үе тэнгийнхэн хамтран суралцах, харилцан туршлага хуваалцах
- 8 Цахим арилжааны шинэ гарааны бизнесийг эхлүүлэхийн тулд эздийн өмч/хувь нийлүүлсэн хөрөнгөд суурилсан санхүүжилтыг босгох байдлаар ашиглах венчур капитал
- 9 Чанаргүй зээл/төлбөр төлөх хугацаа хэтэрсэн зээлийг бууруулах механизмыг тодорхой болгох

Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Судалгаанд оролцогчид гуравдагч этгээдээс санхүүжилт авахгүй байгаа нь зээлийн хүү өндөр, боломжит хувилбарын талаар мэдээлэл дутмаг, барьцаа хөрөнгөгүй, өргөдөл гаргахад хүндрэлтэй зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалжээ. (Зураг 45).

**Зураг 45:** Гуравдагч талын санхүүжилт хайхгүй байх шалтгаан (%)  
(Хувийн хэвшлийн судалгаа, 22 оролцогч)



Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)

Хамгийн өргөн хэрэглэгддэг санхүүжилт болон хөндөгдсөн зарим асуудлыг доор дэлгэрэнгүй авч үзнэ.

### Программ хангамж хөгжүүлэх чиглэлийн инновацийг төрөөс санхүүжүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагын үүсгэсэн гарааны бизнес

Инновацийн тухай хууль (2012)-аар технологи дамжуулах төвийн гишүүнээр бүртгүүлсэн гарааны компани, эсхүл программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид төрөөс дэмжлэг үзүүлж болох ба дараах хэлбэрээр дэмжинэ. Үүнд:


- инновацийн төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх;
- инновацийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэх;
- инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох;
- төслийн нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсгийг инновацийн санхүүжүүлэгч байгууллага болон орон нутгийн төсвөөс бүцэлтгүй нөхцөлөөрсанхүүжүүлэх;
- өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүнийг олон улсын үзэсгэлэн худалдаа, танилцуулах арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлэх;
- экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн санхүүжүүлэх;
- дотоодод үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүнийг Засгийн газрын худалдан авах үйл ажиллагаагаар дэмжих;
- үзэсгэлэн худалдаа, хурал, семинар зохион байгуулах, инновацийн мэдлэг, соёлыг сурталчлах арга хэмжээг олон нийтийн байгууллагатай хамтран зохион байгуулах, санхүүжүүлэх;
- нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагнал олгох.

Инноваци ба эрдэм шинжилгээний байгууллага хоорондын уялдаа холбоог улам бүр бэхжүүлэхийн тулд инновацийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг компанид батлагдсан журмын дагуу таатай нөхцөлөөр төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх асуудлыг Засгийн газар авч үзэж болно. Үүнээс гадна, Инновацийн тухай хуулийн 27-

дугаар зүйлээр улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагыг үндэсний хэмжээний инновацийн үйл ажиллагаанд татан оролцуулах үндсэн тогтолцоог бий болгож, ялангуяа технологи дамжуулах үүрэг бүхий нэгж, гарааны компани (хөрөнгийн үнэлгээ хийгдсэн өдрөөс хойш таван жилийн дотор борлуулах), эх орондоо шинэлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй гарааны компанийг дэмжих онцгой зорилготой зөвлөх компанийн үндэс суурийг тавина. Эрдэм шинжилгээний байгууллага нь оюуны өмчөө гарааны компанийн дүрмийн санд оруулж болно. Мөн тус судалгааны байгууллагын харьяа гарааны байгууллагын орлого, зардлыг тусгай дансанд бүртгэж, тухайн эрдэм шинжилгээний байгууллагад ногдох ногдол ашгийн 75-аас доошгүй хувийг сургалт, судалгаа, технологийн туршилт, чиг баримжаа олгоход зарцуулна.

Инновацийн тухай хуульд заасан дэмжлэгийн арга хэмжээ нь ЖАЙКА-ийн гарааны экосистемийн судалгаанд оролцогчдын гаргасан хүслийн жагсаалттай ихээхэн давхцаж байгаа бололтой (Зураг 46). Гэвч хэрэгжилтийн байдлыг тогтоох боломжгүй байна. Дээр дурдсан санхүүжилт болон бусад дэмжлэгийн арга хэмжээний үр шимийг хүртэхийн тулд программ хангамж боловсруулах байгууллагыг хуульд заасан инновацийн дэд бүтцэд (шинжлэх ухааны парк, үйлдвэрлэлийн технологийн парк, технологи дамжуулах төв, технологийн инкубатор, бизнес инкубатор, хамтарсан оффис болон менежментийн компани) нэгтгэх шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна.

Зураг 46: Технологийн гарааны бизнест хамгийн их шаардлагатай санхүүжилтийн арга хэмжээ (%)



Эх сурвалж: Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)



## Өөрийгөө санхүүжүүлэх

Өөрийн санхүүжилтэд найдах нь Монголын технологийн гарааны бизнесийн эхэн үед ч, дараа нь ч санхүүжилтийн гол шийдэл хэвээр байна. Үүнд хувийн болон гэр бүлийн хуримтлал, албан бусаар бий болгосон найз нөхдийн санхүүгийн дэмжлэг, хувь үүсгэн байгуулагчдын тусгайлсан хуулийн дагуу байгуулагдсан хадгаламж зээлийн хоршооноос авсан хувийн зээл, эсхүл банк, "эх" корпорацийн бүлэг дэх бусад этгээдээс олгосон санхүүгийн дэмжлэг, улмаар бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлого орно. Монголын цахим арилжааны борлуулагчдын нэг Ard Shop<sup>145</sup> болон Intelmind venture studio -ийн үүсгэн байгуулж бойжуулсан инкубац болох цахим дэлгүүрийн (e-shopping) бизнесээс хэрэглэгчид чиглэсэн (B2C platform) Shoppy<sup>146</sup> платформ зэрэг голдуу гадаадын брэнд барааг Монголд борлуулах чиглэлээр мэргэшсэн зарим гарааны компаниуд бүлэг дотроо хүлээн авсан санхүүжилтийн найдвартай загварыг ашигласан гэж мэдээлж байна; Мэдээллийн технологийн Cody компани<sup>147</sup> нь өөрийн боловсруулсан цахим платформын шийдлийг түрээслэхээс гадна Монгол болон хилийн чанад дахь компанид холбогдох үйлчилгээг үзүүлдэг; Европ, Япон, АНУ-аас Монголд автомашины оригинал сэлбэг нийлүүлэх чиглэлээр мэргэшсэн хэрэглэгчээс хэрэглэгчид чиглэсэн (C2C) онлайн платформ болох Zary<sup>148</sup> болон AutoParts<sup>149</sup> цахим дэлгүүрүүд ажилладаг.

## Банкны зээл

Монголын арилжааны банкууд технологийн гарааны санхүүжилт болох хэд хэдэн төрлийн тогтмол зээл олгодог. Үүнд: тоног төхөөрөмж үл хөдлөх хөрөнгийг худалдан авахад чиглэсэн янз бүрийн хөрөнгө оруулалтын зээл, тухайлбал, ипотекийн зээл; эргэлтийн хөрөнгийн зээл; зээлийн шугам; санхүүгийн түрээсийн зохицуулалт г.м. Гэсэн хэдий ч жилд дунджаар 15-20 хувьтай өндөр зээлийн хүү, зээлийн үйл ажиллагааны шимтгэл, зээлийн харьцангуй богино хугацаа, барьцаа хөрөнгийн шаардлага, ихэвчлэн дор хаяж 6-12 сарын бизнесийн түүхийг харуулах шаардлага зэргээс ихэнх гарааны бизнес эрхлэгч ийм санхүүжилтэд тэнцэхгүй, ТЭЗҮ-ийн асуудлаас болж сонирхохгүй, эсхүл авах магадлал багатай болгодог. Энгийн барьцааны оронд авлагыг барьцаалсан тохиолдолд хэд хэдэн банкнаас санал болгож буй POS тоног төхөөрөмжийн орлогын баталгаатай зээл нь гарааны бизнес эрхлэгчдэд илүү сонирхолтой байж болохыг доороос харж болно.

Монголын хэд хэдэн банкнаас бизнесийн туршлагаа харуулах боломжтой бол картын гүйлгээний авлагын урьдчилгаа зээл олгох банкны POS төхөөрөмжийг ашиглан тодорхой хугацаанд (зургаан сар ба түүнээс дээш) төлбөрийн картын факторингийн богино болон дунд хугацааны зээл санал болгодог. Жилийн 13-20 хувийн өндөр хүүтэй байгаа ч богино хугацааны эргэлтийн хөрөнгөөр хангах, үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилготой энэхүү санхүүжилтийн шийдэл нь зээлийн эргэн төлөгдөх нөхцөлийг илүү уян хатан болгож, санхүүжилтийг хурдан шуурхай авах боломжийг олгодог бөгөөд ихэвчлэн авлага нь барьцаа болдог. Гэсэн хэдий ч түүний бодит хэрэглээ тодорхойгүй байна.

ЖДҮ гэж бүртгүүлсэн гарааны бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн олон сонголт бий. Эргэлтийн хөрөнгөөр хангахад чиглэсэн зээлийг гурван төрлөөр санал болгож байна. Үүнд: КОВИД-оос үүдэлтэй ЖДҮ-ийг дэмжих урамшууллын багцын нэг хэсэг болох гурван жилийн хугацаатай, Монголбанкны тусгайлсан зааврын дагуу жилийн 3 хувийн хүүгийн дээд хязгаартай олгох зээл;<sup>150</sup> Зээл олгогч банк болон хөгжлийн түнш (ЕСБХБ,<sup>151</sup> АХБ,<sup>152</sup> ГОУХАН-Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг)

<sup>145</sup> ArdShop, 'ArdShop', 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://ardshop.mn/>.

<sup>146</sup> Shoppy, 'Shoppy.Mn'.

<sup>147</sup> Cody, 'CODY.MN', 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://cody.mnundefined>.

<sup>148</sup> Zary, 'Zary.Mn', zary.mn - Дэлхийн Брэндүүд нэг дор, 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://zary.mn/>.

<sup>149</sup> Autoparts, 'Autoparts', 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://autoparts.mn/about-us>.

<sup>150</sup> Энэ төрлийн зээл олголт 2021 оны сүүлээр зогссон бололтой. Гэсэн хэдий ч олгосон банкуудын зээлийн багцад харагдах хандлагатай байна.

<sup>151</sup> ЕСБХБ, "Монголын ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих: тойм", 2022 оны 12-р сарын 15-нд хандсан, <https://www.ebrd.com/knowhow/mongolia/smedevelopment>.

<sup>152</sup> АХБ, 'АХБ, ХасБанк Монгол дахь ЖДҮ-ийг дэмжих хувийн секторын зээлэнд гарын үсэг зурлаа', Азийн хөгжлийн банк, 2019 оны 12 сарын 16, <https://www.adb.org/news/adb-xacbank-sign-private-sector-loan-support-msmes-mongolia>

эсхүл үндэсний Зээлийн батлан даалтын сан хамтран ивээн тэтгэх зээл; ЖДҮ-ийн бусад зориулалтын зээл, ихэвчлэн РЕПО (Дахин худалдан авалтын гэрээ) арилжаагаар санхүүждэг, эсхүл автомашин болон бусад хөдлөх эд хөрөнгө барьцаалах зэрэг барьцаа хөрөнгийн уян хатан нөхцөлтэй олгодог зээл. Зах зээл дээр байгаа эдгээр зээлийн ихэнх нь уул уурхайн бус салбарын хөгжлийг дэмжих зорилготой ба эдгээр зээлийн аль нь ч цахим арилжаа, технологийн компанид зориулагдаагүй болно. ЖДҮ-д зориулсан зээлийн ихэнх нь бизнесийн түүхийг шаарддаг ч зээлийн хүү бага, эсхүл барьцаа хөрөнгийн хөнгөлөлттэй байх хандлагатай тул анхлан зээлдэгчийн сонирхлыг илүү татдаг. Зарим багц нь өргөдөл гаргагчаас орон нутгийн ЖДҮ-ийн байгууллагаас дэмжлэг авах, эсхүл сургалт болон сургалтын хөтөлбөрт хамрагдахыг шаарддаг. Монгол Улсын ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг 2016 онд өөр өөр салбарт үнэлсний дараа Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ОУЭЗХАБ)-аас хэд хэдэн зөвлөмж гаргаж, хэрэгжилтэд нь 2019 онд хяналт тавьжээ.<sup>153</sup> Тухайлбал, Монгол Улсад: ЖДҮ-ийн талаарх үйлдэл холбоотой мэдээлэл боловсруулж, түгээх; ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас (ЖДҮХС) санал болгож буй бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх; Барьцаа хөрөнгийн шаардлагыг хөнгөвчлөх; Зээл авах өргөдөл гаргах захиргааны журмыг оновчтой болгох; Байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах зэрэг болно. Хэрэгжих шатандаа байгаа дээрх зөвлөмжүүд нь Монголын технологийн гарааны бизнес эрхлэгчдэд ч хамаатай.

Монголын хэд хэдэн банк эмэгтэйчүүдийн эзэмшдэг, эсхүл удирддаг бизнесийг дэмжих зорилгоор тусгайлан зээл олгодог. Эдгээр зээлийн заримыг банкууд болон гадаадын түншүүд, тухайлбал, Голомт банктэй хамтран ажиллаж байгаа, Dutch Lendahand social crowdfunding foundation<sup>154</sup> эсхүл ХХБ-тай хамтарсан Олон улсын хөрөнгө оруулалтын банк (ОУХОБ-ИВ)<sup>155</sup> ивээн тэтгэдэг.

### Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын зээл

Банкнаас гадна олон ББСБ зээл олгодог. Боломжит зээлийн төрлүүдийн хувьд ББСБ-ын санал нь банкныхтай төстэй харагдаж байна. СЗХ-ны мэдээгээр, 2020 онд нэг жил хүртэлх хугацаатай зээлийн (Финтекс-ийн гаргасан) 93.5 хувийг үүрэн телефоны зээлийн үйлчилгээгээр олгосон байна.<sup>156</sup> Ийм зээлийн ихэнхийг хувь (хэрэглэгч) зээлдүүлэгчид олгодог бол тодорхой хувийг нь ЖДҮ-ийн санхүүжилт болгон ашигладаг гэсэн мэдээлэл байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6.1-д зээл санал болгож буй аж ахуйн нэгж нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй. Ингэхдээ хөрөнгийн хүрэлцээ болон бусад зарим зохистой хэм хэмжээг дагаж мөрдөнө.

### Анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) зарчмаар санхүүжүүлэх

Анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) санхүүжилтийг Монголын гарааны бизнесийн өсөлтийн стратегид нэгтгэж эхэллээ. 2022 оны 9 дүгээр сард мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ "Сендли" компани хувьцааныхаа бараг 30 хувиар IPO зарлажээ<sup>157</sup> (хувьцааных нь 25 хувийг олон нийтэд, харин 75 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгосон). Энэхүү туршлагыг Сендлигийн харьяалагддаг MFG (Монголын финтех бүлэг)-ын бусад гишүүд дагаж мөрдөх төлөвтэй байна. Ялангуяа энэ HiPay-д хамаарна.

<sup>153</sup> ЭЗХАБ, 'Өрсөлдөх чадварын шинэчлэлд хяналт тавих: Монгол дахь аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмж' (Парис: OECD Publishing, 2020), <http://www.oecd.org/eurasia/competitiveness-programme/central-asia/Monitoring-Competitiveness-Reforms-Access-to-Finance-for-Firms-in-Mongolia-ENG.pdf>.

<sup>154</sup> Лендаханд', 2022 оны 12-р сарын 15-нд хандсан, <https://www.lendahand.com/nl-NL>.

<sup>155</sup> ИВ, 'Олон улсын хөрөнгө оруулалтын банк (ИВ)', 2022 оны 12-р сарын 15-нд хандсан, <https://iib.int/en>.

<sup>156</sup> СЗХ, 'Санхүүгийн зохицуулах хороо, [www.frc.mn](http://www.frc.mn), 2022 оны 12-р сарын 15-нд хандсан, <http://www.frc.mn>.

<sup>157</sup> Sendly, 'Sendly IPO', 2022 оны 12-р сарын 15-нд хандсан, <https://ipo.sendly.mn/>.

## Өрсөлдөөнөөр олж авсан санхүүжилт

Гарааны бизнесийн өрсөлдөөн нь Монголын хамгийн ирээдүйтэй гарааны бизнесийн үйл ажиллагааг хурдасгах боломж олгохоос гадна нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр болдог. Гэхдээ өрсөлдөөн ховор байдаг тул урьдчилан таамаглахуйц загвар гэж хараахан үзэх боломжгүй байна.

### Шигтгээ 5: Дэлхийн гарааны бизнесийн цом: Монгол улс (Startup World Cup Mongolia)

Startup World Cup бол дэлхий даяар жил бүр зохиогддог хамгийн том гарааны бизнесийн уралдааны нэг юм. Pegasus Tech Ventures-ийн үүсгэн байгуулсан 'Startup World Cup' баг орон нутгийн бүс нутгийн түншүүдтэй хамтран дэлхийн 50 гаруй бүс нутгаас хамгийн ирээдүйтэй гарааны бизнес эрхлэгчдийг (StartUps) хайж байна. 2021 онд тус уралдааны үндэсний хэсгийг Монголд анх виртуал байдлаар зохион байгуулж, хиймэл оюун ухаан, блокчэйн, крипто, AR/VR, дрон, цахим худалдаа зэрэг чиглэлээр хууль ёсны бүртгэлтэй, fintech, martech, edtech, insurtech зэрэг техникийн гарааны бизнес эрхлэгчдэд нээлттэй байлгасан. Технологийн тэргүүлэгч мэргэжилтнүүдээс бүрдсэн хороо Монголын уралдаанд амжилттай оролцсон хамгийн ирээдүйтэй 10 гарааны бизнес эрхлэгчдийг шалгаруулжээ. 'Startup World Cup 2021' Монголын бүсийн финалын ялагч Стартап Чимэг MCS Investment-ээс 100,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын шагнал хүртлээ. Хоёрдугаар байрт Tab Solution шалгарч 60,000,000 төгрөг, Эркс гуравдугаар байрт орж, 40,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт авсан. Хоёулаа Premium Group & Socratus Startup Studio-гийнх юм. OneFit нь IT Park буюу хоёр жилийн инкубаторын хөтөлбөрөөс тусгай шагнал хүртлээ.<sup>158</sup>

Эх сурвалж: Экспоненциал түншүүд

## Хамтын санхүүжилт

ЖДҮ-ийг бага өртөгтэй эх үүсвэрээр санхүүжүүлж хөгжүүлэхэд хамтын санхүүжилтийг хүлээн зөвшөөрсөн, мөн хуурамч компани, платформ үүссэний улмаас залилан мэхлэх эрсдэл өндөр байгааг харгалзан Монгол дахь хамтын санхүүжилтийн эрхзүйн орчны судалгааг Санхүүгийн зохицуулах хорооноос гүйцэтгэж байна.<sup>159</sup> Платформыг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох, тодорхой хугацаанд нэг удаагийн хөрөнгө оруулалтад хязгаар тавих, ил тод байдлыг хангах, дундын дансанд мөнгө хадгалах зэрэг зохицуулалт байж болох юм.

Дотоодын зах зээл дээр хамтын санхүүжилт албан ёсоор гарахыг хүлээж байх хооронд Монголд хааяа нэг хамтын санхүүжилт (заавал технологийн гарааны санхүүжилтийн зорилгоор биш) явагдаж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, гадаадын хамтын санхүүжилтийн компаниуд үе үе Монголын банкууд болон ББСБ-тай хамтран бизнес эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэхэд нь туслаж байна.

### Шигтгээ 6: Туслалцаа үзүүлэх нь (Lendahand)

Голландын Нийгмийн хамтын санхүүжилтийн сангийн (crowdfunding) Лэндаханд (Lendahand) нь Монгол дахь дотоодын түншүүд болох Голомт банк болон Инвескоре ББСБ-тай<sup>160</sup> хамтран “бичил санхүүгийн шалгуурт тэнцэхгүй том, харин банкнаас зээл авахад хэтэрхий бага” бизнес эрхлэгчдэд зээл олгохоор ажиллаж байна. Төлбөр хүлээн авагчид мөнгө зарцуулсны дараа хөрөнгө оруулагчдад зургаан сар тутамд ижил тэнцүү хэмжээгээр буцаан олгогддог бөгөөд мөн жилд дунджаар 3.5 хувь хүртэл тохиролцсон хүү байна. Уг зээлийг Улаанбаатар хот болон орон нутагт ЖДҮ эрхлэгчдэд олгодог. Эмэгтэйчүүдийн эзэмшдэг бизнеспүүд, өрх толгойлсон эцэг эх эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүсгэн байгуулсан ЖДҮ-үүд нийгмийн нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой.

Эх үүсвэр: Лэндэханд (Lendahand)

<sup>158</sup> Экспоненциал түншүүд, 'Гарааны бизнесийн Дэлхийн аварга Монгол улс 2021', Exponential Partners, 2022, <https://exponential.partners/swc2021/>.

<sup>159</sup> СЗХ, 'ҮЦХОУБ-аас хамтран санхүүжилт авах эрсдэлээс хамгаалах', www.Frc.Mn, 18 February 2019 оны 2-р сарын 18, <http://www.frc.mn/a/2797>.

<sup>160</sup> Invescore, 'Invescore NBF', 2022 оны 12 сарын 15-нд хандсан, <https://invescore.mn/mn/>

## Гадаадын салбар эсхүл охин компани байгуулах

Монголын технологийн компаниуд гадаад дахь салбар, тэр дундаа АНУ, Сингапурт байгуулсан салбар компаниараа дамжуулан хөрөнгө оруулалт татах чиглэлд ажиллаж байна. Ворлд Плас (World Plus) компанийн гүйцэтгэх захирлын хэлснээр, компанийг АНУ-д бүртгүүлснээр ТекКранч (TechCrunch), Кранчбэйс (Crunchbase) зэрэг технологийн платформууд өгөгдлийг боловсруулж, компанийн багцын болон ирээдүйн орлого зэрэг хөрөнгө оруулагчдад шаардлагатай найдвартай тооцоолол хийх боломж олгодог. Түүнчлэн АНУ-д байгуулсан компанид хөрөнгө хийх нь Монголд байгаа компанитай харьцуулахад ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд<sup>161</sup> илүү сайн хууль эрх зүйн баталгаа өгөх боломжтой. Компанийг гадаад зах зээлд таниулах хувийн сүлжээ нь түүний амжилтанд зайлшгүй шаардлагатай гэдгийг дурьдсан байдаг.

## Төр, хувийн түншлэлийн (PPP)-ийн санхүүжилт

